ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

# ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ






## Энэ дугаарт

1. Д.Оюунцэцэг
Гэр бүлийн эрх зүйн түүхэн сурвалжийн асуудалд
(1206 оноос эдүгээ хүртэх үе)

2. Ж.Бямбаа
Эрүүгийн шүүн шийдвэрлэх ажиллагааг нийгмийн шударга ёстой уялдуулах нь

3. Р.Оюунбадам
Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийн байдал, цаашдын чиг хандлага

4. Г.Амаржаргалан
Эрх, үүргийн бүтэц ба Иргэний хуулийн тэргүүн хууль

5. Ё.Болормаа
Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үүсдэг үү..., Үр дүнгийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсдэг үү... эсвэл...?

6. Б.Цэрэнчимэд
Хууль зүйн сэтгэл судлал ба нийгмийн хэрэгцээ, шаардлага

7. Л.Нарангэрэл
Хуулийн хэл

8. М.Түвшинжаргал
Олон нийтийн өмчлөлийн компани /GSOC/-ийн тухай ойлголт, АНУ-ын Аляска мужийн туршлага

9. Ч.Жадамба
Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, гадаад орны харьцуулалт

10. М.Хатанзориг
Үндсэн хуулийн цэцэд хүний субъектив эрхийг хамгаалах үүргийг боловсронгуй болгох нь

Мэдээлэл

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Д.Лүндээжанцан /эрхлэгч/
О.Амархүү /ерөнхий редактор/
Гишүүд: Ж.Болдбаатар
Ч.Энхбаатар
Н.Лүндэндорж
Б.Мандахбилэг
Ч.Жадамба /нарийн бичгийн дарга/

Редакцийн хаяг: Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Их сургуулийн гудамж,
Шихихутуг ХЗДС-ийн хичээлийн I байр

Web site: www.shihihutug.edu.mn
E-mail: shikhi_setguul@yahoo.com
Утас: 314977
320176



# ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН СУРВАЛЖИЙН АСУУДАЛД (1206 ОНООС ЭДҮГЭЭ ХҮРТЭЛХ ҮЕ)

Д.Оюунцэцэг
Шихихутуг ХЗДС-ийн захирал, дэд профессор

"Өрх гэр төр улсын үндэс", "Өрхөө засаад төрөө зас" гэх номлол, сургаал нь улс орны оршин тогтнохуй, соёл иргэншлийн хөгжил, хүмүүний төлөвшилд гэр бүл хэмээх гэрлэлт буюу цус махан төрөл дээр үндэслэсэн, гишүүд нь ахуйн амьдралын нийтлэг байдал төдийгүй амьдралын төлөө оюун санаа, бие махбодийн, эд хөрөнгийн нэгэн зорилгоор нэгдсэн нийгмийн анхдагч бичил бүлгийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсон Монгол арга ухааны илэрхийлэл юм.

Монголын туурга тусгаар төр улс, үндэстэн бүрэлдэн тогтнохоос аваад түүхийн бүхий л үед нийгмийн үндэс болсон гэр бүлийн асуудал төрийн бодлогод онцгой байр суурьтай байсаныг түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлджээ.

Тухайлбал А.Жувейнийн "Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх", Рашид-Ад-Диний "Судрын чуулган", Ж.Вернадскийн "Чингис Хааны их Яса (Засаг)-ийн судалгаа түүний агуулга", Сайшаалын "Чингис хааны товчоон" зэрэг бүтээлүүдэд чухамдаа "Монголын нууц товчоо" болон "Их Засаг" хуулинд гэр бүл болох ёс журам, гэр бүлийн бат бэх байдал, эр эмийн харилцааны үнэнч шударга журам, үр хүүхэддээ өмч хөрөнгө өвлүүлэх, гэрээслэх, асран хүмүүжүүлэх үүрэг зэрэг гэр бүлийн харилцааны асуудалд Монголчууд хэрхэн хандаж, яаж зохицуулж ирснийг бичиж тэмдэглэсэн нь цөөнгүй.

Тухайлбал: Монголын нууц товчоонд гэрлэх, сүй тавих, уг сүйг тавьсан хөвгүүн эхнэр болох эмэгтэйн гэрт очиж ямар хүн болохоо харуулах сорилт туулах, гэр бүлд эцэг хүн тэргүүлэгч байр суурьтай байх, гэр бүлийн гишүүн бүр тус тусын үүрэгтэй байх, үр хүүхэддээ насны дэс дараалаар өрх иргэн, өмч хөрөнгө хуваах, нэг эр олон эхнэртэй байх, охиноо нас гүйцмэгц сүлдэнд үзүүлэх, хүүхэд үрчлэн авах, хаан хатан охидоо ноёд ихэст эхнэр болгон өгөх зэрэг ёс журмын асуудал тодорхой тусгагдсан байдаг.[1]

Хамаг Монголын тэргүүн Есүхэй Хонгирад аймгийн толгойлогч Дай Сэцэнийд очиж 9 настай хүү Тэмүүжиндээ гэргий болгохоор Бөртэ охиныг нь гуйхад Дай Сэцэн өгүүлрүүн "Олон гуйлгаж өгвөл эрхэмлэгдэх, цөөн

[1]Монгол Улсын төр, эрх зүйн түүх. Тэргүүн боть. 353 дахь тал.

удаа гуйлгаж өгвөл доромжлогдох" гэдэг боловч охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөхгүй тул охиноо өгье. Чи хөвгүүнээ хүргэн болгож манай гэрт үлдээ гэхэд нь хөтөлж явсан морио бэлэглээд хөвгүүнээ үлдээн буцдаг.[2]

Хөвгүүнтэй айл түүндээ эхнэр гуйхдаа арав орчим настай байхад нь эхнэр болох охины гэрт очиж бэлэг сэлт өгөн, ёс журам гүйцэтгэн гуйж зөвшөөрлийг олонгуут хөвгүүнээ гэрт нь үлдээдэг заншил нэлээд өмнөөс уламжлагдсан буюу энэ нь хүргэн болох хүн эхнэр болох охинд ажил төрөл, авъяас билэг, зан төрхөө мэдүүлж дасах, харилцан суралцах, нэр төрөө хадгалан төлөвших нарийн үйл явцыг хамардаг агуулгатай ёсон байсан ажээ.[3]

Гэрлэх ёслолыг хурим хэмээн нэрлэн, нарийн ёс журам үйлддэг байсан авч ихэнхдээ заншлын хэм хэмжээг мөрддөг байжээ. Монголын нууц товчооны 168-р зүйлд "Багалзуур идэх" тухай өгүүлснийг академич Ц.Дамдинсүрэн авугай "Багалзуур ид" гэх нь эр, эм болох хурим хийх гэсэн үг биз хэмээн тайлжээ. "Багалзуур идэх" гэдэг нь хуримлах ёсны нэг хэсэг бөгөөд эр, эм бологсдын үйлдвэл зохих зан үйлийн нэгэн байжээ. Хүзүү, багалзуурын яс маш бат хэлхээтэй байдаг тул үүгээр эр, эмийн бат холбоог бэлэгдсэн байж болох жамтай юм.

Гэрлэлтийн харилцаанд мөрдөж байсан нэгэн өвөрмөц ёс бол инж өгөх явдал аж. Чингис хаан Ибага хатанд хандаж "Чиний эцэг Жаха-Хамбу" чамд инж болгон Ашиг төмөр, Алчиг хоёр тогоочийн хамт хоёр зуун хүнийг өгсөн билээ" (Монголын нууц товчоо. 1990 он. 184 дэх талд) гэснээс үзэхэд охиноо өгсөн эцэг бүхэн харъяат иргэд, мал, эд хөрөнгө өгдөг ёсон байсны нотолгоо болой. Гэр бүлийн гишүүдийн эзлэх байр суурь, эрх үүрэг, хоорондын харилцаа, өмч хөрөнгийн асуудал гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээний нэгэн чухал хэсэг байсан ажээ.

Монголын нууц товчоо болон "Их Засаг" хууль, бусад сурвалжаас үзэхэд нэгэн гэр бүлийн хүүхдүүдийг ахмад нь ахлах, ахмадаас эхлэн доошлох тутам эрх нь багасах замаар өрх, иргэд, өмч хөрөнгө хуваарилан олгох, хүүхэд нь эцгийнхээ, дүү нь ахын голомтыг өвлөх, хойт, урд гэрийн болон татвар эмийн хүүхдэд адил хувь хөрөнгө олгох, өргөмөл хүүхдэд өмч хөрөнгө хуваах, эцэг эх, ах дүү нар бие биеэ хүндэтгэх туслаж дэмжихэд чиглэж байсан ажгуу.[4]

Гэр бүлийн гишүүдэд ажил эрхлэх хуваарийг тогтоон мөрдөж байсан нь Монголын гэр бүлийн эрх зүйн онцлог шинж байсныг доктор, профессор И.Дашням түүхэн эх сурвалжуудад хийсэн судалгаандаа онцлон авч үзжээ. (354-355) Тухайлбал эрчүүд нь адуу малаа маллах, гаргах, нүүдэл суудал хийхээс эхлээд ан ав хийх, цэрэгт явж дайн тулалдаанд оролцох, эмс эхнэрүүд нь гэр зуурын ажлыг эрхлэн хувцас хунар оёх, сааль сүүгээ хийх, хоол ундаа бэлтгэх, үр хүүхдээ асрах, хүүхдийг гэр бүлийн аз жаргал хэмээн үзэж асран хүмүүжүүлж нүүдэлчин амьдралын жирийн нөхцөлд өлчир, тэсвэр

[2] Монголын нууц товчоо. УБ. 2004. 51; 46 дахь талд.
[3] И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. 353 дахь талд.
[4] И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. 354 дэх талд

тэвчээртэй, зориг шийдмэг чадалдаа тохирсон ажил хийлгэж, ажлын дортэй болгоход анхаардаг байжээ.

Гэрээ цэвэрлэх, үнсээ гаргах, аргал түлээ оруулахаас эхлээд хурга ишиг хариулах, унага тугал татах, мал саах, цагаан идээ бэлтгэх, мал хариулах, эмнэг сургах, нум сум агсаж тарвага, зурам агнах зэрэг нь хөвгүүд, охидод ногддог байжээ.

Рашид-Ад-Диний "Судрын чуулган"-д Эрчүүд ав хоморго, дайн тулаанд явахад гэргий нь зочин ирвээс цэвэр цэмцгэр дэг журмыг үзүүлэн, тансаг идээ бэлтгэх зочин гийчнийг хүндэлвээс эр нөхрийн нэрийг уулын оргил адил өндөртэй өргөмүү. Сайн эрийг сайн ханиар нь мэдмий. Тэнэг мулгуу ухаан бодол, ёс заншил муутай эхнэртэй бол нөхөр нь тэнэг болмой хэмээжээ. Мөн Сайшаалын "Чингис хааны товчоон" номонд хөвгүүд нь эцгийн сургаалыг үл авсан, дүү нар нь ахмадын ятгалгыг үл сонссон, эр нь гэргийгээ сэжиглэн, гэргий нь эрээ эсэргүүцсэн, хүүхэд багачуул нь ахас, ихэсийнхээ сургаалыг үл дагасан явдлыг Чингис хаан мууд тооцож хориглон зарлигдаж түүнээс сэрэмжлэхийг анхааруулж байсныг өгүүлжээ.

"Их Засаг" хуульд өв залгамжлах, тэтгэмж, тусламж үзүүлэх заалтууд байжээ. Өв залгамжлах заалтууд "Их Засаг"-т байсныг Жувейни, Рязановский, Дэндэв, Сайшаал нарын бүтээлүүд "Эзэн Богд Чингисийн Их Засаг", "Чингисийн төр, хууль цааз"-д өгүүлсэн байдаг. Сайшаал "Их түшмэд, ноёд, иргэд буюу ард иргэд үхсэн хойно тэдний эд хөрөнгө хэдий байсан болтугай хөндлөнгөөс нигэ, тэг гэж үл болох бөгөөд хэн ч энэ эд хөрөнгөд халдаж болохгүй, үхэгсдэд залгамжлах үр хөвгүүн үгүй болбоос эд хөрөнгийг нь түүний шавь буюу зарцад өгч болохоос биш улсын санд огт оруулж болохгүй" хэмээн бичжээ. Монголчуудын гэр бүлийн ёсонд хамгийн отгон хөвгүүнийг "галын эзэн, эцгийн гал голомтыг залга" хэмээн үзэж эцгийн нь амьдарч байсан гэр орныг өгч, эхтэй нь хамт өмч хөрөнгө хуваарилан олгож байсан нь өв хөрөнгө залгамжлах ёсонд хамаарах өвөрмөц зүйл болой.

Өв өвлөх тухай "Их Засаг" хууль дахь заалт нь нүүдэлчин Монголчуудын эрт дээр үеэс уламжилж ирсэн ахуй амьдрал, зан заншил, оюуны сэтгэлгээнд тулгуурлажээ.

Монголчуудын дунд өв залгамжлах хэмээх ойлголт суурьшмал орныхонтой харьцуулбал ихээхэн өвөрмөц агаад өргөн агуулга, учир шалтгаантай юм. Энэ нь эцэг дээдсийнхээ бэлчээр нутаг, өвөлжөө, хаваржаа, намаржааг бишрэн хүндэтгэж үе дамжин эзэмших, түүн дээр орших уул, ус, ургадаг ургамал, амьдардаг амьтдыг шүтэн хамгаалж, дээдлэн ашиглах, эцэг эх нь нас барахдаа хамгийн хайртай мал, эдлэл чимэглэл (зэмэг бөгж, гаанс, хөөрөг, эмээл хазаар, авдар сав, хувцас хэрэглэл, орон гэр г.м)-ийн зүйлсээ биеэр ба гэрээслэлээр өгөх, отгон хүү нь эцгийн гал голомтыг сахин үлдэж, нандигнан хамгаалаад дараагийн залгамжлагчиддаа өвлүүлэн үлдээх,

удам угсаагаа хүндэтгэн хамгаалж, үр хүүхэддээ мэдрүүлж цааш, цаашид үргэлжлүүлэх зэргээр илэрч байсан бөлгөө. [5]

Их Засаг болон Их Монгол Улсын үеийн хууль цаазын бусад эх сурвалжид гэр бүлийн бат бөхийн үндэс нь болсон эр, эмийн сэтгэлийн холбоо, үнэнч шударгыг сахих, хууран мэхлэх, садар самуунд автахыг үл тэвчих, эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон заалт, шаардлага цөөнгүй байдаг ажээ. Тухайлбал, "Их засаг"-т

- Эр хүн нь санааны зоргоор хэдий олон эхнэр авч болмой. Анхны гэргий нь эрхэм хүнд, онц эрхтэй байхыг туйлын зохистой явдал болгох бөгөөд энэхүү эрх хүндийг, түүнээс төрсөн үр хүүхэд хүртэл өргөттөмүй.
- Эцгээ нас барахад хөвгүүд нь түүний эхнэрүүдийн хувь заяаг шийдвэрлэнэ. Төрсөн эхээ оролцуулахгүйгээр эцгийнхээ бусад эхнэрийг авааль болгох буюу буслад өгч болно. Эгч, дүү хоёрыг эхнэр болгон авч болно.
- Алив хүн бусадтай явалцаныг гэрлэсэн эсэхийг ялгаварлахгүй цаазаар аваачмой гэх мэтээр заасныг жишээлэн хэлж болно. [6]

Түүнчлэн "Их Засаг"-т татвар эмээс гарсан хүүхдүүд хууль ёсоор гарсан хүүхдийн адил эрхтэй, зэрэг захирагч хийгээд цэргүүд хүчиндээ дулдуйдсан, шинэ дагасан аливаа хот, гацаанаа эмс хийгээд охидтой хүч түрэн гэрлэж болохгүй зэрэг хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан шинжтэй заалтууд байжээ. [7]

Ийнхүү Их Монгол Улсын үед ихэвчлэн уламжлалт зан заншлаар зохицуулагдаж ирсэн Монголчуудын гэрлэлт, гэр бүлийн харилцаа нь хуулийн зохицуулалтад орох үндэс тавигджээ. Энэ үед "Их Засаг" болон эрх зүйн бусад сурвалжид гэрлэгсэд, гэр бүлийн гишүүд, садан төрлийн харилцааг бие биеэ хүндэтгэж, асран халамжлах, удам судраа хайрлан хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, ихэс дээдсээ хүндэтгэх, гэр бүлийн нийгмийн өмнө хүлээх үүргийг тогтоох, өндөр хариуцлага хүлээдэг ёсыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байжээ.

Эзэн Богд Чингис хааны өрхөө засаад төрөө засах гүн ухаан, "Их Засаг"-ийн бат бэх өрх гэрийг төлөвшүүлэх үзэл санаа ийнхүү төрох, төрөө засах арга ухааны үнэт зүйл болон үлджээ.

Хубилай цэцэн хаан 1271 онд Бээжинг Монгол гүрний нийслэл хэмээн зарлаж, тэр ондоо Их Монгол Улсын төрийг Их Юан улс болгон өөрчлөв. Юан гүрэнд төр ёс гүнзгийрэн бэхжихийн дээр эрх зүйн хөгжил харьцангүй өндөр байжээ.

Гэвч "Монгол Улсын арван буянт номын цагаан түүх нэрт судар оршвой", 1262 онд Яо-Шугийн боловсруулсан "Ярьж эмхэтгэсэн хуулийн бичиг", "Их

[5] И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. 349-350 дахь тал.
[6] Ж.Болдбаатар, Д.Лундээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.2011. 90-91 дэх тал.
[7] Мөн тэнд үзнэ үү

Юаны нэвтэрхий хууль", "Ертөнцийг засах магад хууль" зэрэг Юан гүрний үеийн хууль цаазын сурвалжуудад эцэг, эхээ, ахас ихэсээ хүндлэх, үр хүүхдээ хүмүүжүүлэх, садар самууныг жигших зэрэг ёс заншлын зүйлүүдээс өөр Монгол гэр бүлийн харилцааны зохицуулалтын зүйл ховор байдаг.

Хубилай хаанаас эхлээд Юан гүрний хаад хууль тогтоолоо тэр дундаа гэр бүлийн харилцааг зохицуулахдаа юуны өмнө "Их Засаг" хуулийн зарчмыг суурь дэвсгэр болгож байжээ.[8]

Тухайлбал, Японы эрдэмтэн Таяма Сигеру Юан гүрний үед Чингисийн "Засаг хууль" нөлөөтэй хэвээр байж, уул хуулийн агуулгыг аман уламжлалын байдлаар Монгол нутгийн иргэд дотор дэлгэрүүлж ёс журмыг сахиулдаг байсан гэж бичсэн байдаг ажээ. [9]

Юан гүрний дараах буюу улс төрийн бутралын үеийн **(XIV-XVII** зуун) Монголын гэр бүлийн эрх зүйд мөн зан заншлын зэрэгцээ хуулийн зохицуулалтын зүйлүүд байжээ. "Их Засаг" хуулиас болон "Их Юан улсын хууль цаазын бичиг" (1271 он), "Ертөнцийг засах магад хууль" зэрэг Юан улсын хууль цаазын бичиг баримтаас өвлөсөн зүйл цөөнгүй ажээ. Тухайлбал, "Алтан хааны цаазын бичиг"-т эр, эм, гэр бүлийн харилцааны асуудлыг тодорхой тусгасан байдаг. Түмэн засагт хаан (1539-1592) Их цаазын үндсэн дээр Түмэдийн Алтан хаан (1507-1582) өөрийнхөө түмэнд мөрдүүлэх нэгэн тусгай цааз хууль зохион "Бага цааз" хэмээн нэрлэж байсан нь түүхнээ "Алтан хааны цааз бичиг" хэмээн нэрлэгдэн үлджээ. Уг цаазын бичигт эмс, охидыг эрд гарахад тэдний санал бодлыг хүндэтгэх, садар, самууныг үл тэвчих, бэр буулгах, гэр бүлийн доторхи хүчирхийллийг таслан зогсоох зэрэг харилцааг зохицуулж байжээ. Жирэмсэн эмийн ургийг унагаваас сарыг нь тоолон есөөр торгохоор заасан байхад, эр, эм самууран явалцваас долоон есөөр, тэр ч байтугай ор дэвсгэрээс нь татваас гурван есөөр торгож байжээ. Мөн эцэг эх нь охиноо элдэв аргаар эрд өгвөөс есөн есөөр торго, охин нь буцаж ирвээс цаазгүй", "цэвэр бага охиныг гутааж эцэг, эх нь хүргэнд барьж өгвөөс эцэг эх нь цаазтай".[10] Эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэн үзэх, гэр бүлийн хүчирхийллийг хориглох, садар самуун, үнэнч бусыг цээрлэхтэй холбогдсон эдгээр заалт нь онол, арга зүйн хувьд сонирхол татахуйц юм.

Улс төрийн бутралын гэгдэх үед зохиогдон мөрдөгдөж байсан "Хутугтай Сэцэн Хунтайжийн шашны цааз", "Эрхэмжийн бичиг" буюу "Үйсэн дээрхи бичиг", XVII зууны 40-өөд оны үед бүртгэгдсэн "Долоон хошууны Их Цааз" зэрэг улс төр, шашин, эрх зүйн сурвалжуудад нутаг ус эзэмших, эдлэх эрх, өвлөх өмчлөх эрхийн тухай охин богтлох, буулгах, буцаахад холбогдсон гэмт хэрэг зэрэг гэр бүлийн эрх зүйн зохицуулалттай холбогдсон зүйлүүд байдгийг академич Ш.Бира, Х.Пэрлээ гуай нар судлан тогтоожээ.

Тухайлбал, зургаан хошууны цаазнаа, гэрчгүй хуримыг (сүй) үрье. Гэрч болтугай. Хорь насалсан охиныг өөрийн ноён хүргэний ноёнд хүрч (сонсгож)

[8] Ж.Болдбаатар, Д.Лундээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.2011. 121 дэх тал
[9] Ж.Болдбаатар, Д.Лундээжанцан нар нэг татсаныг дам иш. 126 дахь тал
[10] Ж.Болдбаатар, Д.Лундээжанцан. "Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал". 146 дахь тал

өг хэмээсэн байх ба мичин жилийн (1620) их цаазад мөн тийм утгатай зүйл байдаг ажээ. [11]

Өгүүлж буй энэ үед гэрлэлтийн уламжлалт ёс журам зөрчигдөж, түүнтэй холбоотой гэмт хэрэг гарах болсноос улбаалан, төмөр гахай жилийн (1611 он) цаазад, ноёд хүний сүйтийг нь аваад, хүн өгвөөс тэр хүнээс анз аваад тэр эмийг хариулж буцааж өг. Усан үхэр жилийн (1613 он) их цаазанд, харц хүний сүйтийг хан хүн авбаас тэмээ, хуяг хоёрын нэгийг өг. Хан хүн хуримтай байтал авхайгаа хүнд өгвөөс тавин анз, таван бэрх ав. Хуримгүй бөгөөс өгсөн малыг нь хариулж өг гэх мэтээр заажээ. /Мөн тэнд үз./ /46,115/

Монголчуудын цааз эрхэмжийн хөгжлийн нэгэн бүхэл бүтэн үеийг төлөөлөн харуулах чадамжтай эрх зүйн нэг дурсгалт бичиг "Монгол-Ойрадын хууль"-д (1640 оны үед зохиогдсон) иргэний болон гэр бүлийн хуулийн олон чухал заалт байдаг ажээ. Онцгойлон авч үзвэл худ ураг болох, эцэг, эх, ах захаа хүндэтгэх, гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанаас үүдсэн зөрчлийг шийдвэрлэхэд чиглэсэн нэлээд өвөрмөц заалтууд оржээ. Жишээлбэл, аливаа хүн сургасан багшаа, эцгээ, эхээ нанчвал гурван ес ав, дундаас хоёр ес, багаас нэг ес ав" эцэг хөвгүүнээ ... бэрээ сурган нанчвал гайгүй, бургуугаар нанчвал ес ав" гэх мэт.

"Монгол-Ойрадын хууль" болон тухайн үед мөрдөж байсан бусад хуульд өв залгамжлалын зохицуулалтын талаар тодорхой заалт үгүй байсан ч Монголчууд хийгээд эзлэгдсэн зарим улс үндэстэнд "Их Засаг" хууль хүч нөлөөтэй үйлчилж, түүнд заасан өв залгамжлалын хэм хэмжээ мөрдөгдөж байсны зэрэгцээ эзлэгдсэн үндэстэнд өөрийн уламжлалт өвлөх ёс, дүрэмтэй түүнийгээ дагаж мөрдөж байсантай холбоотой юм. Өгөдэй хаан Чингисийн байгуулсан гүрэн улсын бодлого, "Их Засаг" хуулийг үеийн үед эргэлт буцалтгүй сахин биелүүлж байхыг бүх албат, иргэддээ журамт үүрэг болгосон бөгөөд дараагийн хаадууд ч үүрэг захиасыг биелүүлж байжээ.[12]

Манжийн эрхшээлийн үеийн иргэн, гэр бүлийн эрх зүйн гол баримт бичиг бол Монголчуудын өөрсдөө зохион боловсруулсан "Халх журам" мөн. Үүний сацуу тухайн цаг үед Манжийн эзэнт гүрний хэмжээнд үйлчлэх "Манж Чин Улсын Бүгд хууль", Монголыг баримтлан захирахад шууд зориулсан "Монгол цаазын бичиг, Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг" зэрэг үйлчилж байв.

Эдгээрээс "Халх журам" нь Монголын хууль цаазын нэн дурсгалт бичиг юм. Түүнийг тухайлан судалсан профессор С.Жалан-Аажав "Халх журам"-ыг Монгол хууль цаазын шилдэг буюу дээд нь" гэсэн нь бий.

"Халх журам"-ын гэрлэлт, гэр бүлийн харилцааг зохицуулсан заалтууд нь садар самууныг хориглон гэр бүлийг хамгаалж, бэхжүүлэхэд чиглэсэн шинжтэй байна. Ноёд, тавнангууд авай (охин) дээр авай нэмж авах, ноёд, ноёд зуураа сүй өгч авалцах, ноёд гурван хошууны зуураа харц хүний сүйг авах,

[11] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. "Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал". 153 дахь тал
[12] Т.Мөнхжаргал. Өв залгамжлалын эрх зүй. УБ.2009 он. 117 дахь тал

ноёд, ноёдын хатанд, ноён харц хүний эмд, харц хүн ноёны хатанд, харц хүн харцын эмд орох, хэн хүний сүйт охиныг сүйгүй гэж ноёнд худал хэлж өгөх, хан хүний охиныг харц сүйлэх зэргийг хуульд нарийвчлан заажээ. Эдгээрийг зөрчсөн этгээдийг малаар торгох, эд хөрөнгийг нь хураан авах, ангаар болон есөөр торгох, боолын боол болгох, цаазаар авах ял оноон шийтгэж байжээ. Ялангуяа садар самууныг онцлон жигшиж, "хөнжлийн захаас татваас гурван ест, эм хүн өвөрт орвоос гурван ест" /31,26/ торгож байсан аж.

Гэрлэлт, гэр бүлийн харилцаанд язгуур угсааны хамаарал хүчтэй тусч байсныг дараах заалтуудаас харж болно. Үүнд:

- Хан хүний охин авайг харц хүн сүйлэх бөгөөс (сүйлэн авбаас) цагаан тэмээ мөнгөн буйлтай, цагаан морь, булган молцогтой, мөнгөн аяга архиар дүүрсэн нүхгүй сувд эрдэнэ эдгээрээр сүйлсэнийг сүйд тооцно.

- Ноёд тавнангуудын охиныг гуйваас мөнгөн аяга, сувд, архи хүргэвээс (өгвөөс) тооцно.

- Харц хүн өөр зуураа сүйлэх бөгөөс (авбаас) архи болон хонины гэдэс дотор эвэр туурай гүйцэд болбоос тооцон гэх мэтээр заасан байна.[13]

Үүнээс үзэхэд "Халх журам"-д Чингисийн "Их Засаг" хуулийг иш үндэс болгосон зүйл цөөнгүй нь харагдаж байна.

"Халх журам" болон "Монгол цаазын бичиг", "Гадаад Монголын хууль зүйлийн бичиг" зэрэгт хөрөнгө эзэмших, ашиглах, хөрөнгө өвлөх зэрэг иргэний эрх зүйн зарим хэм хэмжээг тогтоох гэсэн заалтууд цөөнгүй байдаг. Тухайлбал, "Халх журам"-д ер ноёд үрдээ өмч өгөхдөө хаанд айлтгаж засгийн ноёндоо тэмдэглүүлж тамгалуул. Тэмдэггүй болоод заргалж булаацалдваас тод лацтай гэрч ба тэмдэггүй болох аваас үрийн (хүүхдүүдийн) амнаас хэлэх үг ба ийм билээ гэх буюу хүн эс хүссэн бол тооцолгүй (баримт болгож тооцож үл болохыг хэлж буй). Үр дор ялгаагүй тул бүгдэд мэдэгдэх, зөвт хүү бүгдэд мэдээлэх, буруут хүү хоёроос бусдад хуваан өгөх, булаацалдаж буй хүүхдүүдийн эх нь мэдтүгэй" гэх зэргээр өгүүлсэн байдаг ажээ.[14]

"Халх журам"-д "Үхсэн хүний эмийг ноёд өгвөөс тэр эм хөвгүүн хэд байвч хойт эртэй малаа хүн бүр хуваан аваад хүүхэд нь албандаа гартугай, ноёноос зарлиггүй аваас ташуураа барьж гартугай" гэсэн нь гэр бүлийн харилцаан дахь өв залгамжлалтай холбоотой заалт юм.

"Монгол цаазын бичиг" буюу "Хууль зүйн бичиг"-ийн 163-р зүйлд "харьяат монгол албат хөвгүүд, хуягууд нас нөгчөөд үргүй болбоос үүний үлсэн (үлдсэн), үр тасарсан гэр бараа хөрөнгийг ойр торлийн төрсөн өвгийн хөвгүүд, ач нарын дотроос салбарын ойр холыг бодож ялган салгаж хүлээн авагтун... хэрэв авах хүнгүй бол харьяат хошуунд өгч албанаар хэрэглэхэд бэлтгэгтүн..." 164-р зүйлд "... тайж нарын харьяат албат бие нөхцөөд үргүй бол ойр төрөлгүй, үхсэн гэрээ бараа хөрөнгө буй бөгөөс түүний уг эзэн нь

[13] Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть (1206-1910 он) УБ 2010 он. 147-148 дахь тал
[14] Т.Мөнхжаргал. Өв залгамжлалын эрх зүйн номын 119-д иш татсаныг авав.

язгуураас тайж агсан хойно байлгасан нь болбоос харъяат тайжид өгч хүлээн авагтун" гэжээ. (Монголын төр, эрх зүйн түүх. IV дэвтэр. УБ.,2008. 89 дэх талд)

**Олноо өргөгдсөн Монгол Улсын төр, эрх зүйн** онцлог нь тусгаар тогтнолоо дахин сэргээсэн Монголын төр, эрх зүйн салбарт зарим өөрчлөлт шинэчлэл хийн манжийн хууль цаазыг үе шаттайгаар хийж эхэлсэнтэй холбоотой юм. Гэхдээ энэ өөрчлөлт нь голдуу Монгол дахь Манжийн засаг захиргааг халан өөрчлөх, төрийн аппаратыг цэгцлэх, эдийн засаг, нийгмийн шинэ бодлого явуулахад чиглэгдэж байсан бөгөөд иргэний, тэр дундаа гэр бүлийн эрх зүйн асуудалд төдийлөн анхаарах цаг боломж бүрдээгүй байжээ. Иргэний болон гэр бүлийн эрх зүйн холбогдолтой гол сурвалж бол **"Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"** хэмээх 1915-1918 онд боловсруулан гаргасан хууль юм. Энэхүү хуульд гааль татвар, тариалан, гэр бүл бололцох зэрэг иргэний холбогдолтой зургаан дэвтэр (хууль бүхэлдээ 65 дэвтэртэй) ордог ажээ.

**Монгол Улсад Үндсэн хуульт, ардчилсан байгуулал тогтоохын төлөө тэмцлийн үе буюу 1924-1990-ээд** он хүртэлх үеийн гэр бүлийн эрх зүйн гол эх сурвалжид 1926-1929 онуудад хэсэгчлэн боловсруулж, 1929 онд эцэслэн батлагдаж 1952 он хүртэл дагаж мөрдсөн 10 бүлэг 217 зүйл бүхий Иргэний хууль орно. Өнөөгийн хэллэгээр багц энэхүү гэмээр энэхүү хуулинд 1926 оноос мөрдсөн "Аливаа өв хөрөнгийг залгамжлан эдлүүлэх тухай хууль" (2 бүлэг, 32 зүйлтэй) "Гэр бүлийн эрх, үүргийн тухай" 3-р бүлэг (28 зүйлтэй) ордог байна. Энэхүү хуулийг (БНМАУ-ын Иргэний хуулийн III бүлэг) гэр бүлийн хуулийн үндэс суурь гэж үзэх бүрэн үндэслэлтэй. [15]

Иргэний хуулийн 58 дугаар зүйлд: Эр, эм бололцох нь угсаа, шашин шүтлэг, лам хуврага гэж ялгаварлуулахгүйгээр 18 насанд хүрсэн хэн болович зөвхөн гэрлэгч эр, эм хоёр хүний санал нийлэлцсэнээр хэрэгжих тухай заасан нь гэрлэлтийн зарчмыг бэхжүүлж өгснийг харуулж байна. Ийнхүү гэрлэлтийн зарчим хуульчлагдсаны ач холбогдлыг тэмдэглэж, профессор И.Дашням бичихдээ: "... гэрлэлтийн харилцаанд урьд өмнө олон зуун жилээр мөрдөгдөж ирсэн тэгш бус зарчмыг халж, хүн төрөлхтөний амьдрал, аж төрөх ёсонд илүү дэвшилтэт, хүмүүнлэг ёсыг тогтооход чиглэж байснаараа ач холбогдолтой" гэжээ. Мөн зүйлд эр, эм бололцоход харшлах зүйлийг тодорхойлсны дотор гэрлэгчдийн аль нэг нь эхнэр буюу нөхөртэй байхыг хориглосон нь манай улсад нэг нөхөр, нэг эхнэртэй байх зарчмыг хуульчлан бэхжүүлсэн хэрэг мөн. Түүнчлэн төрөл садан хүмүүс гэрлэхийг хуулиар хориглосон нь хүн амын удмын санг цэвэр ариун байлгах ач холбогдолтой заалт юм.

Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээнүүдийг агуулсан дээрх хуулиар гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, эд хөрөнгийн харилцаа, гэрлэлт цуцлах үндэслэл, журам, гэр бүлийн бусад гишүүд, ойрын төрөл саднаа тэжээн

[15] Ж.Болдбаатар, Д.Лундээжанцан. "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал". 318 дахь талд

тэтгэх үүрэг, үрчлэлтийн журам, овог нэрийн бүртгэл зэрэг гэр бүлийн эрх зүйн асуудлууд ямар нэг хэмжээгээр тусгалаа олсон байна.

Дээрхээс үзвэл, өгүүлэн буй үед гэр бүлийн эрх зүйн үндэс суурь нэгэнт бүрэлдэн тогтсон гэж үзэх үндэслэлтэй.

1951 онд БНМАУ-ын Гэрлэлт, гэр бүлийн байдлыг бүртгэх хууль батлагдан мөрдөгдсөнөөс хойш 22 жилийн дараа буюу 1973 оны 4-р сарын 19-ний өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоолоор БНМАУ-ын Гэр бүлийн хуулийг баталж, мөн оны 10-р сарын 01-ээс эхлэн дагаж мөрджээ. Уг хууль нь оршил, 13 бүлэг, 113 зүйлтэй бөгөөд хуулийг дагаж мөрдөх журмын тухай зарлигийг мөн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс баталсныг дурдах хэрэгтэй юм.

Хуульд тухайн нийгмийн тогтолцооны үзэл сурталжсан байдал ч тусчээ. Тухайлбал, эл хуульд зааснаар БНМАУ-ын Гэр бүлийн хууль тогтоомж нь социалист гэр бүлийг бэхжүүлэх, гэр бүлийн харилцааг улам боловсронгуй болгох, гэр ахуйн харилцаанд эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах зорилготойг дурджээ. Түүнчлэн гэрлэх, гэрлэснээ цуцлуулахтай холбогдсон харилцаа, гэрлэгсэд эцэг эх, үр хүүхэд, гэр бүлийн бусад гишүүний хоорондох амины болон эд хөрөнгийн харилцаа, хүүхэд үрчлүүлэх, үрчлэн авах, иргэдийг асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон харилцаа, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбогдон үүссэн харилцааг тус тус зохицуулахаар хуулиид заажээ.

Хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Гэрлэгсэд гэрлэлтээ бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв гэрлэснээ бүртгүүлээгүй бол тэдгээрийн хооронд энэ хуульд заасан гэрлэгсдийн эрх, үүрэг үүсэхгүй, БНМАУ-ын Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагад бүртгүүлсэн гэрлэлт болон 1951 оноос өмнөх гэрлэлтийг хүчинтэйд тооцох, гэрлэгсэд хэрэв энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө гэрлэснээ нотолбол анх гэрлэсэн хугацаагаар гэрлэлтээ бүртгүүлэх эрхтэй болохыг чухалчлан заажээ.

1973 оны гэр бүлийн хууль нь гэрлэлт, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцааг хуулиар хамгаалж, гэр бүлийн доторхи эрх тэгш байдлыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн юм.

Зах зээлийн эдийн засагт шилжиж буй манай орны хувьд гэрлэлт, гэр бүлийн харилцаа ялангуяа гэрлэгсдийн эд хөрөнгийн асуудлаар нарийвчлан зохицуулсан Гэр бүлийн хуулийг шинээр баталж мөрдүүлэх зорилт тулгарч байна.

Улсын Их Хурлаас 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн баталж, 1973 онд батлан мөрдөж байсан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болгосон юм.

Шинэчлэн баталсан гэр бүлийн тухай хуулиар гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулав.

Гэрлэх нөхцлийг хуульд зааснаар харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харъяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно. Эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна. Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.

Мөн хуулиар гэрлэлт дуусгавар болсонд тооцох болон гэрлэлтийг цуцлах талаарх эрх зүйн ойлголтыг нарийвчлан тогтоож өгсөн юм. Тус улсад гэрлэлтийг захиргааны болон шүүхийн журмаар цуцална. Харин гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар зохицуулж байна.

Хуулиар (тавдугаар бүлэг) эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцааг зохицуулсан байна. Эцэг, эх болон хүүхдийн хооронд харилцаа үүсэх нөхцөл, түүнчлэн хүүхдийн эцэг, эхийг захиргааны, эсхүл шүүхийн журмаар тогтоох асуудлыг хуульчилжээ. Хүүхдээ хүмүүжүүлэхдээ эцэг, эх тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

1973 оны Гэр бүлийн тухай хуульд зөвхөн эцэг, эх байх эрхийг хасах тухай зохицуулалт байсан билээ. Харин 1999 оны хуулиар дээрх зохицуулалтаас гадна хүүхдийн эрх ашгийн үүднээс буюу хүүхэд төрсөн гэртээ өсөн хүмүүжих эрхтэй гэсэн заалтыг бэхжүүлжээ. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор эцэг, эх байх эрхийг 6 сараар хязгаарлах тухай зохицуулалт шинээр тусгасан байна.

Гэр бүлийн тухай хуулиар зохицуулж буй нэг гол харилцаа бол тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа юм. Хүүхдийн тэтгэлгийн хэмжээг хүүхдийн насны байдлаар нь харгалзан үзэж шүүхээс тогтоож байхаар хуульчилсан байна. Түүнчлэн тэтгэлгийг мөнгөн хэлбэрээр болон эд хөрөнгөөр олгож байхаар заажээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор түүний ашиг сонирхлын үүднээс хүүхдийг үрчлүүлэх асуудлыг тусгахдаа гадаадын иргэн Монгол Улсын харъяат хүүхэд үрчлэн авах тухай асуудлыг ч нарийвчлан хуульчилжээ.

Товч дүгнэлт

1. Монголчууд зуун зууныг улираан мал сүргээ маллаж байгаль эхээ шүтэн газар ус, ургамал амьтныг хайрлан хамгаалж амьдрахдаа ихэс дээдэс, эцэг эх, эмэгтэйчүүд, хүүхдүүдээ хүндэтгэн бие биеэ хайрлан асран дэмжих, удам судар угсаа гарвалаа хадгалан хамгаалах зэрэг гэр бүлийн нандин харилцаатай ард түмэн юм.

Гэр бүлийн энэхүү нандин харилцааг, зан заншил болон хууль цаазаар зохицуулж гэр бүл болохыг ёслол төгөлдөр үйлдэж гэр бүлийг бат суурьтай, төрийн өмнө чанд хариуцлага хүлээдэг ёсыг төлөвшүүлж иржээ. Монголчууд хэзээнээс эр, эмийн ёсонд үнэнч шударгыг эрхэмлэдэг, садар самууныг үл тэвчдэг, гэр бүлийн гишүүдийн нас хүйс зэрэгтэй холбоо бүхий хөдөлмөрийн нарийн хуваарьтай байсан, байгаль цаг уурын хатуу ширүүнд бөрви бөхисхийдэггүй хөдөлмөрч зан чанар нь үр хүүхдээ өсвөр багаас нь ажилсаг, тэсвэр тэвчээргэй ёс жудагтай иргэн болгон төлөвшүүлэх үндэс нь болж иржээ. Монголчуудын өв залгамжлах нь мөн ёс журам төгс ажгуу. Энэ нь гэр бүлийн харилцаанд онцгой ач холбогдолтой байжээ.

Гэр бүлийн харилцааны эдгээр асуудал Монголчуудын уламжлалт заншилд үндэслэгдэж байв.

2. Монголчуудын гэр бүлийн харилцааны нандин уламжлал, зан заншил болон эзэн богд Чингис хааны гэрээ засаад төрөө засах гүн ухаанд суурилсан "Их Засаг" хууль нь агуулга нь үлэмж баян, төр улс, иргэний амьдралын бүх хүрээг хамарсан Монголын төр улсын цаашдын хувь заяанд ихэд нөлөөлж балрашгүй ул мөрөө үлдээсэн хууль цаазын хосгүй үнэт эх сурвалж юм. Их Засаг хууль Монголын гэр бүлийн эрх зүйн хуулийн зохицуулалтын үндсийг тавьсан төдийгүй түүний үзэл санаа нь Монголын төр улсын буурал түүхийн бүх үеийн хууль цаазын эх сурвалжууд: Их Монгол Улсын хаадын хууль, зарлиг цаазууд, Юан гүрний "Монгол Улсын арван цагаан буянт номын цагаан түүх оршвой", "Их Юан нэвтэрхий хууль", дараа үеийн "Монгол-Ойрадын хууль", "Халх журам", "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг" зэрэг хууль цаазын эх сурвалжууд болон "Ардын Засгийн үеийн иргэний болон гэр бүлийн хуулиудад шингэж эрх зүйн нэг үндсэн эх сурвалж нь болж иржээ. Даяаршил, ардчиллын эринд "Их Засаг" хуулийн байгаль эхээ, удам судар, угсаа гарвалаа хайрлан хамгаалах, ахас ихэсээ хүндлэх, залуу хойч үеэ эх оронч ухамсар, хөдөлмөрч хичээнгүйд сурган хүмүүжүүлэх, эмэгтэйчүүд, хүүхдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих, гэр бүлийн ариун үнэнч ёс журмыг чандлан сахих, садар самууныг үл тэвчих, бусадтай эе эвийг хичээн амьдрах зарчим үзэл санааны ач холбогдол хадгалагдсаар байна.

3. Манай улс зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжин хувийн өмч хүний эрх, эрх чөлөөний гол баталгаа болж Монгол Улсын иргэн, гэр бүлийн амьдрал, харилцаанд өмч хөрөнгө эзэмших, өв залгамжлуулах асуудал чухал байр суурьтай болж байна. Гэрлэлт, гэр бүл, гэрлэлтийн гэрээ зэрэг хууль эрх зүйн ойлголтуудын мөн чанар, ялгаа, зөрүүг нарийвчлан тогтоох шаардлага тавигдаж байна. Улс орнуудын нийгмийн амдралын харилцан нөлөөлөл, хамаарал ихэсч, хүмүүнлэгийн харилцаа өргөжин тэлж буй нөхцөлд бусад улс орны иргэнтэй гэр бүлийн харилцаа тогтоох, үр хүүхэд үрчлэх, өмч хөрөнгийн харилцааг зохицуулах асуудлыг гэр бүлийн тухай хуулинд шинээр авч үзэх ч шаардлагатай. Түүнчлэн гадаадын зарим

оронд ижил хүйстнүүдийн гэр бүл болох, "хамтран амьдрагчид"-ийн харилцааны асуудал тавигдаж хуулийн зохицуулалтад орж буйг ч анхааран судлах хэрэгтэй байна. Энэ бүхэн нь Гэр бүлийн хуулийн зохицуулалтыг шинээр, цогц байдлаар авч үзэх нөхцлийг бүрдүүлж байна.



# ЭРҮҮГИЙН ШҮҮН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ НИЙГМИЙН ШУДАРГА ЁСТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

Ж.Бямбаа
/Шихихутуг ХЗДС-ийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор/

Шударга ёс нийгмийн амьдралын хүрээнд тулгуур хэм хэмжээ болон үйлчилсэн цагт хэнд ч болов амьдралынхаа утга учрыг ухаарч, зөвхөн чин ариун эрмэлзэл, шударга хөдөлмөрөөрөө өмч хөрөнгөтэй, хангалуун амьдралтай болж чадна, үнэн хэзээд ч, ямар ч тохиолдолд ялна, ухаалаг нийгэм, төр түүнд үйлчилнэ гэсэн өөдрөг үзэл бодол, итгэл үнэмшил бүрэлддэг бөгөөд, ингэснээрээ бодгаль хүний авьяас билэг, хичээл зүтгэл, урам зориг нь идэвхжиж улс эх орны хөгжин дэвших үндэс суурь нь тавигдаж ирээдүй нь улам өөдлөн тодордог жамтай.

Чухам ийм учраас шударга ёсны шаардлага эрх зүйн агуулгын гол бүрэлдэхүүн хэсэг, хуулийг хэрэгжүүлж хэрэглэх үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болж байдаг юм.[1]

Шударга ёсны тухай ойлголт олон талтай өргөн ухагдахуун учраас нийгмийн шинжлэх ухааны янз бүрийн салбарт, тухайлбал, гүн ухаан, ёс суртахуун, эдийн засаг, хууль эрх зүйн хүрээнд өөр өөрсдийн үзэл онолын үүднээс өвөрмөц онцлог өнгө аястайгаар тайлбарлагддаг боловч үндсэн санаа, чиглэл нь хаана, ямар ч тохиолдолд утга агуулга, мөн чанараараа тун төстэй нь ажиглагддаг.

Эртний философичид **нийгмийн дотоод зөрчлийг арилгах үндэс нь шударга** ёс гэж үзэн бөгөөд тэрхүү онол сургаал нь ухаантан мэргэдийн зохиол бүтээлд тусгалаа олсон байдаг. Сократ үзэхдээ: "шударга ёс гэдэг нь бие хүний ёс суртахууныг тодорхойлогч бөгөөд зан суртахууны оршил болсон шударга ёсны зарчим нь хуулиар илэрч байх ёстой. Ингэсэн цагт хуулийн нөлөө нь тун их"[2] хэмээжээ.

Шударга болон хууль ёсны зарчим нь мөн чанарын хувьд хоорондоо тун төсөөтэй гэсэн үзлийг Платон, Аристотель нар дэмжиж байв. Тэд "шударга ёсны үзэл баримтлал амьдралын аль ч салбарт адил хүчин чадалтай хэрэгжих эрхийг жам ёсны гэнэ. Энэ эрх нь ямар ч нийгэмд, аль ч төрд үйлчилдэг. Мөн шударга ёсыг хэрэгжүүлэгч нь эрх зүй юм". Хууль нь бүх нийтээр дагаж

[1] СН. Филимонов В.Д. Справедливость как принцип права., Ж. Государство и право. 2009г. Мос. Ст5-13
[2] Учение древних мыслителей М., 1994 Том 1. Стр-16-20

мөрдөгдөн чанд сахигдах ёстой. Үүний тулд албадлага хэрэглэх үе ч бий[3] хэмээн сургаж байв.

Хүний нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу Монгол оронд шударга ёсны тухай суут хүмүүсийн сургааль бодитойгоор хэрэгжих, биелэлээ олох боломж бүрдлээ. Харамсалтай нь түүнийг хэрэгжүүлэхэд нийгмийн ухамсрын түвшин, эрүүл саруул сэтгэлгээ, ур ухаан, хүмүүжил, ёс суртахууны хэр хэмжээ сүрхий дутагдсаар байна.

Төр, эрх зүйн сургаалийн түүх, олон улсын өнөөгийн практикт нийтлэг хүлээн зөвшөөрсөн онол арга зүйн үүднээс авч үзэхэд **засаглалыг**[4] хуульчлан зохицуулах, гүйцэтгэн захирамжлах, шүүн таслах гэсэн үндсэн гурван хэсэгт ангилан хувааж энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь тус тусдаа харьцангуй бие даан өөр өөрсдийн онцлог үүрэг зорилтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ нэг нь нөгөөдөө хяналт тавьж харилцан үйлчилж байж эрх мэдлийн тэгш үйл ажиллагаа, тэнцвэржлийг хангадаг ажээ.

Энэ гурван бүрэлдэхүүн хэсгийн аль нэгний үйл ажиллагаа нь нөгөөгөө орлох юм уу бүдгэрүүлвэл тулгуур хуулиа хүртэл үл дээдлэх өвчинд автана.

Гэтэл манайд төрийн байгууллагуудын эрх мэдлээ хэрэгжүүлж буй өнөөгийн практикаас үзвэл хуульчлан зохицуулах ба гүйцэтгэх засаглалын эрх үүрэг роль хэт өргөмжит атлаа, шүүн шийдвэрлэх үйл ажиллагааны ач холбогдлыг өрөөсгөлөөр ойлгож даран номхруулах аль эсвэл элдэв арга замаар нөлөөлдөө авах гэсэн эрмэлзэл хандлага сүрхий ажиглагдлаг.

Чухам ийм л үед аливаа зарга маргааныг зөвхөн шүүх эцэслэн шийдвэрлэдэг байх, зөв буруут гагцхүү шүүн таслах журмаар тогтоох, хуулийн өмнө бүгд тэгш байх, шүүгч асуудлыг хэний ч нөлөөнд авталгүй зөвхөн хуульд захирагдан шийдвэрлэх эрхэм шударга зарчмууд зөрчигдөж, шүүхийн зайлшгүй байх хяналтаас гадуур онцгой эрх дарх эдлэх гэсэн оролдлого гаарч тэр нь эцэс дүндээ элдэв хэлбэрээр биелэлээ олдогоос засаглалын нэг чухал салаа мөчрийн нэр хүнд үүрэг роль буурч, шүүх зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хэдэн хүнд прокурор, цагдаагийнхны амаар ял оноодог юм уу, эсвэл хэрүүл маргаанд өртсөн цөөн тооны бүтэлгүй этгээдүүдийн очдог хүсмээргүй нэгэн газар болоход хүрээд байна гэхэд хэтрүүлэг болохгүй биз.

Энэ бол шүүхийн утга учрыг таних, түүнд хандах мөн чанарт гарч байгаа гажуудлын илрэл монголын улс төрийн <u>"онол, бодлогыг тодорхойлогчдын"</u> зарим болчимгүй үйл ажиллагаа, ноцтой алдаа дутагдлын үр дүн гэж хэлэхэд огтхон ч хилсдэхгүй.

Зүй нь шүүх үл бүтэх хүмүүсийн дуудагдаж очдог газар биш, үнэн шударгыг эрхэмлэн хүндэтгэдэг бүх хүний өөрөө хүсэж ирдэг ариун үнэний

---

[3] Танаж. Стр 57-58, 62-64

[4] **Засаглал** гэдэг үгийн нэрийн ч үйлийн ч утгаар хэрэглэхэд хүрэлцээтгүй байтал "засаглал" гэж мөрдүүлэн ашигуурлуулах хэрэг юун" гэж доктор, профессор Б.Чимэд онцлон тэмдэглэснийг анхаарна уу? Б.Чимэд.Улс төр өнөөгийн хуульчийн нүдээр УБ.2006 он. 204 дэх тал

хүрээлэн, ардчилсан засаглалын нэгэн гол цөм байх учиртайг хэн хүнгүй мэдрэх учиртай.

Жон.Френкийн хэлснээр "шүүхээс айх хэрэггүй, харин түүгээр дамжуулж, түүний тусламжтайгаар элдэв худал хуурмаг явдал дураараа аашлах үзэгдэл, хүнд суртал, зальмэхтэй булт олноороо шийдвэртэй тэмцэх хэрэгтэй".[5]

Шүүхийн нийгмийн төрөлх зориулалт ийм бөгөөд тэр шинжээрээ засаглалын төдийгүй нийгмийн хүрээнд хүндтэй байр суурь эзэлж хууль ардчилал, шударга ёс, хүний эрхийн төлөө тэмцлийн индэр байх зүй тогтолтой юм.

Эрх зүйн системийн шинэчлэлийн дотор шүүхийн байр суурийг төр засаглалын системд зохих ёсоор эзлүүлж түүний ролийг дээшлүүлэх явдал одоо ч тэргүүн зэргийн ач холбогдлоо агуулсан хэвээр байна.

Энэ нь өнөөгийн бодит шаардлагаас урган гарч буйг эрдэмтэд нотолж "шүүх эрх зүйн системийн төв хэсэг, сайн шүүх-улс гүрний нэр хүндийн асуудал", "шударга шүүн таслах ажиллагаа бол төрийн тулгын чулуу" гэж бичиж байна.[6]

Үнэхээр ийм байх хувь тавилантайд бид эргэлзэхгүй байгаа бөгөөд чухам төр, эрх зүйн хүрээнд шүүхийн системд явагдсаар байгаа манай шинэчлэлийн нэг гол хандлага нь түүнд бүрэн чиглэгдэх ёстой.

Нийгмийн шударга ёсны нийтээр дагаж хүндэлдэг зарчмын нэг нь гэм буруутай зүйл хийсэн хэн боловч тохирсон ял шийтгэлээ зайлшгүй хүлээх зүй ёсны шаардлага юм.

Шударга ёсны энэ журам тус улсын хууль тогтоомжинд тод томруун тусгалаа олж хэрэгжихэд нэлээн цаг хугацаа, эр зориг шаардахнээ. Ялангуяа, хууль цаазны хариуцлагын төрлүүд, тухайлбал, эрүүгийн, захиргааны, сахилгын, иргэний хариуцлагын тухай хуулиуд заалт янз бүрээр нэрлэгдсэн ч агуулга, мөн чанараараа энэ зарчмын утга агуулгыг бүрнээ илэрхийлж байх учиртай.

Тэгэхдээ бид хуульд заасан хариуцлага, ял шийтгэлийн ерөнхий хэмжээнд л багтаж байгаа тэр бүхэн заавал шударга байна гэж туйлшруулан үзэж боломгүй.

Учир нь **нэгдүгээрт:**

Хуулийн зарим заалт нийгмийн шударга ёсны олон талт нарийн утга учир шаардлагатай зөрчилдөж болно. Эрх зүйн аль ч тогтолцоонд шударга ёсыг ганцхүү нарийвчлан заасан эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулна гэсэн ойлголт байж таарахгүй. Тиймээс аливаа хэрэг маргааныг хуульчлан

[5]Ардчилал гэж юу вэ? Сэтгүүл. Энерегтикийн мэдээллийн агентлаг.1994.хуудас 13

[6]Оросын Холбооны Улсын академич М.В.Кудрявцев Правовые гарантии свободы. М.,1997. стр.19, Доктор. проф.Б.Чимэд "Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлал" Шүүх эрх мэдлийн шинэ зуун" эмхэтгэл. УБ.2001. 46-48 дахь тал

шийдвэрлэхдээ эрх бүхий субъектэд, ялангуяа шүүх засаглалынханд эрх мэдлээс гадна нийгмийн шударга ёсыг чанд дээдлэх өргөн боломж олгох шаардлага улам бүр өсөж байна.

Жишээлбэл, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлд заасан "Ял хөнгөрүүлэх нөхцөл байдлууд" нь мөн хуулийн тусгай ангийн зүйл, заалтуудаар оноосон хөнгөрүүлэх авч үзэх тодорхой тохиолдолд л жинхэнэ утгаараа үйлчлэх хүч чадал бүрдэнэ. Түүнээс биш "дээрээс" тогтоох "логорифмны таблиц" шиг ялын дээд доод хэмжээг тулгасан зүйл заалтууд л заавалчгүй үйлчлэх ёстой хэмээвээс **"ял хөнгөрүүлэх хуульчлагдсан нөхцөл байдлууд"**-ыг ухаалагаар хэрэглэх мөн чанар, утга агуулга алдагдаж таарна.

Хуулийн хэм хэмжээний шийтгэл, хариуцлагыг тодорхойлсон хэсэг нь нэлээд тохиолдолд /Эрүүгийн хуулиар жишээ авъя/ нэгэн гэмт хэргийн төлөө хорих, албадан ажил хийлгэх, торгох ялын аль нэгийг оноох боломж бүхий, бас эд хөрөнгө хураах, тодорхой ажил эрхлэх эрхийг нь хасах нэмэгдэл ял хэрэглэхээр заасан байна гэж үзье.

Ийм сонгох ялтай үед дээрх "хөнгөрүүлэх нөхцөл байдлууд"-ыг цогц ухаалагаар хэрэглэж чадваас холбогдох зүйл заалт ямар ч "дарамт шалгуурыг" даван гарах амьд үйлчлэл үзүүлж чадна.

**Хоёрдугаарт:**

Зарим зарга маргааныг хянаж үзэхэд уг асуудлыг яаж шийдэх тухай ямар ч хууль тогтоомжинд заагаагүй байх тохиолдол бий. Энэ нь эрүүгийнхээс бусад процесс ажиллагаанд цөөнгүй тохиолддог.

Тэгэхлээр эрхийн хэм хэмжээний заалт зөрчилтэй байх үед яах вэ? Хуулийн зүйл ангийн энэ олон сонгох шийдлийн чухам алиныг нь ямар хэмжээгээр оногдуулах вэ? гэсэн нарийн төвөгтэй, ээдрээтэй асуудлууд тулгарна. Чухам тийм үед л шүүгчийн мэргэн ухаан, амьдралын туршлага, "оновчтой жишиглэл", эрх зүйн мэргэшсэн ухамсар[7] чухал үүрэг гүйцэтгэнэ.

Зөрчилтэй ч гэсэн хуулийн заалт зөв гэх юм уу, хуульд хэрхэхийг заагаагүй учир тухайн маргааныг шийдэхгүй орхих хэрэгтэй хэмээж туйлширсан хандлагыг шүүгч гаргах учиргүй.

Чухамдаа эдгээр ээдрээтэй асуудалд зөв хариулт өгөхийн тулд нийгмийн шударга ёсны зарчим, эрх зүйн мэргэшсэн ухамсарын үүднээс эргэцүүлэн тунгааж дотоод итгэлийнхээ зөв шийдэлд хүрэх шаардлагатай болно.

Аливаа маргаантай асуудлыг ялган тунгаахдаа тухайн тодорхой тохиолдолд л үнэн мөн шударга ёсыг тогтоож тунхаглах нь хууль зүйг хэрэглэж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрхэм нандин чанар мөн бөгөөд энэ нь хууль ёс, шударга ёс хоёр адил ойлголт биш боловч шийтгэл, зэмлэл,

---

[7]Профессиональное правосознание юристов. Под. ред.Г.В.Мальцева, В.книге. Политико-правовые учение А.О.Н М.1989г кол. авторов.

эрх үүргийн асуудлыг практикт шийдэхэд хоорондоо байнга нөхцөлдөх зүй тогтлыг харуулж байдаг юм. Зөвхөн шударга шийдвэр л хууль ёсны байх бөгөөд аливаа шударга бус зүйл хууль ёсны байх ямар ч аргагүй билээ.[8] гэж эрдэмтэн, судлаачид үздэг аж.

Иймд хууль, шүүхийн байгууллага аль нэг асуудал, зарга маргааныг хууль зүйн үндсэн дээр шийдэхдээ тэр нь шударга ёсонд хэр нийцэж байна вэ гэдгийг ямагт нягтлан цэгнэх учиртай.

Шударга ёс гэдэг бэлэн зохиосон жор биш улс төр, эдийн засаг, ёс суртахуун, гоо зүй, нийгмийн зэрэг үдэмж өргөн олон утга агуулгатай гүн гүнзгий ухагдахуун гэдгийг нэгэнт онцолсон билээ.

Тийм ч учраас шударга ёсны тухай ойлголтыг аливаа нэгэн улс төрийн хүчин, хэн нэгэн "гэнэт тодорсон" онцгой авьяастан "зөвхөн бурханаас түүнд заясан" мэтээр өмчлөн авч өөрийн дураар тайлбарлаж огт таарахгүй.

Хууль хэрэглэж асуудлыг шийдна гэдэг нь үнэхээр олон талын мэдлэг оюун ухаан, амьдралын туршлага, нягт нямбай ажиллагаа, бүтээлч сэтгэлгээний үр дүн.

Шийтгэл зэмлэлийн бодлого шударга ёсонд хэр нийцэж байна гэдгийн гол шалгуур нь хэргийн учир оноож буй ял шийтгэл, хийсэн гэмт үйлдлийн нийгмийн аюул, иргэд олон нийтэд учирсан хор хохирлын хэр хэмжээ, шинж чанар болон тухайн гэмт этгээдийн хувийн байдалд яг тохирч байх цогц үзүүлэлт.

Чухам энэ л хууль цаазны хариуцлагын гол утга учир бөгөөд буруу муу зүйл хийсэн хүн тохирох цээрлэлээ заавал хүлээх ёстой гэсэн шударга ёсны үзэл санаатай дүйж байгаагийн илрэл юм. Ямар шийтгэл оноовол гэмт этгээдийг цаашид засаж хүмүүжүүлэхэд илүү үр нөлөөтэй вэ гэдэг асуудал хууль цаазын хариуцлага хүлээлгэхэд ярианхгүй харгалзах зүйл мөн боловч шийдвэрлэх ач холбогдол бүхий үндэслэл биш, дагалдах үзүүлэлтэнд тооцогдох учиртай.

Иймч учраас шүүх засаглалыг хэрэгжүүлэхдээ хуульчдад жигшүүртэй муухай гэмт хэрэг үйлдсэн улс орны хөрөнгө мөнгө, байгалийн баялагийг гадна дотныхонтой элдэв хорон аргаар хуйвалдан завшигчид, банк, санхүүг сүйрүүлэгчид, татвар, хураамжаас удаа дараагийн ноцтой гэмт үйлдлээр зайлсхийхийн зэрэгцээ авилга, хээл хахуулийн "түймэр асаагчид" газрын наймаачдыг яагаад эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, өршөөл үзүүлэх оролдлого засаглалын янз бүрийн түвшинд байнга хийгээд байна? Ямар учраас онц жигшүүртэй хэрэг өдүүлсэн этгээдийг ялын бодлого тодорхойлогчид өөгшүүлэн өрөвдөөд байгаад нийгмийн өргөн давхарга жигшин зэвүүцэлгийг эс тоомсорлож хэрхэвч болмооргүй юм.

[8]Муральян Э.М. Социальное действие и резонанс судебного решения. Гос и право 1995.
Х.Тэмүүжин "Шударга шүүх хэмээхийн учир" "Эрх зүй" сэтгүүл. 2003.№8-9. тал 52 дахь тал
Академич С.Нарангэрэл "Ёс суртахууны хуулиар хамгаал" "Хуульч" сэтгүүл 2015. №02. 20-21 дэх тал

Түүнийг чухамдаа нийгмийн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхийг шаардаж буй олон түмний зүй ёсны хүсэл эрмэлзэл гэж хүлээж авах ёстой.

Үнэхээр ч муухай хэрэг хийсэн хүн яаж халхавчлагдсан ч хатуу цээрлэл хүргэх ёстой бөгөөд шударга ёс гэдэг оюун санааны талаас авч үзвэл зөвхөн энэрч өрөвдөх биш, бас жигшин зэвүүцэхийн мөн чанарыг агуулж байдаг юм.

Шударга ёс нийгмийн сэтгэл зүйн нэгэн өвөрмөц ойлголт, категорийн хувьд хууль зүйн хариуцлагын шударга эсэхийн тухай асуудал нь олон нийт ард иргэдийн нийтлэг үзэл бодлыг харгалзан үзэхээс өөр аргагүй зүйл.

Ийм учир манай нийгэм, олон түмний эрх ашиг сонирхолд жинхэнээсээ нийцэж буй тэр л зүйл шударга гэж үнэлэгдэх учиртай.

Үүнийг өнгөц ойлгож тодорхой хэрэг, асуудлыг шүүх шийдэхэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэгэх нь зөв, ингэх нь зүйтэй гэж яаж шийтгэх талаар санал хэлэх нэрийдлээр шүүхийг дарамтлахыг оролдох, эсвэл аль нэгэн улс төрийн төлөөлөл, хүчин хэн нэгэн "их мэдэгч" шүүхийг хараан зүхэж, шүүгчдийг тэнэг, мулгуу хоцрогдсоноор нь дуудаж нийгэмд онцгойрон тодорч ардын баатар болох гэсэн оролдлоготой адилтгаж таарахгүй.

Ингэхийг эрх зүйн соёлтой аль ч оронд цээрлэдэг. Ер нь нийгэм хичнээн ардчилсан ил тод байлаа гэхэд шүүх шийдвэл зохих тодорхой асуудлыг олон нийт урьдчилан шийдвэрлэх юм уу, шийдсэн хойно нь хэсэг, бүлгийн журмаар, аль эсхүл засаглалын өндөрлөгүүдээс болон "ард түмний шүүхээр" буруу зөрүүг зааж "хянаж үзэх, өөрчлөн зөвтгөх" тухай элдэв явуулга байх учиргүй.

Энэ бол зөвхөн хуульд захирагдан аль нэг нөлөө дарамтаас ангид үйл ажиллагаагаа явуулдаг эрх зүйт төрийн нэг гол шинж, шударга ёсны үндсэн шалгуур мөнөөс мөн.

Шударга ёсыг хэлбэрэлтгүй биелүүлэх шаардлагатай уялдуулан шүүн таслах ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг бодитойгоор хэрэгжүүлэх явдал ихээхэн чухалчлагдаж байна.

Тиймээс ОХУ, ХБНГУ-ын зарим эрдэмтдийн Англо-Саксоны эрх зүйн тогтолцоон дахь мэтгэлцээнийг зохицуулсан арга хэлбэрүүдийг Ром-Германы гэгдэх орнуудад жишиглэн хэрэглэж болох тухай сүүлийн үед гарч буй саналууд анхаарал татаж эхэллээ.[9]

Шүүх хуралдааны хэлэлцүүлэг маань хэрэг дээрээ урьдчилан бэлтгэсэн хавтаст хэрэг, яллах дүгнэлт, яллагдагчаар татах тогтоолын хүрээнд явагдан явцуурсаар байна. Эх газрын эрх зүйн тогтолцоонд талуудыг ялангуяа өмгөөлөх талыг мэтгэлцээнд идэвхтэй оролцуулах бүхий л арга хэлбэрийг

[9]Б.Шюнеман. Монгол Улсын ЭБШ хуульд өгсөн шинжлэх ухааны тайлбар. 2003 он УБ., 46-48 дахь тал. Дэлхий дахинд америкийн процесс давамгайлж чадах уу: өгүүлэл. Хууль зүйн бодлогоос, шинжлэх ухааны тулгамдсан асуудал. УБ. 2010. 39-45 дахь тал.

улам боловсронгуй болгох шаардлага тун их байна. Мэтгэлцэх зарчмыг бодитой хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө:

- Шүүхийн өмнөх бүхий л шатанд процессын баталгааг бодитойгоор хангаж бүхий л нөхцлийг бүрдүүлэх.
- Хуралдааны үед мөрдөн байцаалтын дутууг гүйцээхийн тулд яллах, өмгөөлөх чиг үүргийг шүүх дангаараа эрхлэхээс татгалзах.
- Яллах тал эрх үүргээ биелүүлэхээс зайлсхийж, мэтгэлцээнд оролцохгүй байх тохиолдолд шүүх түүнийг үл орлох.
- Шүүгчдийн гэм буруут нотлуулахаар шүүх санаачлан нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах зэргээс юуны урьд татгалзах нь зүйтэй.

Мэдээж ийм өөрчлөлтүүд нь манай өнөөгийн эрх зүйн ухамсар, сэтгэлгээ, практикт тийм амар хоногшихгүй.[10]

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлд заасан "хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох" тухай заалтыг эрүүгийн хэргийн мөрдөн мөшгих, хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хэлбэрэлтгүй мөрдөж бүрнээ хэрэгжүүлэх ёстой.

Аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэдэг, засаглалын мөн чанар шинж төрхийг гагцхүү бодит үнэнийг олж тогтоодог "онцгой арга, тусгай хэрэгсэл" шүүхэд байдаг мэтээр гэм буруут хэт хялбарчилан эцэслэхийг хичээвээс мөрдөн байцаалтын шатанд гарч ирсэн элдэв эргэлзээтэй асуудлыг шүүхэд "тулган өгөх" зохисгүй хандлага улам нэмэгдэж онцгой чиг үүрэгтэй, энэхүү байгууллагыг "зуудаг нохойд барьдаг мод" мэт ашиглах алдаа завхрал лавшрахад хүрнэ гэдгийг анхаарах нь зүйтэй.

Энд онцлоход эцэслэн шийдвэрлэдэг утга агуулгаараа аль ч оронд анхан шатны шүүх нь бүр анхан шатны журмаар шийтгэх, цагаатгах тогтоолоо улсынхаа аль эсхүл ард түмний нэрийн өмнөөс гаргадаг юм.

Давах болон хяналтын шатны ажиллагаанууд заавал явагдах ёстой үе шатууд ч бас биш. Гэхдээ тэдгээр нь хүний эрх, эрх чөлөө түүний дотор давж заалдах эрхийн Үндсэн хуулийн баталгаа, байцаан шийдвэрлэх процессын дотоод хяналтын механизм, алдаа дутагдлаа цаг алдалгүй залруулах арга зам, шударга ёсны биелэл болж өгдөг билээ.

Давж заалдах болон хяналтын шатны ажиллагаа нь барууны зарим оронд байгаа "Апелляци", "Кассаци" гэсэн хоёр хэлбэртэй ерөнхийдөө тосоотэй.[11]

Харин түүнийг манай оронд шууд буулган хэрэглэхэд бэрхшээл үүсгэж сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй тал бас бий. Жишээлбэл, манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа нэг талыг хэт барьсан буюу гүйцэт биш хийсэн

[10] Уголовный процесс М.МГУ.2001 под ред Гуценко К.В стр 350
[11] Хууль зүйн тайлбар толь Г.Совд нар УБ. 2003 он 143 дахь тал

/ЭБШХуулийн 318 дугаар зүйл/ эцэслэн шийдвэрлэх тогтоолд дурьдсан зүйл нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй /ЭБШХуулийн 319 дугаар зүйл/ тухай буюу "бодит" хэмээн нэрлэгддэг нотолгоотой холбоотой үндэслэлээр манайдаа хамгийн мэргэшсэн туршлагатай Улсын Дээд Шүүх хяналтын ажиллагаа явуулах боломжгүй болгон хязгаарласан бөгөөд харин шүүх бүрэлдэхүүнээр тогтоол гаргасан, зөвлөлдөх тасалгаанд болсон шүүгчдийн зөвлөлгөөний нууц задруулсан, тогтоолд шүүгчдийн хэн нэг нь гарын үсэг зураагүй, хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл байгаагүй /ЭБШХуулийн 320.8 дугаар зүйлийн холбогдох заалтууд/ зэрэг нэн тодорхой "техникийн" гэмээр ялимгүй асуудлыг Дээд шүүх хянах болсон нь амьдрал практикт ач холбогдол, үр нөлөө багатай тун сонин зохицуулалт болсон гэж манай практикт ажилтнууд шүүмжилдэг нь үнэний хувьтай.

Гэхдээ хуулийн өнөөгийн энэхүү зориулалт нь янз бүрийн шатны шүүхүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, хүнд суртал чирэгдлийг шахаж арилгах бүхий л нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн гэдгийг үгүйсгэж үл болно. Түүнээс гадна Улсын Дээд Шүүхээс анхан шатны болон давах шатны шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах боломжийг орхигдуулахгүй, тэгэхдээ шүүхийн захиргааны зохист үйл ажиллагаатай уялдуулан бүхий л ухаалаг нөхцөл боломжийг ашиглаж байх шаардлагатай.

Эрүүгийн хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруут тогтоох ажиллагаа нь хэд хэдэн үе шат туулан нягтлагдсан үнэхээр цогц шинжийг агуулдаг. Хүний халдашгүй чөлөөт байдал, эрхэмсэг оршихуйн үүднээс төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны "урьдчилан тогтоосон" гэм буруут мадаггүй үнэн гэхгүй бөгөөд гагцхүү ЭБШ ардчилсан зарчмуудыг удирдлага болгон хэргийг олон талаас нь бүрэн, бодитойгоор шүүн тунгаасны дараа эцсийн шийдвэр гаргадаг юм.

Гэхдээ ЭБШ ажиллагааны үе шат болгонд бусад оролцогчдын эрх, ашиг сонирхлыг ямагт анхаарч хамгаалах учиртай. Чингэвээс Эрүүгийн мөрдөн мөшгилтийн тухай өнөөгийн хийсвэр сэтгэлгээнээс ангижирч[12] энэхүү цогц процесс шүүх таслах ажиллагаатай улам бүр уялдаж хүний эрх, эрх чөлөөг дээдлэн баталгаажуулж, хууль ёсоо чандлан сахих ариун үйлсэд чанарын дэвшил гарцаагүй гарах төдийгүй, шударга ёсны зарчим жинхэнэ утгаараа хэрэгжих болно.

[12] Монгол улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх. Профессор Н.Лүндэндорж нар. УБ. 2010. 74-75 дахь талууд.



# ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Р.Оюунбадам
/Монгол улсын гавъяат хуульч,
Хууль зүйн ухааны доктор, Ph.D/

XXI зуун гарснаас хойш шилжилтийн болон зөрчилдөөний дараах үеийг туулж буй олон оронд эрүүгийн хууль тогтоомжийг шинээр гаргах, ялын оновчтой бодлогыг эрэлхийлэх зэргээр эрх зүйн шинэтгэлийн орчныг бүрдүүлэх үйл явц идэвхтэй өрнөх болсон билээ. Хүний эрхийн үнэт зүйлсийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах шаардлага өсөн нэмэгдэж, үндэсний болон олон улсын эрх зүйн уялдаа холбоо улам гүнзгийрэх тусам гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдсэн эрх зүйн нийтлэг зарчим, стандарт нөхцлүүдийг НҮБ-ын түвшинд хүлээн зөвшөөрөх хандлага бий болж байна. Монгол улсын эрүүгийн хуулийг шинэчлэх шаардлага өсөн нэмэгдэж,үүнийг дагаад ял эдлүүлэх эрх зүйн зарчим, хэм хэмжээг боловсронгуй болгох явдал өнөөгийн тулгамдсан асуудал болж байна. Үүнтэй холбогдуулан саяхан "Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар хуулийн байгууллагуудын нэгдсэн хэлэлцүүлэг" болов. Монгол улсын 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж эхэлснээс хойш шүүхээс оногдуулсан нийт ялын дотор хорих ялын эзлэх хувийн жин жилд дунджаар 76.5 хувийг эзэлж, ялын бодлогод хүмүүнлэгийн зарчим багагүй алдагдаж ирснээс гадна хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн 47 хувь дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байна.Үндсэндээ шүүхээр ял шийтгүүлсэн 4 хүний 3 нь хорих ялаар шийтгүүлж байна.[1] Иргэд олон нийт хууль зөрчих нь буруу ч гэлээ юм л бол барьж хориод байх нь тэдний гэр бүл, хүүхдэд болон нийгэмд маш их хохирол, гомдол, харуусал дагуулсаар байгааг хүчтэй шүүмжлэх болжээ. Ер нь гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт хорих ял тэр дундаа олон жилийн хорих ял оногдуулах нь улсад ч хувь хүнд ч ар гэрийн хүмүүсийн ч эдийн засгийн маш их хор хохиролтойн дээр нь хорих газраас суллагдсан хойно нь нийгэмшүүлэх гэж нүсэр ажил болох нь мэдээж юм. Хорих газраас суллагдсан хүн нийгмийн амьдралд дасан зохицох, цаашид өөрийгөө болон гэр бүлийн амьдралаа аваад явах итгэл найдвар зарим талаараа баталгаа муутай байдаг.

Сүүлийн 10 жилийн судалгаанаас харахад богино хугацаатай хорих ялын оногдуулалт буурч 10 буюу түүнээс дээш жилийн хорих ялтай хүний

[1] Хуулийн байгууллагуудын нэгдсэн хэлэлцүүлэг дээр прокурорын илтгэлээс 2014-02-26

тоо өссөн. Ялангуяа хорих ял эдлэж буй эмэгтэйчүүд нийт хоригдлын 38.5 хувийг эдлэж байгаа ба 15-25 хүртэл жилийн хорих ялтай эмэгтэйчүүд 5-6 хувийг эзлэж байна. Ийнхүү олон жилийн хорих ял эдлээд суллагдсан хүний хөдөлмөрийн чадвар суларсан, мэргэжил мэдлэг хоцрогдсон, нас нь хөгширсөн байх нь бодит үнэн. Хорихоос суллагдсан хүнийг ажилд авах сонирхолгүй. Тэдгээр хүмүүсийг ялтай байсан гэсэн мөнхийн хар сүүдэр дагалддаг гэх мэтээр хорих ялын хууль зүйн үр дагаврыг тоочоод байвал мундахгүй ихийг хэлж болно. Бүр цаашлаад тэдгээр хүмүүсийг нийгмийн халамжинд хамруулах чиг хандлага байгаа нь нөгөө л хавтгайрсан халамжийг нэмэгдүүлж, эдийн засагт муугаар нөлөөлөх нь мэдээжийн асуудал юм.

Иймд шүүхээс хорих ял оногдуулалтыг аль болохоор багасгах, хорихоос өөр төрлийн ял оногдуулахыг нэмэгдүүлэх боломжийг эрж хайх, гадны орнуудын хууль тогтоомжийг судлах шаардлагатай байна.

2007 онд гаргасан "Дэлхийн эрүүгийн загвар хууль" нь зөрчилдөөний болон шилжилтийн дараах орнуудын хувьд үлгэр загвар болохуйц чухал эх сурвалж болсноороо дэлхий дахины баримт бичиг болсон билээ. Загвар хуулийн үзэл баримтлал, зарчмууд нь Монгол улсын хувьд онцгой ач холбогдолтой гэж үзээр байна.

Тэгвэл монгол улс төрт ёсны уламжлалт хууль цаазтай орон гэдгээ мартах учиргүй. Өмнөх үеийн хууль цаазын уламжлал нь илүү ухаалаг, илүү өвөрмөц, илүү зөөлөн ялангуяа гэмт хэрэг хийсэн хүнийг ахуйгаар нь өөрчлөх бодлоготой байсан юм. Тухайлбал Их засаг хууль, Алтан хааны цааз, Монгол ойрдын хууль, Халх журам, Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг зэрэг уламжлалт хууль цаазуудад хэрэг үйлдсэн хүнийг шийтгэх олон янзын арга хэрэглэж байсан ба түүнээс заримыг дурьдвал: Зэрэг тушаал бууруулах, олны өмнө ичээх, хөрөнгийг нь хураах, тангараг өргүүлэх, хоньтоор торгох, морь үхэр авах, түлээ түүлгэх, гороо эргүүлэх, боол болгох, пүнлүү хасах[2] гэх мэт ял шийтгэлийг өргөнөөр хэрэглэж байжээ. Монгол улсын үндэсний ардчилсан хувьсгалын дараах үеийн 1926, 1929 оны шүүх цаазын бичгээс 1986 оны эрүүгийн хууль хүртэл эрүүгийн төрөлжсөн хуулиас судлан үзвэл, хорихоос өөр төрлийн ялын төрлийг илүү өргөн хэрэглэж байсан бөгөөд тэдгээр нь: торгох, эд хөрөнгө хураах, аливаа эрхүүдийг бүрэн буюу заримыг тодорхой хугацаагаар эсхүл бүр мөсөн хасах, донгодох буюу олон нийтийн өмнө буруушаах, учруулсан гэм хорыг арилгах[3] гэх мэт ял байв.

2002 онд батлагдсан Монгол улсын Эрүүгийн хуулиар хорихоос өөр төрлийн ялыг зөвхөн 4 төрөл дээр хуульчилжээ. 213 гэмт хэрэгт торгох ял, 44 гэмт хэрэгт албадан ажил хийлгэх ял, 42 гэмт хэрэгт эд хөрөнгө хураах ял, 65 гэмт хэрэгт тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 65 гэмт хэрэгт оногдуулахаар тус тус хуульчилсан байна.[4]

[2] Э.Авирмэд, Д.Дашдэлэг, Г.Совд Монгол хууль 1997 он 8 дахь тал
[3] Монголын төр, эрх зүйн дээж бичиг 1-р дэвтэр 2006 он 16 дахь тал, мөн С.Жанцан Монгол улсын төр эрх зүйн онол 2009 он 53 дахь тал
[4] Халх журам 2009 он Эх бичгийн судалгаа 19-27 дахь тал.

Хорихоос өөр төрлийн ялыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 91-100 дугаар зүйлд хуульчилж өгсөн байдаг.[5] Тус хуульд зааснаар ***торгох ялаар*** шийтгүүлсэн этгээд 14 хоногийн дотор сайн дураар биелүүлээгүй бол эд хөрөнгөөс албадан гаргуулах ажиллагааг хийхээр хуульчилсан.

2013 оны байдлаар торгох ялын бодит биелэлт гүйцэтгэх хуудас 83.7 хувь, мөнгөн дүн 76 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бодит биелэлт гүйцэтгэх хуудас 10.8 хувиар, мөнгөн дүн 10.9 хувиар өссөн дүн гарчээ.[6] *Эд хөрөнгө хураах ялыг* гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэх бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эд хөрөнгө хураах ялаар шийтгүүлсэн этгээдийн ялыг 30 хоногийн дотор дуусгавар болгохоор заасан бөгөөд "Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актын хамтаар ялтны эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд шүүх 3 хоногийн дотор хүргүүлэх учиртай. 2013 оны байдлаар *Эд хөрөнгө хураах ялын* бодит биелэлт гүйцэтгэх хуудас 85,3 хувь, мөнгөн дүн 86,5 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх хуудас 11,5 хувь, мөнгөн дүн 28,3 хувиас тус тус өссөн байна. Сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад 24,9 хувиар өсчээ.[7]

Албадан ажил хийлгэх ялын тухай Монгол улсын эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхээр хуульчилсан бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96.2 дахь хэсэгт зааснаар ШШГ алба шийтгэх тогтоолыг хүлээж аваад 3 хоногийн дотор сум, дүүргийн засаг даргад танилцуулж аль байгууллагад албадан ажил хийлгэхийг тогтоолгож, ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина[8] гэж заасан.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах, эрх хасах ялын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 42,5 хувь, хоногийн биелэлт 52 хувьтай. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх хуудас 3,8 хувиар, хоног 4,9 хувиар өссөн байна. Сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад 9,7 хувиар өссөн дүнтэй байна.[9]

Ийнхүү аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба шийдвэр гүйцэтгэлийг улирал, жилээр гаргаж үр дүнгээ тооцлог хэдий ч хохирогчийн гомдол тасардаггүй. Учир нь төлбөр авагч шүүхээр асуудлаа шийдвэрлүүлсэн ч тэр нь цаасан дээрээсээ хөрсөн дээр бууж бодит биелэлээ олох үнэхээр хүнд,

[5] Монголын төр эрх зүйн дээж бичиг 5 дугаар боть 2010 он 320 дахь тал
[6] ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын 2013 оны жилийн эцсийн тайлангаас
[7] Мөн тайланд
[8] Мөн тайланд
[9] Хорихоос өөр төрлийн ялын талаар хуулийн байгууллагын нэгдсэн хэлэлцүүлэг прокурорын байгууллагаас өгсөн дүгнэлт.

зардал чирэгдэл ихтэй, цаг хугацаа алдагдсан хэцүү ажил гэдгийг төлбөр авагчдын гомдлын судалгаа харуулдаг.

Прокурорын хяналтын мэдээгээр нийслэлийн хэмжээнд 2013 онд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн нийт 4165 ялтанд хяналт тавьж ажилласны дотор торгох ялтай 180 ялтны 28-ыг, албадан ажил хийлгэх ялтай 225 ялтны 7-г тус тус хорих, баривчлах ялаар солиулжээ. Гэвч шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад шүүхийн шийтгэх тогтоолд зарим шүүгч тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан ч гүйцэтгэх хуудас бичихгүй байгаагаас ялтан хяналтанд бүрэн хамрагдахгүйд хүргэж байна гэж дүгнэсэн.

Шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэхэд багагүй хүндрэл бэрхшээл байна. Энэ нь голчлон хуулийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу байгаагийн зэрэгцээ өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадан ажил хийлгэх ялыг хаана, ямар байгууллагад ажиллуулах нь тодорхой бус зөрчилтэй байна. Иймд Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын уялдаа холбоог хангах чиглэлээр шинээр боловсруулж буй "Гэмт хэргийн тухай", "Ял шийтгэл эдлүүлэх, нийгэмшүүлэх тухай" хуулийн төсөлд санаа болгоход, албадан ажил хийлгэх ялтай этгээд ямар байгууллагад ажиллуулах гэдэг дээр нэгдсэн ойлголтод хүрч энэ төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр нэг ойлголтод хүрэх шаардлагатай байна.

Хорих ял дээр эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулсан гүйцэтгэх хуудас бүрэн бичигдэж ирэхгүй байна. Тухайлбал, 2013 оны жилийн эцсийн байдлаар хорих ангид үндсэн ялаа эдэлж байгаа эд хөрөнгө хураах нэмэгдэл ялтай 127.9 сая төгрөгийн төлбөртэй 459 ялтан ял эдэлж байгаагаас зөвхөн 31.1 хувьд гүйцэтгэх хуудас бичигджээ.[10]

Энэ нь ял оногдуулсан ялтан бүрийн гүйцэтгэх хуудсыг шүүхээс заавал бичиж шүүхийг шийдвэр гүйцэтгэх албад руу хүргүүлж байх, нөгөө талаар хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолтой нь эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан гүйцэтгэх хуудсыг нь хамт бичиж ирүүлэх ажлыг нэг мөр болгох хэрэгтэй байгааг харуулж байна. Яагаад гэвэл шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заахаар хуульчилсан боловч практикт ихэвчлэн мөнгөн хэлбэрээр бичигддэг нь гүйцэтгэл хийхэд хүндрэл учруулж байна.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг 1-5 жилээр хязгаарлахаар хуульчилсан бөгөөд хэрэгжилтийг хэрхэн хангахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан байдаг.

[10] ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын 2013 оны жилийн эцсийн тайлангаас

Өнөөдрийн дагаж мөрдөж байгаа хуулиар эрх хасах ялаар шийттүүлсэн этгээдийн 90 орчим хувь нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял шийттүүлсэн ялтан байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нь тэдгээрийн тээврийн хэрэгсэл жолоодохгүй байгаа эсэхийг өдөр тутам хяналт тавих боломжгүй байна. Иймд "Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам"-д прокурор, цагдаагийн байгууллагатай хамтарсан ажлын хэсэг гарч өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулах асуудал ганц монгол улсын асуудал биш дэлхийн бусад олон улс оронд хэрэгжүүлж байна. Зарим улс орны туршлагаас цухас боловч дурьдая.

Дэлхийн эрүүгийн загвар хуулийн 68 дугаар зүйлд "Эд хөрөнгө хураах, Хохирогчид нөхөн төлбөр төлөх, Торгох, Хуулийн этгээдийг татан буулгах, Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээллэх, тодорхой үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх эрхийг хугацаатай ба хугацаагүйгээр хориглох зэргээр" тодорхойлсон байна.

Дэлхийн эрүүгийн загвар хуулийн тусгай ангийн шинэ төрлийн гэмт хэргийн 20 шахам төрлүүдийг хуульчлан томъёолсныг гэмт хэргийн бүрэлдэхүүнээр нь нарийвчлан задалж авч үзвэл 60 шахам төрлийг томъёолсон байна. Жишээ нь загвар хуулийн 134-135 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн төрлүүдийг 10 гаруй гэмт хэргийн бүрэлдэхүүн үйлдлээр дамжин илрэх учиртай тодорхой ойлгомжтойгоор томъёолжээ. Мөн ялын зорилгыг зарчим, төрөлтэй нягт уялдуулж, тодорхойлохыг зорьсон байдаг. Эрүүгийн загвар хуулийн 34 дүгээр зүйлд: "Ялын үндсэн зорилго нь нийгмийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангах, гэмт этгээдийг засан төлөвшүүлэх, гэмт хэргийн хор аюулыг нийгмээс зайлуулах, гэмт хэргийг таслан зогсоох, сэргийлэхэд оршино" гэж заажээ.[11]

Франц улсын эрүүгийн эрх зүйд ялын систем нь гэмт үйлдэхүйн категори ангиллаас хамаарч эрүүгийн ял, засан хүмүүжүүлэх, цагдаагийн гэж ангилна. Тэдгээрээс хамгийн хүнд нь эрүүгийн ял бөгөөд түүнд нь урт, богино хугацаатай хорих ял багтана. Францад торгох ялыг өргөн хэрэглэдэг. Тухайлбал 20-50 евро хүртэл торгодог байна. Торгох буюу хорих ял хэрэглэсэн нөхцөлд нэмэгдэл ял хэрэглэдэггүй юм байна.[12]

Герман улсад хууль бусаар олсон орлого буюу зориулалтын бус зүйлд хөрөнгө оруулсан этгээдэд эд хөрөнгөөр торгох ял оногдуулдаг.[13]

ОХУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийн төрлийг хохирлын гэхээсээ илүү нийгмийн аюул болон оногдуулах ялын санкцын шалгуурыг голлон харгалзаж үздэг байна. ОХУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хянан байцаах газар, засан хүмүүжүүлэх товууд, баривчлах байр, засан хүмүүжүүлэх газар, төв болон орон нутгийн

[11] Model Codes for Post-Conflict Criminal Justice Volume 1 Model Criminal Code book united state institute of peace press Washington o.c 2007

[12] Prisoners- Staties-Countries Compared-NationalMaster http//www.nationmaster.com /red/ graph-pri-fem-crime prisoner

[13] Уголовный Кодекс федеративной республики германиy(Науч.ред Д.А Шестокова, перевод с немецкого Н.С рачковой С.П. б Пресс. 2003)

байгууллагууд, бусийн удирдах байгууллагууд зэрэг бүтэцтэйн дотор засан хүмүүжүүлэх төвүүд нь эрх чөлөө хязгаарлах ял шийтгэлийг хэрэгжүүлдэг.[14]

Монгол улсын шүүхийн статистикийн сүүлийн 5 жил тутмын дундаж жишгээс харьцуулан түүвэрлэж үзэхэд эрүүгийн хэргийн шийттэх тогтоолын 52.2-54.7 хувь нь хэвээр үлдэж, 45.3-47.8 хувь нь хүчингүй болох буюу өөрчлөгдөж ирсэн нь ялын бодлогын шийдлийн үнэн зөв, тогтвортой байдал алдагдаж ирснийг харуулж байна.

Хорихоос өөр төрлийн ялын дотроос албадан ажил хийлгэх болон эд хөрөнгө хураах ялыг байнга хэрэглэж ирсэн ч биелэлтийн хувьд хангалттүй байна. Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн шийдвэрийг авсаны дараа 3 хоногийн дотор сум, дүүргийн засаг даргад танилцуулж, ялтныг ажиллуулах хуультай ч хаана, ямар байгууллагад ажиллуулах нь тодорхой бус учраас зарим талаараа ялтан ял завшихад хүргэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар эд хөрөнгө хураах ялаар шийтгүүлсэн этгээдийн ялыг 30 хоногийн дотор дуусгавар болгохоор заасан байдаг ч амьдрал дээр 30 хоног байтугай хавьгүй урт хугацаанд үргэлжилж эд хөрөнгө хураах ялыг хэрэгжүүлэхэд маш их хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Зарим яллагдагч, шүүгдэгч түүний ар гэрийн хүмүүс шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд эд хөрөнгөө бусдад шилжүүлэх зэрэг үйлдлүүд практикт түгээмэл байдаг. Гадны орны туршлагаас харж байхад торгох ялыг биелүүлэхээс зайлс хийсэн ялтны ялыг хорих баривчлах ялаар солихоос гадна эдийн засгийн өөр төрлийн арга хэмжээнүүд авдаг байна. Энэ бүхнээс үзэхэд Монгол улс эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хорих ялын талаар өөрчлөлт шинэчлэлт хийхийн зэрэгцээ хорихоос өөр төрлийн ялын талаар дорвитой арга хэмжээ авах цаг болсныг харуулж байна. Иймд дараах зарим санал дүгнэлтийг хийж байна.

Үүнд: Дээр дурдсан нөхцөл байдлыг үндэслэн Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэл эрүүгийн хуулийг шинээр гаргахад үзэл баримтлалын хувьд:

- ✓ Дэлхийн эрүүгийн загвар хуульд заасан хууль ёсны болон хүнлэг ёсны зарчмуудыг жишгийн агуулгаар нь шалгуур болгон тогтоох замаар энэхүү суурь зарчмуудыг шүүх хэрэглэх нөхцлийг бий болгох
- ✓ Ялын бодлогод хүмүүнлэгийн шинжтэй зарчмын өөрчлөлт оруулж, хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх өргөн боломжтойгоор альтернатив нөхцлөөр тодорхойлох
- ✓ Торгох ялыг оногдуулах нөхцөл, үндэслэлийг загвар хуульд гарсан жишгийн дагуу ялтны орлого, цалин хөлс болон орлого олох боломжийг харгалзан тодорхой тарифаар буюу стандарт хэмжээгээр уялдуулж оногдуулах, ингэхдээ тодорхой хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тооцох журмыг шинээр хуульчлах

[14] Коментарий к Уголовному кодексу Российской Федерации. Под. Ред А.В Бриллиантова. М., 2010 с.6

- ✓ Албадан ажил хийлгэх ялыг бүрэн халж, нийгмийн тустай ажил хийлгэх ялаар солих
- ✓ Хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоог сайжруулах
- ✓ Хууль тогтоогчоос хуулийн хийдэл цоорхойг арилгуулахаар нэмэлт өөрчлөлтийг тухай бүр хийж байх
- ✓ Хууль хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтны хууль биелүүлэх сахилгыг дээшлүүлэх
- ✓ Ял эдлүүлэх болон хяналтын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох ажиллагааг шинэ түвшинд гаргах



# ЭРХ, ҮҮРГИЙН БҮТЭЦ БА ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗЭРЭГЦЭЭ ХУУЛЬ

Г.Амаржаргалан
/Шихихутуг ХЗДС-ийн Салбар эрх зүйн тэнхмийн эрхлэгч, магистр/

Бид яагаад хариуцлага хүлээдэг вэ?

Хариуцлага хэмээх ухагдахуун нь хүний ухамсрын үүсэлтэй холбоотой буюу би юуг? яагаад? хэзээ? хэний төлөө? хаана? хийх тухайгаа бодох болсон тэр үеэс эхэлсэн. Бид ямар нэгэн ойлголт, хэмжүүрийг асар тодорхой нэгэн цаг үед хамаатуулахыг хичээсээр их уджээ.[1] Үг зүй, үүсэл гарвалын хувьд ч тэр ***хариуцлага нь болох, болохгүйн тухай асуудал*** юм. Аливаа үйлийг зөв, буруу гэж үзэх, болох, болохгүйн ялгаанд зааглах нь хүн бүрийн нэгдмэл нэг сэтгэхүйн үйлдлээр илэрхийлэгдэх боломгүй сэтгэхүйн нарийн түвэгтэй ойлголт биз. Энэ л утгаараа бид эрх зүй хэмээх хамгийн нийтлэг сэтгэхүйн хэмжүүрийг бий болгосноор хариуцлагыг ганцхүү эрх зүй, хууль зүйн түвшинд л ярьж, бичдэг болжээ.

Хариуцлага буслад харагдах ёстой юу? Бид бичигдээгүй хуулийн тухай ярьдаг ч хуулийг бичигдсэн хуулиар л ойлгодог, бас хардаг. Нэгэнт бид хариуцлагыг бичсэн учраас бичсэн зүйлээ харахын тулд хариуцлагыг хэн хүлээх юм бэ? тэр хүн яаж хариуцах вэ? ямар хариуцлага хүлээлгэх вэ? хэн хүлээлгэх вэ? гэсэн түүнийгээ харж болох бодит хэмжүүрээр тодорхойлсоор эцсийн дүндээ цаазаар авах ял "эдэлсэн" цогцосыг, хохирол арилгаад хоосорсон хэн нэгнийг харж байж санаа амардаг.

***Хариуцлагын тухай ярихын тулд үүргийн тухай, үүргийн тухай ярихын тулд эрхийн тухай ярихаас өөр арга үгүй.*** Угтаа бид хариуцлагын тухай ярихын тулд эрхийн тухай яриад байна уу? эрхийн тухай ярихын тулд хариуцлагын тухай яриад байна уу? Хариултыг хайхын тулд юуны өмнө хариуцлагаас урагших эрхийг тодорхойлох гээд үзье.

Эрүүгийн хариуцлага хүлээж буй этгээд хэний өмнө үүрэг хүлээсний төлөө энэхүү хариуцлагыг хүлээж байна вэ? Лавтай өөрийнхөө өмнө л лав биш. Тийм ч учраас өөрийгөө зодох, өөрийгөө гүтгэх, өөрийгөө доромжлох, өөрийнхөө өмчийг хулгайлах зэрэг гэмт хэрэг байдаггүй биз. Тэгвэл зодуулсан хүний өмнө түүнийг зодохгүй байх үүргийг хүлээдэг гэж үү? Бас тийм биш байна. Яагаад гэвэл тэр хүн гомдоод байгаа эсэх нь нэг их чухал

[1] Энэ нь "хариуцлагатай байх" үгийн хажуугаар хариуцлагагүйгээр оногдсон хүмүүст хамаатай.

биш. ***<u>Бусдын</u> буюу тодорхой хэн нэгний өмнө бус нийтийн өмнө хүлээж байна.*** Нийтийн өмнө хүлээсэн үүргийг бий болгосон эрх нь бас нийтийн, амьд хүн бүрт хамаарах эрхүүд байгаа нь тодорхой. Энэ эрх нь байдаг эрх үү? байлгадаг эрх үү? байгаа гэж ярьдаг эрх үү? Юутай ч хариуцлага нь *<u>тодорхой, арга, хэлбэр нь олон бас цөөн байхаас хамаарч</u>* үүрэг бас тодорхой, олон, цөөн байна, бас эрх ч нэгэн адил. Мэдээж хэрэг «хүний эрхийг дээдэлсэн нийгэмд» эрх нь тодорхой, ямар нэг хуульд нэг бүрчлэн дурдсан шинжтэй байх нь инээдтэй учраас эрхийг хангах үүргийг бас хариуцлагыг мухарлах нь амаргүй ажил юм. Юутай ч эрүүгийн хуульд буй гэмт хэргийн төрөл нэмэгдэж байгаад талархууштай.

Захиргааны хариуцлага хүлээж буй этгээд яагаад ийм хариуцлага хүлээж байгаагаа мэддэг болов уу? Архи уугаа л биз. Бусдад архи уулгасан биш. Машинаа жолоодоо л биз. Хүний машин жолоодсон биш. Замын хөдөлгөөнд оролцоо л биз. Хүн дайрч, зам эвдэлсэн биш. Гэтэл яагаад? Бас л өөрийнхөө өмнө эсхүл бусад тодорхой этгээдийн өмнө бус нийтийн өмнө хүлээсэн үүргийн тухай яригдаж байна.

***Эрх зүй бол үүрэгжүүлсэн, угтаа бол хариуцлагажуулсан эрх юм.***

Эрх зүйн ялангуяа хувийн эрх зүйн хувьд эрх, үүрэг, хариуцлагын бүтцийг зөв тогтоох нь ***бодит Иргэний хууль*** болон түүний ***зэрэгцээ орших Иргэний хуулийг*** ялган тодорхойлоход ихээхэн чухал.

Үндсэн хуулийн эдийн засгийн баталгаа болох өмчлөх эрхэд чиглэсэн хувийн эрхийн харилцаа нь эрх, үүргийн харилцан хамаарлын дараах бүтэцтэй байна.

1. [**эрх**[2] = *үүрэг*[3] = **шаардах эрх**[4] = *хариуцлага хүлээх үүрэг*[5]]
[А] [Б] [А] [Б]

Энэ бүтцийн агуулга нь, эрхийн харилцаа нь хэн нэгэн тодорхой этгээдэд олгогдсон бол энэ нь цаашид бусдыг үүрэгжүүлэх, шаардах, хариуцлага хүлээх гэсэн эрх-үүргийн цуваа хэлбэртэй байх юм. Бусдын өмнө хүлээх үүргийн энэ бүтцийг хууль /Иргэний хууль ба бусад хууль/ зохицуулахдаа **"бүтэц эвдэгдэхгүй байх"** зарчмыг хангах ёстой.

Монгол улсын Иргэний хуулийн 13.3-т, "Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ **бусдад** гэм хор учруулсан, зах зээлийн

---

[2] Энэ бүтцийн эрх бол тодорхой этгээдэд хамаарах эдийн засгийн эрх ба боломж юм. Энэ эрхтэй этгээдийг А гэж нэрлэе. Одоогоор хуулийн хүрээнд /Үндсэн хууль, Иргэний болон бусад хууль/ энэ эрхийг тодорхойлсон байна. Монгол улсын Үндсэн хуулийн 5.2-т " Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", 16.3-т, "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийтийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө."

[3] Энэ бүтцийн үүрэг нь, А-д олгогдсон эрхийг хангахын тулд уг эрхийг зөрчихгүй байх үүргийг А-аас бусад этгээдэд хүлээлгэж буй хэлбэр юм. Бусад этгээдийг Б гэе.

[4] Энэ бүтцийн шаардах эрх нь А-д хамаарах эрхийг Б зөрчсөн учраас түүгээр эрхээ хамгаалахаар шаардах эрх буюу А-д хамааралтай эрх юм.

[5] Энэ бүтцийн хоёрдахь үүрэг буюу хариуцлага хүлээх үүрэг нь гагцхүү А-ийн шаардсанаар Б-д хамаарах үүрэг юм.

харилцааны чөлөөт байдлыг үндэслэлгүйгээр хязгаарласан, хууль ёсны давуу байдлаа хууль бусаар ашигласан үйл ажиллагаа явуулж болохгүй бөгөөд хэрэв зөрчвөл **хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ"** гэж заажээ. Хуульд эрх нь аль эсвэл үүрэг нь байгаа ч хариуцлага байхгүй бол энд бүтэц байхгүй болж таарч байна. Хариуцлагыг хуульд заахгүйгээр бусдад оногдуулах боломжгүй учир эл бүтцийн хариуцлагаас бусад аль нэг хэсэг нь хуульд заагдсан байна.

Бүтэц эвдэгдэхгүй байхаар хуулийг томъёолж чадвал бүтцийн аль нэг эрх эсхүл үүргийг заасан байхад л бүхэлд нь энэ харилцааг үнэлэх боломжтой болох юм. Ийм бүтцийг хангах хувийн эрх зүйн хууль "хариуцлагыг тоочих" боломжгүй юм. Бүтцийн хувьд хариуцлага юу гэж тодорхойлогдсоноор шаардах эрх, үүрэг, эрхийн хүрээ, хязгаар яг тийм хэмжээгээр тодорхойлогдох боллог. Гэтэл эл бүтцийн язгуур нь эрх учраас бүтцийн хувьд замбараа муутай иргэний хуулиар бусдын зөрчигдсөн эрхийг шударгаар хангана гэдэг худал. Бүтцэд анхаарах, бүтцийн язгуурыг тогтоох, бүтцийн нэгж бүрийн тэнцвэрийг үнэлэхгүйгээр аль нэг хэсгийг шууд үнэлэн хэрэглэх /шаардах эрхийг шүтэх үзэл/ нь учир дутагдалтай юм. Эх газрын нэг бүлийн сонгодог жишгийг дагах нь одоохондоо барьцтай ч хэрэглээ бол хуулиа л дагадгийг санах хэрэгтэй. Эрхгүй үүрэг, үүрэггүй шаардах эрх нь хуульд заасан хариуцлагаар хангагдах боломжгүй юм.

2. [**эрх** = *үүрэг* = **шаардах эрх** = *хариуцлага хүлээх үүрэг*]

[А] [Б] [А] [Б]

Энэ бүтцийн хувьд өмнөх бүтэцтэй загвар адил боловч хариуцлагаас бусад нэгжүүд аль аль нь хуульд заагдаагүй байхыг ойлгоно. А-ийн хуульд заагаагүй эрх нь Б-д хуульд заагаагүй үүргийг үүсгэх учир А-д хуульд заагаагүй шаардах эрхийг үүсгэнэ гэсэн үг. Гагцхүү энэ бүтцийн хувьд хуульд заагдсан хариуцлага байхыг шаардана. Иргэн, хуулийн этгээдийн "эдийн засгийн эрх"-ийг "өмчлөх эрх" дангаараа тодорхойлж чадахгүй учир хуульд нэг бүрчлэн заан тоочих боломжгүй олон боломж /эрх/ хуулийн зэрэгцээгээр оршин буй. Иргэний хуулийн 13.2-т, "Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хуулиар хориглоогүй буюу хуульд шууд заагаагүй эрх, үүргийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж болно" гэсэн байна. Заалтын агуулга нь гагцхүү тэдгээрийг хангах хариуцлагын заалтын тусламжтайгаар дээрх бүтцийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Нэгэнт Иргэний хууль бол хэн нэгэнд чанартай угаалгын нунтаг санал болгодог "зар сурталчилгааны самбар"-аас ялгаатай учраас иргэн, хуулийн этгээдэд санал болгосон, жишиг болгосон олон олон "эрхтэй", "шаардах эрхтэй" гэсэн хэсэг бусаг заалтуудаас татгалзах нь зүйтэй. Харин хувийн эрх зүйн "үндсэн хууль" гэдэг агуулгаараа хуульд заагаагүй эрхээс үүдсэн, түүнийг зөрчихгүй байх хуульд заагаагүй үүрэг, түүнийг шаардах хуульд заагаагүй шаардах эрх, түүнийг хангах хуульд заасан хариуцлагын бүтцийг сайтар анхаарах нь чухал байна. Иргэний хуулийн зэрэгцээ орших энэ бүтэц нь бусдын өмнө хүлээх үүргийн

харилцааг хариуцлагажуулсан хэсгээс л харагдах боломжтой юм.

3. [эрх = үүрэг = шаардах эрх = хариуцлага хүлээх үүрэг /эрсдэл/]

[A] [A] [A] [A]

Энэ бүтэц нь агуулга, зорилгоороо 1 болон 2 дахь бүтцэд ямар үүрэг, шаардах эрх, хариуцлага байхыг тодорхойлж өгөх үндсэн бүтэц юм. Өөрийн өмнө хүлээх үүрэг тодорхойлогдож байж, бусдын өмнө хүлээх үүрэг тодорхойлогдоно. Дээрх бүтцээр А-д хамаарах эрхийг хангах, түүнийг зөрчихгүй байх үүргийг "бусад этгээд" биш А өөрөө хүлээж байна. Ийм бүтцээр А өөрийнхөө өмнө хариуцлага буюу "эрсдэл"[6] хүлээнэ. Монгол улсын Иргэний хуулийн 255.1-ийн дурдсан заалтуудад, «...худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдана» гэжээ. Ийм агуулга бүхий заалт Иргэний хуульд[7] хэд хэд бий.

***Жишээ тоймлоё.** Худалдагч А худалдан авагч Б-д ном худалдсан байна.*

***Б шалгаж үзэлгүй авсан бөгөөд хожим номын хуудас дутуу болохыг мэдсэн байна.***

**Задаргаа хийхэд.**

1. А-д ном худалдаж авах буюу эд хөрөнгийг шударгаар олж авах эрх бий. Хууль болон гэрээгээр энэ эрхийг хангах, тохиролцоог зөрчихгүйгээр эд

[6] Эрсдэл- бусдаас шаардах эрхгүй хариуцлага. /Г.А/

[7] 94.1.Эд хөрөнгийг эзэмших эрхгүй буюу энэ эрхээ алдсан шударга эзэмшигч нь уг эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан өгөх үүрэгтэй., 150.11.Барилга, байгууламж барих зориулалтаар газар эзэмшиж байсан этгээд энэ хуулийн 150.10-т заасныг хугацааг сунгахаас татгалзвал нөхөн төлбөр шаардах эрхээ алдана., 159.4.Барьцааны зүйлийн үнийг төлөөгүй тохиолдолд худалдан авах эрхээ алдахыг дуудлага худалдаанд оролцогчдод тайлбарласан байвал зохино., 175.4.Үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарснаар үүрэг гүйцэтгэгч уг эд хөрөнгийн үр шимийг өөртөө үлдээх эрхээ алдана, 255.1. Дараах тохиолдолд худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдана:, 204.2.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээнээс татгалзах хугацааг татгалзах санал гаргаагүй тал нь тогтооно. Энэ хугацаанд гэрээнээс татгалзаж байгаа тухай нөгөө талд дахин мэдэгдээгүй бол гэрээнээс татгалзах эрхээ алдана, 224.2.3.мөнгөн төлбөрийн үүрэг дөсөр хүү, энэ авах эрхээ алдах., 242.6.Үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгч нэг этгээдэд шаардлага гаргаснаар бусад үүрэг гүйцэтгэгчдэд шаардлага гаргах эрхээ алдахгүй., 255.1.1.эд хөрөнгө хүлээж авах үедээ уг эд хөрөнгийн доголдлын талаар мэдсэн буюу мэдэх боломжтой байхад түүнийг хүлээн авсан; 255.1.2.аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэн даруй шалгаж авах үүргээ биелүүлээгүй; 255.1.3.тухайн эд хөрөнгийн доголдол нь худалдан авагч түүнийг тээвэрлэх, хадгалах, ашиглах журам зөрчсөнөөс, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй océгой нөхцөл байдлын улмаас үүссэн., 282.3.Хуульд өөрөөр заагаагүй бол хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана, 352.4.Ажлын үр дүнг хүлээж авах үед түүний доголдлыг захиалагч мэдэж байсан боловч ямар нэгэн гомдол гаргаагүй бол гэрээр энэ хуулийн 352.2-т заасан шаардлага гаргах эрхээ алдана., 367.2.Ажиллуулагч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй, ажилтан гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу гэрээнд харш үйл ажиллагаа явуулсны улмаас гэрээг цуцалсан бол ажилтан ажлын хөлс шаардах эрхээ алдана, 373.2.Энэ хуулийн 373.1-д заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгосон бол аялал жуулчлал зохион байгуулагч нь хэлэлцсэн тохиролцоон хөлс авах эрхээ алдана. Нэгэнт үзүүлсэн доголдолгүй үйлчилгээнийхээ хөлсийг шаардах эрхтэй., 378.2.Энэ хуулийн 378.1-д заасан тохиолдолд аялал жуулчлал зохион байгуулагч гэрээгээр тохиролцсон хөлс авах эрхээ алдах боловч өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр жуулчнаас шаардах эрхтэй., 411.9.Зуучлагч гэрээг зөрчиж, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс ажиллавал хөлс, шагнал авах буюу зардлаа нөхөн төлүүлэх эрхээ алдана., 415.7.Хишгээ хийгч нөгөө тал үүргээ гүйцэтгэж чадахгүй болох нь тогтоогдвол худалдааны төлөөлөгч, комисс нь хөлс, шагнал шаардах эрхээ алдаж, өмнө авсан хөлс, шагналыг үйлчлүүлэгчид буцаан өгнө. 418.2.1.шинээр хамрагдсан үйлчлүүлэгчтэй байгуулсан хэлцлийг сунгаснаар хөлс, шагнал авах эрхээ алдсан., 443.18.Гуравдагч этгээдэд санаатайгаар амь нас даатгасан тохиолдолд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий гуравдагч этгээдийн хууль бус үйлдлийн улмаас даатгагдсан этгээд нас барсан бол уг этгээд даатгалын нөхөн төлбөр авах эрхээ алдана, 462.3.Үүрэг гүйцэтгүүлэгч, энэ хуулийн 462.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол тэрээр үүрэг гүйцэтгэгчийн улмаас үүсэж хохирлын хэмжээгээр батлан даагчийн эсрэг шаардлага гаргах эрхээ алдана., 515.5.Хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвлөгдөх хөрөнгө эзэнгүй эд хөрөнгийн нэг адил төрийн өмчлөлд шилжинэ.,

хөрөнгийг шилжүүлэх /худалдах/ үйлдэл хийх үүрэг Б-д үүссэн байна. Б эл үүргээ зөрчсөн бол түүний гүйцэтгэлийг шаардах эрх А-д, А-ийн шаардлагын дагуу хариуцлага хүлээх үүргийг Б хүлээнэ. Дурдсан жишээгээр эрх, үүрэг, шаардах эрх нь хуульд заагдсан агуулгаараа эхний бүтцэд хамаарч байна. /243.1-д зааснаар биет байдлын доголдолгүй эд хөрөнгийг бусдад шилжүүлэх үүрэг/

2. А-д ном худалдаж авах буюу эд хөрөнгийг шударгаар олж авах эрх бий. Хууль болон гэрээгээр энэ эрхийг хангахдаа номыг шалгаж авах үүрэгтэй байхаар хуульд заажээ. Энэ үүргийг А нь Б-ийн өмнө бус өөрийнхөө өмнө хүлээсэн байна. Улмаар эл үүргийн зөрчилтэй холбоотойгоор үүсэх шаардах эрх А-д хамааралтай учраас А өөрийнхөө өмнө хариуцлага буюу эрсдэл хүлээж байна. Дурдсан жишээгээр 3 дахь бүтцэд хамаарч байна.

Хуулийн дурдсан заалтуудын дагуу шаардах эрхээ алдаж буй этгээд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжоо шууд алдаж байна. Учир нь, хэдийгээр худалдагч доголдолгүй эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлэх үүрэгтэй хэдий ч түүнийг шалган авах, хүлээн авах үүргийг худалдан авагч худалдагчийн бус өөрийнхөө өмнө хүлээсэн байна.

Хүмүүний жинхэнэ мөн чанар нь "өөрийгөө ойлгох буюу өөртөө бүү тохиолдоосой гэсэн зүйлийг бусдад бүү хийх"[8] зарчимд үндэслэнэ. Угтаа өөрийнхөө өмнө хүлээх үүргийг бусдын өмнө хүлээнэ гэсэн үг юм. Үүргийн буюу эрсдлийн 3 дахь бүтцийг зөв тогтоосноор бусдын өмнө ямар үүргийг хүлээх, эс хүлээх хуулийн зорилт, зохицуулалт урган гарна. Эдийн засгийн агуулгаараа XVIII зуунд мөрийтэй тоглоомын магадлалд суурилсан эрсдлийн эхэн үеийн шинжилгээ нь эдүгээг хүртэл үйлдэх, эс үйлдэхийн эргэлзээ, таамаглалд суурилсан институц болж хөгжжээ. Эдийн засгийн нөхцөл байдлаа дордуулахыг хүсэхгүй байх эдийн засгийн хувь ашиг сонирхолыг Иргэний хуулиар хэлбэржүүлэхдээ «шаардах эрхээ алдах» байдлаар томъёолсон нь буруу биш ч чухам эдийн засгийн ямар харилцаанд хувь хүн өөрийн өмнө үүрэг хүлээн улмаар эрсдэж болох нь тодорхой бус байна. Иргэний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж буй практикт, эрхээ алдах «үүрэгжүүлсэн» зохицуулалтыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөж байгаагаас хувь хүний хүсэл зориг үл үнэлэгдэн орхигдож байгаа жишээ тодорхой бий. Иргэний хуулийн 282.3-т зааснаар шийдэгдэж буй маргаануудад хүсэл зоригийн цаасан хэлбэрт баригдан хүүг хүлээн зөвшөөрсөн хүсэл зоригийг огоорон шийдвэрлэж, шийдвэрээ «хууль ёсны» хэмээн үнэлүүлж буй шийдвэр[9], магадлал[10], тогтоол цөөнгүй байна.

Үүргийн гүйцэтгэлийн зарчим ёсоор үүргийг шударгаар, зохих ёсоор, тогтоосон хугацаанд, зохих газарт гүйцэтгэх зэргээр гүйцэтгэлийн болон гүйцэтгэж болохгүй хэмжээ хязгаарыг тогтоосон. Эл зарчмаар доголдолтой эд хөрөнгө худалдсан худалдагч Б бусдын өмнө хүлээсэн үүргээ зөрчсөний

[8] Күнзийн сургаалийн хэлтэс. Философи. Орч Б.Батчулуун. 2012. 39 дэх тал
[9] Монгол улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл. /Иргэний хэрэг/. цуврал 1. 70, 71, 72 дахь тал
[10] Монгол улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл. /Иргэний хэрэг/. цуврал 1. 45, 46, 47 дахь тал, 66, 67, 68 дахь тал.

улмаас учруулсан гэм хорын хэмжээгээр хариуцлага хүлээх нь зүйн хэрэг. Харин Иргэний хуулиар худалдагчийн бусдын өмнө хүлээсэн үүргийн хариуцлага нь худалдан авагчийн өөрийнхөө өмнө хүлээсэн үүргийн эрсдлээс шалтгаалан үгүйсгэгдэж байна.

Эдийн засгийн утгаараа тодорхой харилцаа, тодорхой үйлдлийн эцсийн үр дагавар хэнд нь илүү хамааралтай байна тэр хүн л илүү хариуцлагатай байх ёстой. Энэ нь бусдын өмнө хүлээсэн үүргээс өөрийн өмнө хүлээсэн үүрэг илүү жин дарна гэсэн үг. Нөгөө талаар хэн нэгэнд олгогдсон эрх нь угаас хэн нэгэнд бусдын өмнө хүлээх үүргийг бий болгоно. Харин хуулиар өөрт олгогдсон эрхийг хангах өөрийн өмнө хүлээсэн үүрэг буюу эрсдлийн зохицуулалтыг хуулиар хангалттайгаар зохицуулах шаардлагатай.

Тодорхой төрлийн гэрээнүүдээс харахад, худалдах худалдан авах гэрээ болон зээлийн гэрээ, аялал жуулчлалын гэрээ, даатгалын гэрээ, батлан даалтын гэрээний хувьд л бусдын өмнө хүлээсэн үүргийн зэрэгцээгээр өөрийн өмнө хүлээсэн үүргийг /эрсдэл/ зохицуулж өгсөн байна. Хууль тогтоогч ямар шалгуураар эдгээр гэрээнүүдийн хувьд сонголт хийсэн нь тодорхой бус. Эдийн засгийн ашиг сонирхолд суурилдаг гэрээний үүрэг бүрт "шаардах эрхээ алдах" нөхцөл тэнцвэртэйгээр хамаарах ёстой.

***"Хариуцлагаас чөлөөлөх" нь эрсдлийн хуурмаг хэлбэр юм.***

Энгийн агуулгаараа хүлээсэн хариуцлагаас нь чөлөөлж байгаа нь хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн илрэл, нийтийн эрх зүйд зөвтгөж болох ойлголт юм. Харин хувийн эрх зүйд, ялангуяа зөрчигдсөн эрхээ хамгаалуулах эрх нь хуулиар олгогдсон шаардах эрхтэй этгээдийн хувьд энэ эрхийг хангах хариуцлагаас хэн нэгнийг "дураар чөлөөлөх" нь хувийн эрх зүйн зорилго, зарчимд үл нийцнэ. Монгол улсын Иргэний хуульд, "хариуцлагаас чөлөөлөх", "үүрэг хүлээхгүй байх", "үүргээс чөлөөлөгдөх" зэрэг тодорхой нэршлээр томъёологдсон эл харилцаа нь шууд утгаараа эрсдэл хүлээлгэж байгаа боловч, нөгөө тал шаардах эрхээ алдаагүй байгаа үед хэрэглэх боломжгүй юм.

***Товчхондоо, А тал шаардах эрхээ алдсанаар л Б тал хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой. Харин А талд шаардах эрх хадгалагдаж байхад Б талыг түүний өмнө хүлээх хариуцлагаас хуулиар чөлөөлж байгаа нь зөрчигдсөн эрхийг сэргээх зарчимтай зөрчилдөж байна.***

Иргэний хуулийн үүргийн гүйцэтгэлийн зарчим ёсоор бол худалдагчид доголдолтой эд хөрөнгө худалдсан худалдагч хариуцлага хүлээх нь гарцаагүй боловч худалдан авагчийн эрсдэл энэ хариуцлагаас түүнийг чөлөөлж байна. Хуулийн заавал биелэгдэх үүрэгжүүлсэн томъёололд "шаардах эрхээ алдана", "хариуцлагаас чөлөөлнө" гэсэн нэр томъёо аль аль нь хамаарна. Гагцхүү эдийн засгийн ашиг сонирхолыг хангагч Иргэний хуулиар эдийн засгийн эрх чөлөөг үүрэгжүүлэн хязгаарлах нь хувийн эрхийн хэм хэмжээний хувьд "байх боломжгүй" юм.

Нөгөө талаас эрх зүйн харилцааны бүтцийг буюу угтаа эрх, үүргийн бүтцийг тогтоохдоо угаас эдгээр нь тэнцвэртэй байх учиртайг //=/ тэмдэг бүхий байгааг/ анзаарсан буйзаа. Нэгэнт эрхийн хэмжээг зөв тодорхойлсон бол шаардах эрхийн хэмжээ зөв тодорхойлогдох нь дамжиггүй. Иргэний эрх зүйн шинжлэх ухаанд яригдах гэм хор, хохирол гэсэн ойлголтуудыг одоог хүртэл объектын шалгуураар ялгаж байгаа нь учир дутагдалтай. Эдгээр томъёолол нь субъектэд хамаарах нэршил юм. Иргэний хуулийг хэрэглэгч нь хохирлын хэмжээг тогтоогч биш гагцхүү гэм хор учруулагчийн гэм буруутай нийцэхүйц гэм хорын хэмжээг тогтоох туйлын зорилготой юм.

Эдгээр томъёоллын харилцан хамаарлыг дараах байдлаар ойлгож болно.

[гэм хор=хохирол][11]
[гэм хор>хохирол][12] /угтаа бол[гэм хор=хохирол]/
[гэм хор<хохирол][13] /гэм хорд хамаарахгүй хохирлын хэмжээ нь эрсдэл болно/

Гэм хор, хохирлын харилцан хамаарлын хамгийн сүүлийн хэсэгт хохирсон этгээд хоёр төрлийн хариуцлага хүлээж байгаа буюу хоёр төрлийн харилцаанд хоёр төрлийн үүрэг хүлээж байсан байна. Нэгд, гэм хортой тэнцэх хохирлын хэмжээгээр бусдын өмнө, гэм хороос давсан хохирлын хэмжээгээр эрсдэл буюу өөрийн өмнө үүрэг хүлээж байсан гэсэн үг.

Эрх, үүрэг, шаардах эрх, хариуцлага хүлээх үүргийн бүтцийн харилцан хамаарал болон гэм хор, хохирлын харилцан хамаарлаас тодорхойлж үзвэл, үүрэгтэй тэнцүү хэмжээтэй хариуцлага хүлээх үүргийг «гэм буруугийн хэр хэмжээ, эдийн засгийн байдлыг харгалзан» чөлөөлөх ойлголт гэж байхгүй юм. Гагцхүү үүргийн хэмжээ, хариуцлагын хэмжээг тэнцвэржүүлж чадаагүй хуулийн буруу хэрэглээний хувьд л «хариуцлагаас чөлөөлөх» аргаар алдаагаа засаж болох юм.

Эрсдлийг тооцох, үнэлэх нь эрх зүй ялангуяа хувийн эрх зүйн хувьд нэн чухал юм. Сүүлийн ***үед Германы иргэний эрх зүй нь /хувийн эрх зүй/ гэм буруунд суурилсан хариуцлагаас эрсдэлд суурилсан хариуцлагын[14] тогтолцоорүү нүүдэллэж буй нь*** үүний тодорхой жишээ бизээ.

**4. [эрх = үүрэг = шаардах эрх = хариуцлага хүлээх үүрэг /ёс зүйн/]**

[A] [A] [A] [A]

[11] Зөрчил гаргасан этгээдийн бусдад учруулсан гэм хорын хэмжээ нь, хохирсон этгээдэд учирсан хохирлын хэмжээтэй тэнцүү байх. Нотлох баримтыг үнэлэх явцад Б-ын учруулсан гэм хорын хэмжээгээр А-д хохирол учирсан байж болно. Эсрэгээрээ А-д учирсан хохирлын хэмжээгээр Б-ын учруулсан гэм хорын хэмжээ тодорхойлогдож болно.

[12] Энэ тохиолдолд учруулсан гэм хорын хэмжээ хохирлоос их байх нь хохирол шаардах эрхтэй этгээдийн шаардлагын хэмжээнээс хамааралтай байх юм. Угтаа бол тэнцүү байгаа болови А хохирлын 3 сая төгрөгөөс 2 саяыг нэхэмжлэх нь шаардах эрхийн хувь ашиг сонирхолтой холбоотой.

[13] Иргэний эрх зүйд, зөрчигдсөн эрхийн хэмжээг учруулсан гэм хороос давсан хохирлын хэмжээгээр тогтоох ойлголт биш учир шаардах эрхийн буюу хариуцлагын хэмжээ нь хохирлын бус гэм хорын хэмжээнээс шууд хамааралтай байна. Угтаа эрх, үүргийн үндсэн бүтцийн дагуу эдлэх эрхийн хэмжээгээр хүлээх үүрэг, хүлээх үүргийн хэмжээгээр шаардах эрх, шаардах эрхийн хэмжээгээр хариуцлага хүлээх үүргийн хэмжээ тодорхойлогдоно.

[14] Tim Kaye. Law and risk:an introduction. From status to contract. page 5 http://ssrn.com/abstract=1263472

Заримдаа ямар нэг хууль судалж байх явцад "үүрэгтэй" боловч тэр нь ямар эрхийг хангах, хэний өмнө хүлээж буй болон хэнд шаардах эрх нь хамаарах, ямар хариуцлагаар хангах эсэх нь тодорхой бус байдаг. Уг нь бол хуульд огт хамааралгүй боловч хуульд заачихсан байдаг тэр л үүргийн тухай асуудал юм. Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 10.3-т, "Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх...үүрэгтэй» гэснээс үзэхэд, үнэнч байгаагүй эхнэр нь эл үүргийг нийтийн эсхүл, нөхрийн, эсхүл өөрийн өмнө хүлээж байгаа нь тодорхой бус байна. Хуульд заасан хариуцлагын аргын хүрээнд авч үзэхэд, хөрш айлын Д-д шаардах эрх олгогдоогүй байна. Харин нөхрийн хувьд эхнэр нь үнэнч байх үүргээ биелүүлээгүйн улмаас түүнд учирсан эдийн бус, сэтгэл санааны хохирлоо шаардах эрх бас үүсээгүй байна. Тэгвэл энэ нь эхнэр өөрийн өмнө буюу түүнийхээ үр дагаврыг сэтгэл санаа, амь амьдралаараа нөхөн төлдөг, хариуцдаг ёс зүйн үр дагавартай холбоотой байна. Хууль тогтоогч энэ бүтцийн дагуу дээрх үүргийг томъёолсон эсэх нь тодорхой бус. Магадгүй хэний ч өмнө хүлээгээгүй үүргийг хуульчилсан ч байж мэдэхээр байна. Дээр дурдсан бүтэц нь угтаа аль нэг хуульд тусгагдах шаардлагагүй бөгөөд тусгагдсан бол «зохицуулсан хэм хэмжээ» бус «сануулсан хэм хэмжээ»ний үүргийг гүйцэтгэх юм. Ийм «сануулсан хэм хэмжээ» бүхий хууль, хуулийн заалт цөөн бус байгааг дурдая. Хувийн эрх зүйд, тодруулбал, бизнесийн эрх зүйн дотоод буюу «цэвэр» бизнесийн харилцаанд эл үүрэг ихээхэн хамааралтай байдгаас бизнесийн хууль, хууль тогтоомжид заах бус харин чөлөөт шийдвэр гаргалтын эрх зүйн хэлбэрт буюу иргэний хуулийн зэрэгцээ хуульд үлдээх нь энэ бүтцийн хувьд зөв алхам болох юм.

Товчлон хэлэхэд, «эрх зүйн харилцааны агуулга нь эрх, үүргийн нэгдэлтэй байдал» гэсэн уламжлалт хандлагыг ялангуяа хувийн эрх зүйн /иргэний эрх зүй биш/ хувьд «эрх-үүрэг-шаардах эрх-хариуцлага хүлээх үүрэг» гэсэн цуваа томъёолол, бусдын өмнө хүлээх болон өөрийн өмнө хүлээх үүрэг, гэм хор-хохирлын буюу хариуцлага-эрсдлийн харилцан хамаарлаар баяжуулан авч үзэх нь бодит Иргэний хууль болон түүний зэргэлдээх Иргэний хуулийн уялдаа холбоо, учир зүйг тунгаахад дөхөм болох юм. Бодит Иргэний хууль болон түүний зэргэлдээх Иргэний хуулиудад эрх, үүргийн бүтцийг оновчтой хуваарилах нь харагдсаныгаа л хардаг хэн бүхэнд хэрэгтэй буйзаа.



# ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА НЬ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ҮҮСДЭГ ҮҮ..., ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА ҮҮСДЭГ ҮҮ... ЭСВЭЛ...?

Ё.Болормаа
/Шихихутуг ХЗДС-ийн багш, магистр/

*Үг гэдэг навч мэт. Дэндүү их навчтай модонд үр жимс тун бага. - Пифагор*

***Оршил:*** Монгол улсын хөдөлмөрийн хуулиуд /1925, 1930, 1933, 1941, 1973, 1991, 1999/ нь тухайн нийгмийн тогтолцоо бүрт үйлчилж, шинэчлэгдэн өөрчлөгдөж өнөөг хүрсэн билээ. Хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн хуулийн практик хэрэгжилт нь өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгжид хэрэглэх боломжгүй, хамрах хүрээ нь явцуу байна. Хөдөлмөрийн эрх зүйн харилцааны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хуулийн зохицуулалтын хүрээг нарийвчлан тодорхойлох нь зүйтэй болов уу.

***Өгүүлэмж:*** Монгол улсад Нийт ажилтнуудын 29% нь төрийн албанд, 37.7% нь хувийн хэвшилд, 31.3% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 2% нь төрийн бус байгууллагад[1] хөдөлмөр эрхэлж байна. Монгол Улсын хөдөлмөрийн хуулийн 1.1. Энэ хуулийн зорилт нь ***хөдөлмөрийн гэрээний*** үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино. 24.1. Ажил олгогч буюу түүний эрх олгосон албан тушаалтан иргэнтэй ***хөдөлмөрийн гэрээг*** бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй. Байнгын ажлын байранд ***хөдөлмөрийн гэрээнээс*** бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно, мөн Төрийн албаны тухай хуулийн 3.3, 9.1-дэх заалтуудаас харахад төрийн албаны ангиллын дагуу зөвхөн төрийн үйлчилгээний албан тушаалтантай л хөдөлмөрийн гэрээ байгуулах төдийгүй, мөн 11.6-д Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна. ...19.3-д Төрийн жинхэнэ албан хаагчийн **үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг** хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага тогтооно...

***Үндсэн хэсэг:*** Ажиллах хүчийг ид хэрэглэх нь чухамхүү хөдөлмөр мөн.[2] гэснээс үзэхэд хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын хүрээг хязгаарлахгүйгээр хуульчилж өгөх нь зүйтэй байна. Хөдөлмөрийн эрх зүйн

---
[1] Үндэсний статистикийн хорооны "Ажиллах хүчний 2013 оны 2-р улирлын судалгааны товч танилцуулга" 2013 он, 10 дахь тал

[2] Карл Маркс, Капитал, 1999 он, 207 дахь тал

харилцаа нь зөвхөн ***Хөдөлмөрийн гэрээний*** үндсэн дээр үүсэх, байнгын ажлын байран дээр хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэж хуульчилсан нь хөдөлмөрийн хуулийн үйлчлэх хүрээг хумигдуулсан шинжтэй байна.

***Асуудлын гол нь:***

1. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үүсдэг үү...?
2. Үр дүнгийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсдэг үү... эсвэл...? гэдэгт л асуудлын гол нь оршиж юм.

***Нэгдэх асуудлын хүрээнд, Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үүсдэг үү...,***

Монгол Улсын хөдөлмөрийн хуулийн зорилт нь **хөдөлмөрийн гэрээний** үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино. Мөн хуулийн 24.1-д...иргэнтэй **хөдөлмөрийн гэрээг** бичгээр байгуулж, гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй. Байнгын ажлын байранд **хөдөлмөрийн гэрээнээс** бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэж хуульчлагджээ. Эндээс Монгол улсын хөдөлмөрийн хууль нь, зөвхөн **хөдөлмөрийн гэрээ** байгуулсан тохиолдолд үйлчлэхээр харагдаж байна.

Эрх зүйн харилцаа гэж /англ.legal relation (relationship), ор. правоотношение/-эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан нийгмийн харилцаа[3]. Хөдөлмөрийн эрх зүй харилцаа гэж **ажилтан хөдөлмөрийн чиг** үүргийг... цалин хөлс авч биечлэн биелүүлэх, ...хөдөлмөрийн гэрээнд заасан хөдөлмөрийн нөхцлийг ажил олгогчоос хангах, ажилтан хөдөлмөрийн дотоод журамд захирагдахаар ажилтан ба ажил олгогчдын хоорондын хэлэлцээрт үндэслэсэн харилцаа.[4] гэж тайлбарласан бол нэг талд **ажилтан, нөгөө талд** захиргаа буюу ажил олгогчийн хооронд хөдөлмөрлөх, хөдөлмөрлүүлэх асуудлаар үүсч байгаа харилцаа. Энэ нь хөдөлмөрийн гэрээний дагуу ажил үүрэг гүйцэтгэх...ажилтан ажил олгогчийн хоорондох үйл ажиллагаагаар тодорхойлогдоно.[5] Хөдөлмөрийн гэрээнээс ангид байдлаар хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэх боломжгүй бөгөөд энэ нь эл салбар харилцааны онцлог болно.[6] Мөн Төрийн албаны тухай хуулийн 3-р зүйлийн 3.3, 9-р зүйлийн 9.1-дэх заалтуудад төрийн албаны ангиллын дагуу зөвхөн **төрийн үйлчилгээний** албан тушаалтантай л хөдөлмөрийн гэрээ байгуулахаар хуульчлагдсан байна.

Эндээс Хөдөлмөрийн хуулийн үйлчлэх хүрээ нь хөдөлмөрийн гэрээгээр хязгаарлагдах төдийгүй, Мөн Төрийн албаны тухай хуулийн 11.6-д Төрийн

[3] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг, 2011 он 669 дэх тал
[4] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг, 2011 он 540 дэх тал
[5] Л.Баасан,Г.Баярмаа. Монгол улсын хөдөлмөрийн эрх зүй, 2009 он 5 дахь тал
[6] Л.Баасан, Монгол улсын хөдөлмөрийн эрх зүй, 2010 он 6 дахь тал

албан хаагч[7]-ийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна гэснээс үзэхэд хөдөлмөрийн хууль нь Төрийн албанд үйлчилнэ гэдэг нь тодорхой байна.

Дээрхээс дүгнэхэд Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үүсдэггүй гэж дүгнэж болохоор байна.

**Тэгвэл,**

***2. Үр дүнгийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсдэг үү... эсвэл...?***

Төрийн албаны тухай хуулиар Төрийн албыг дор дурдсанаар ангилна:

1. төрийн улс төрийн алба;
2. **төрийн захиргааны алба;**
3. **төрийн тусгай алба;**
4. төрийн үйлчилгээний алба.

Төрийн албаны тухай хуулийн 11.4-т Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно. Мөн 19.3-т Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага тогтооно.

Энэхүү журамд Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх, Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, Менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах, Менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх, Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам, Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх журмуудаар Төрийн жинхэнэ албан хаагчидтай байгуулсан **"Үр дүнгийн гэрээ"**-ээр зохицуулагдана.

Монгол улсын хөдөлмөрийн хуулийн зорилт болон холбогдох бусад заалтаас хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь зөвхөн хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үүсэхээр байна. Гэтэл Төрийн албаны харилцаа нь хөдөлмөрийн эрх зүйн харилцааны ***үндсэн шинжүүдийг*** агуулж байдаг. Өөрөөр хэлбэл: Төрийн алба бол байнгын шинжтэй, үргэлжилсэн шинжтэй, хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрддөг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дагаж мөрддөг, цалингийн сүлжээгээр цалинждаг, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг хийж гүйцэтгэдэг гэх мэт хөдөлмөрийн эрх зүйн харилцааны шинжийг үндсэндээ хангаж байгаа юм. Гэтэл, Хөдөлмөрийн

[7] Төрийн албан тухай хуулийн 11.1. Төрийн албан тушаалыг эрхлэж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ.

хуулийн 24.1-д ...Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэж хуульчлагджээ. Энэ тохиолдолд Төрийн албан дахь Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үүссэн харилцааг хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүссэн гэж үзэх боломжгүй мэт. Гэтэл УДШ-ийн тогтоол, зөвлөмжид ***"Үр дүнгийн гэрээ"-г "Хөдөлмөрийн контракт"***[8]-тай адилтган үзэж болно гэдгээс харахад Үр дүнгийн гэрээ нь хөдөлмөрийн гэрээний нэг төрөл мөн гэж үзэж болохоор байна. Ийнхүү хөдөлмөрийн харилцаатай холбоотойгоор сонгох, томилохоос гадна өөр өөр төрлийн гэрээ байгуулж байгаа нь эдгээр харилцаанаас үүссэн хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбоотой харилцаа төдийгүй түүнээс үүдэн гарах маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудал ч мөн урган гарч ирнэ.

Өөрөөр хэлбэл, ***Үр дүнгийн гэрээ***-ний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсдэг гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн[9] Бусад тохиолдолд....ерөнхий харъяаллын шүүх шийдвэрлэнэ.

Төрийн үйлчилгээний албан хаагчийг ажлаас халах шийдвэрийг ЗХХШТХ-ийн 4.1-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан хэдий ч хөдөлмөрийн эрхийн харилцаа ***хөдөлмөрийн гэрээ***[10]-ний үндсэн дээр үүсдэг тул тухайн асуудлаархи маргааныг ерөнхий харъяаллын шүүх хянан шийдвэрлэнэ. Шүүхийн харъяаллыг тогтоохдоо Хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан уу, ***Үр дүнгийн гэрээ*** байгуулагдсан уу эсвэл томилогдсон уу, сонгогдсон уу гэдгээс тогтоож болохоор байна. Ийнхүү тогтоож байгааг бас л судлах шаардлагатай. Мөн Төрийн албаны тухай хуулийн 11-р зүйлийн 11.5-д Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно гэж хуульчлагдсан. Одоогийн зохицуулалтаас авч үзэхэд, ***Үр дүнгийн гэрээний үндсэн дээр*** Төрийн албаны эрх зүйн харилцаа үүсдэг гэж үзэж болохоор байна. Үүнийг тухайн салбарт байгуулагдсан гэрээ, маргааныг шийдвэрлэх шүүхийн харъяаллаас харж болохоор....

**Дүгнэлт, санал:**

1. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үүсдэг үү..., Үр дүнгийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсдэг үү... эсвэл...? Хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн хуулиар хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь зөвхөн хөдөлмөрийн гэрээний / контракт/ үндсэн дээр үүсдэг, үр дүнгийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсдэггүй. Харин цаад мөн чанарыг нь авч үзвэл төрийн албанд бүхэлдээ хөдөлмөрийн эрх зүй харилцаа үүсэж байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн эрх зүйн харилцааны онцлог, мөн чанар, гэрээний

[8] 22.1. Өмчлөгч буюу түүнээс эрх олгосон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг хэрэгжүүлэхэд бусдын хөдөлмөрлөх үйл ажиллагаа, мөн ажил олгогч нь иргэний гэм буюу хохирол авсан, өндөр ур чадварыг холбогдон авч ашиглах шаардлагатай иргэнтэй контракт байгуулна.

[9] Монгол Улсын дээд шүүхийн "Иргэний зарим хэргийн харъяаллыг захиргааны хэргийн харъяаллаас зааглан ялгах тухай 2007 оны 32-р тогтоолын 3.1-д Төрийн албаны тухай хуулийн 5.1-д заасан төрийн улс төрийн, тусгай, захиргааны албан хаагчдын ажлаас үндэслэлгүй халагдсан тухай маргаантай хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх бөгөөд энэ тохиолдолд ажлаас халах шийдвэрийг ЗХХШТХ-ийн 4.1-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан байх шаардлагатай.

[10] Төрийн албаны тухай хуулийн 11-р зүйлийн 11.5-д Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

төрөл зэргээс харж болохоор... Хүчин төгөлдөр үйлчилж буй хөдөлмөрийн хуулийн зорилт нь зөвхөн тодорхой төрлийн гэрээгээр /хөдөлмөрийн гэрээгээр/ хязгаарлагдаж байгаа нь "Үг гэдэг навч мэт. Дэндүү их навчтай модонд үр жимс тун бага" байна уу гэж харагдахаар байна.

2. Хөдөлмөрийн хуулийн зорилт нь ***бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөхөд хүргэж байна.*** Тухайлбал, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд зааснаар иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн; /Нийгмийн даатгалын тухай хууль/ Энд мөн л байнгын ажлын байран дээр хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно гэсэн заалтаас ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэхгүй...

3. ***Хэргийн харьяаллын асуудал,*** тухайн салбарт ямар гэрээ байгуулагдаж байна гэдгээс практикт хэргийн харьяаллыг тогтоож байна. Төрийн албаны зөвхөн үйлчилгээний албан тушаалтны хөдөлмөрлөх үйл ажиллагаа нь иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж байна. Энд, төрийн үйлчилгээний албан тушаал нь төрийн албаны ангилалд багтдаг төдийгүй, Үр дүнгийн гэрээг Хөдөлмөрийн контракттай адилтган үзэж болно гэсэн зөвлөмж нь эргэлзээ төрүүлэхээр...

4. Хөдөлмөрийн маргааныг захиргааны хэргийн шүүх, иргэний хэргийн шүүхээр харьяалан шийдвэрлэж байна. Хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбоотойгоор хөдөлмөрийн маргаан нь эрүү, иргэний хэргээс дутуугүй олноор гарч байгаа нь судалгаанаас харагдлаг.[11] Гэтэл шүүхүүд хөдөлмөрийн маргаантай асуудлыг 2-рт тавьж хавсарга төдийхнөөр ойлгож шийдэг нь хөдөлмөрийн харилцаанд иргэд хохирох гол шалтгаан болж байна. Иймд дэлхийн нийтийн жишигт нийцүүлэн манай улсад ***хөдөлмөрийн шүүх*** байгуулах боломжийг судлах нь зүйтэй....

5. **Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, төсөл /2014** он/-д Энэ хуулийн зорилго нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны доод хэмжээг тогтоож, **ажилтан** ба **ажил олгогч** болон тэдгээрийн төлөөлөгчдийн хоорондын хөдөлмөрийн харилцааны зохистой тэнцвэрт байдлыг хангахад оршино. **Хөдөлмөр эрхлэлтийн гэрээ** гэж хувь хүний ажиллах хүчийг хөлслөн ажил олгогчийн удирдлага, хяналт дор ажил үүрэг гүйцэтгүүлэх, хөдөлмөрийн хөлс олгох болон бусад нөхцлийг тухайлан тохиролцон хөдөлмөр эрхлэлтийн харилцааг үүсгэхээр хийсэн тохиролцоог .... Эндээс Хөдөлмөрийн гэрээний нэршил нь өөрчлөгдсөн байх ба гэрээний эрх зүйн үүднээс авч үзвэл гэрээний талууд нь ажилтан, ажил олгогч хэвээр байгаа нь хөдөлмөрийн эрх зүйн зохицуулалтын хүрээг тодорхой төрлийн гэрээгээр хязгаарласан хэвээр ойлгогдож байна.

[11] УДШ, иргэний хэргийн судалгаа 2012,2013 оны харьцуулсан судалгаа / http://www.supremecourt.mn/

# ХУУЛЬ ЗҮЙН СЭТГЭЛ СУДЛАЛ БА НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Б.Цэрэнчимэд
/Шихихутуг ХЗДС-ийн багш, магистр/

Хууль зүйн шинжлэх ухаан болон сэтгэл судлалын шинжлэх ухаан нь ялгаатай боловч хоорондоо уялдаа холбоо бүхий салбар шинжлэх ухаанууд юм. Хуульчийн ёс зүй, хуульч мэргэжлийн ёс зүй зэрэг ойлголтуудаас бид хуульчийн сэтгэл судлалыг салган ойлгох хэрэгтэй. Өнөөгийн нийгэмд хүн бүр ямар нэг хэмжээгээр сэтгэл зүйн дарамт буюу гутралд орж байдаг бөгөөд үүн дотор хуульч бидний хувьд ажлын онцлогоос шалтгаалан сэтгэлийн гутралд орох явдал их гардаг. Энэ үед бидэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын эмчилгээ хийх, тэдний ар гэрийхэнд зөвлөгөө өгөх, дэмжих тогтолцоо байхгүй байгаа нь хүний эрхийг дээдэлдэг МУ-ын хувьд анхаарах ёстой асуудал болоод байна.

МУ-ын хувьд "хууль эрх зүйн сэтгэл зүй", "шүүхийн сэтгэл судлал" гэдэг нэр томьёонууд өргөн хэрэглэгддэг боловч иргэн, захиргаа, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч, тэдгээр ажиллагаанд оролцогчдын сэтгэл зүйг нарийвчлан судалсан, энэ асуудлыг хөндсөн, шинжлэх ухааны түвшинд судалсан судалгаа маш ховор байдаг байна.[1] Гэтэл нөгөө талдаа нийгэм маань хөгжиж энэ шинжлэх ухааныг хөгжүүлэх, судлах шаардлагатайг бидэнд сануулсаар байна. Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор Суурийн Жанцан "Хууль зүйн сэтгэл судлал" нэртэй анхны сурах бичгийг гаргасан нь хууль зүйн шинжлэх ухаанд хуулийн сэтгэл судлалын асуудлыг хөндсөн анхны том бүтээл болсон. Сэтгэл судлалын чиглэлээр олон нэртэй доктор, профессорууд байдаг бөгөөд хууль зүйн сэтгэл судлалыг хөгжүүлэхэд тэдний туслалцаа, хамтын ажиллагаа чухал шаардлагатай байгаа юм.

Сэтгэл судлал гэж юу болох, хүний мэдрэл, тархины үйл ажиллагаа, сэтгэцийн физиологи, хүний ухамсар, бие хүн ба түүний сэтгэл зүй, танин мэдэхүйн процесс ба сэтгэцийн байдал, энэ нь хуульч хүний онцлогт хэрхэн илрэх, хууль зүйн сэтгэл судлал, түүний нийгэм сэтгэл зүйн үндэс, хуульчийн хөдөлмөрийн сэтгэл зүй, хууль ба сэтгэл судлалын холбоо ба ялгаатай байдал, иргэний болон эрүүгийн, захиргааны шүүх хуралдааныг эрхлэн явуулагчдын сэтгэл зүй болон оролцогчдын сэтгэл зүй, тэдгээрийг танин мэдэх арга зам болон тактик, сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч, гэмт хэрэгтэн хүний сэтгэл зүй түүний дотор шунахайн, танхайн, хүч хэрэглэсэн гэмт хэрэг, хүний амь бие эрүүл мэндийн гэмт хэрэг болон давтан, онц аюултай гэмт хэрэгтнүүдийн сэтгэл зүйн онцлогийг судлах арга замыг боловсруулах шинжлэх ухааны түвшинд судлах шаардлагатай байна.

ЭБША нь процессын ажиллагаа байдаг учир хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, мөрдөн байцаах тодорхой ажиллагаануудын сэтгэл зүй,

[1] С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал.УБ., 2001 он,127 дахь тал

байцаалтын үеийн сэтгэл зүй, прокурорын сэтгэл зүй, түүний онцлог болон шүүгч, өмгөөлөгч нарын сэтгэл зүйн онцлог мөн иргэн, захиргааны эрх зүйн харилцаанд оролцогч бүрийн хувьд өөр өөрийн сэтгэл зүйн онцлогтой оролцдог бөгөөд тэдгээрийн онцлогыг судлах, танин мэдэх арга замыг боловсруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа үүний дотор эрүүл мэндийн хувьд хамгаалах нь төрийн төдийгүй хувь хүний үүрэг байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сэтгэл судлал, хорих ангид ял эдэлж байгаа эрэгтэй эмэгтэй ялтан, тэдгээрийн сэтгэл зүйн онцлог болон ял эдлүүлэх байгууллагад ажиллагсадын сэтгэл зүйн онцлог, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ, нөхөн төлбөр, сэтгэл засал болон аюулгүй ажиллах нөхцөл, сэтгэл зүйн хувьд тайван ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг нь сэтгэл судлалын асуудалтай нягт уялдаатай байдаг.

Зарим гадаадын улс оронд тухайлбал АНУ-д хуулийн сургуулиуд нь хуулийн сэтгэл судлалын тэнхимтэй байхаас гадна бие даасан хуулийн сэтгэл судлалаар дагнасан сургуулиуд ч олон байдаг. Жишээ нь: Флоридагийн олон улсын хуулийн сургууль, Невадагийн сэтгэл судлал хуулийн сургууль, Карелтоны хууль сэтгэл судлалын дээд сургууль[2] гэх мэт. АНУ-ын хуулийн сэтгэл судлалын холбоо гэдэг байгууллага байдаг бөгөөд энэ байгууллага нь хуульч, сэтгэл судлаач профессор багш нараас бүрддэг байна. Багш нарт тавигдах шаардлага өндөр байдаг бөгөөд JD,Ph.D зэрэгтэй багш нар хичээл заах шаардлага тавигддаг. Тус улсад хуулийн сэтгэл судлалыг нийгмийн, эмнэлгийн болон танин мэдэхүйн гэсэн 3 чиглэлээр судлан энэ чиглэлүүдийг хууль зүйн шинжлэх ухаантай холбон судалдаг байна.[3]

Энэ асуудлын хүрээнд судлаач миний хувьд дараахь хэд хэдэн саналыг дэвшүүлж байна.

- Хуулийн их дээд сургуулидад мэргэжсэн хуулийн сэтгэл судлаач нарыг бэлтгэж эхлэх
- Цагдаагийн байгууллага болон бусад хууль шүүхийн байгууллагуудад сэтгэл судлаачийн орон тоог гаргаж ажиллуулах
- Тухайн байгууллагууд дээр орон тооны мэргэжсэн хуулийн сэтгэл судлаач ажилласнаар тухайн байгууллагын ажилтан, албан хаагч нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэлийн гутралд орохоос урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн дарамтанд орсон тохиолдолд сэтгэл заслын эмчилгээ хийх
- Хууль хэрэгжүүлэгч нарт бусад оролцогчдын сэтгэлзүйг танин мэдэх арга тактик болон бусад шаардлагатай мэдээлэл, мэдлэгийг өгч, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Сэтгэл судлалын салбарын эрдэмтэн, профессоруудтай хамтран ажиллах замаар хуулийн сэтгэл судлалын асуудлыг шинжлэх ухааны түвшинд хүргэн хөгжүүлэх

---

[2] htte://www. Law psychology of America.org
[3] http://www.en.wikipedia.org/

# ХУУЛИЙН ХЭЛ

Л.Наранзэрэл
Шихихутуг ХЗДС-ийн ахлах багш, Хэл шинжлэлийн ухааны докторант/

Хэл нь хуульд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хууль нь хэлгүйгээр оршин тогтнох аргагүй юм.[1] Өөрөөр хэлбэл хэлээр дамжуулан хуулийн контент, дүрэм журам, шүүхийн шийдвэр, прокурорын яллах төлөвлөгөө (*indictments of prosecutors*) зэрэгтэй танилцдаг. Хууль зүйн дискурс[2], ялангуяа хуулийн контекст (legislative context) нь нэг хэвийн, нарийн түвэгтэй байдлаар нь хүмүүс ойлгодог. Хууль зүйн хэл нь тусгай зорилго бүхий хэл болохынхоо хувьд бусад хэлнээс ялгардаг бөгөөд метафизик феноменийг илэрхийлдэг.

Хуулийн хэлний судалгааг Америкийн болон Европын хэл шинжлэлийн нилээдгүй олон эрдэмтэд хийсэн байдаг бөгөөд түүн дундаа Mellinkoff, Crystal, Davy, Bhatia, Kurzon, Tiersma нарын судлаачид хууль зүйн хэлийг үгийн сангийн, өгүүлбэрийн болон дискурсийн түвшинд судалж хэлний онцлогуудыг нь өргөн хүрээнд судалсан байдаг. Хууль зүйн хэл болон түүний контекст, техникийн хэлний талаар Melinkoff, Caton, Crystal, Davy, Grice нарын судлаачид судалсан, хуулийн хэлний царцанги байдал, шүүх танхим дах хүмүүсийн зан авир болон хандлага, хэлний онцлогуудын талаар Bhatia, Conely нар судалсан бол Tiersma, Bhatia, Kurzon нарын судлаачид хууль зүйн хэлний онцлог, үгсийн сан болон нэр томъёоны судалгаа, хуулийн хэлний ангилалын талаар тус тус дагнан судалсан байна. Хууль зүйн хэлний анхны томоохон судалгааны ажил бол Судлаач Bhatia-н хууль тогтоомжийн текстэд хийсэн судалгаа юм.[3]

Хууль зүйн хэл нь бичгийн болон аман гэсэн үндсэн хоёр хэлбэртэй. Ерөнхийдөө бичгийн хэлбэр нь цаасан дээр буусан референтийн хувьд тогтмол харилцаа юм. Хуулийн хэл нь ихэвчлэн бичгийн хэлбэртэй байдаг.[4] Нөгөө талаас, хууль зүйн хэлний аман хэлбэр нь түр зуурын шинжтэй байдаг ба ярианд буюу мэдэгдэлд хэрэглэгддэг. Дээрх хууль зүйн хэлний хоёр төрөл нь хоорондоо харилцан хамааралтай байна. Хууль зүйн дискурс ялангуяа бичгийн хэлбэр нь хууль зүйн хэлийг томъёолох боломжыг олгодог. Хууль нь хууль зүйн өвөрмөц стильтэй байдаг бөгөөд хуулийн хэлний онцлогийг авч үзвэл мэргэжлийн нэр томъёо их хэрэглэгддэг хураангуй, товч тодорхой, оновчтой байх шинжүүдтэй байдаг. Хамгийн гол нь энгийн (хууль тогтоогчийн санаа нийтэд ойлгомжтой байх ёстой бөгөөд тодорхой, хоёрдмол утгагүй байх явдал юм.

---

[1] Anna Trosborg, 'The performance of Legal Discourse', 1999, p.23

[2] 1. Дискурс гэгч нь тодорхой нэг цаг хугацаа, орон зай, нөхцөлд яригч, сонсогч хоёрын хооронд явагдаж буй харилцааны нэгэн үйлдэл мөн. Энэхүү харилцааны үйлдэл нь аман яриа, бичгийн аль нь ч хэлбэртэй вербаль болон вербаль бус бүрэлдэхүүнтэй байж болно. Д.Хонгорзул, 'Дискурсийн үндсэн ойлголтууд', Улаанбаатар., 2012.х.13
2. Zellig Harris 1952 онд "Discourse analysis" хэмээх нэр томъёог анх хэрэглэсэн бөгөөд тэрээр морфем, клауз болон өгүүлбэрийн шаталсан бүтцийн дарааллын түвшин бол дискурс юм гэж тодорхойлсон.

[3] Dennis Kurzon 'Linguistics and Legal Discourse: Introduction', International Journal for the Semiotics of Law, 1994.p.120

[4] Peter Tiersma, 'The Oxford handbook of Language and Law', Oxford University Press, 2012.p.6

Хуулийн текст гэдэг нь үгээр илэрхийлэн, баримт бичигт буулгасан хуулийн агуулга бөгөөд хуулийн агуулга, хууль зүйн хэм хэмжээний үгэн илэрхийлэл бүрэн, оновчтой төгс байх шаардлагын дагуу зохиогдох ёстой.[5] Хуулийн текстийг зөвхөн ёс төдий, баримт бичгийн чанартай зүйл гэж үзэж болохгүй. Гагцхүү текстийн үг, өгүүлбэрийн тусламжтайгаар хуулийн агуулга нь илэрхийлэгдэж, нийгэмд дэг журмыг тогтоож, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг. Иймд үг, өгүүлбэр, цэг, таслал гэх зэрэг тэмдэг тэмдэглэгээнүүдийг хуульд оновчтой хэрэглэх, зөв байрлуулах нь ач холбогдолтой юм. Хуулийн хэлийг хууль зүйн хэлний бусад домайнуудаас тусад нь авч үздэг.[6] Жишээ нь: шүүх танхимд хэрэглэгддэг хэл, хууль зүйн сурах бичгийн хэл гэх мэт. Хууль зүйн бичгийн хэл нь гэрээ, гэрээслэл, бичмэл хууль ... гэх мэт олон баримт бичгүүдээс бүрддэг.

Хуулийн хэл нь нэр томьёо, хэлний бүтэц, цэг тэмдэг тэмдэглэгээ зэрэг олон тооны өвөрмөц шинжүүдтэй. Ялангуяа хуулийн текст нь техникийн нэр томьёо, үгүйсгэл болон формал үг хэллэг их хэрэглэгддэг, эзэн биегүй өгүүлбэрийн бүтэцтэй, номинализацид их чиглэгдсэн, тодорхой өгүүлбэрийн бүтэц, илэрхийллийн давтамж их байдаг гэх мэт онцлог шинжүүдтэй байдаг.

Аливаа салбар бүр өөрийн гэсэн нэр томьёотой байдаг. Нэр томьёо гэдэг нь хууль тогтоомжын агуулгыг тодорхойлохын тулд хэрэглэдэг аливаа ойлголт, ухагдахууны үгэн илэрхийлэл юм.[7] Хуулийн текстэд гурван төрлийн нэр томьёо хэрэглэгддэг байна.[8]

1. Нийтийн хэрэглээний нэр томьёо буюу нийтэд ойлгомжтой утга бүхий нэр томьёо. Жишээ нь: баримт бичиг

2. Техникийн тусгай нэр томьёо буюу техник, анагаах ухаан, эдийн засаг, хууль гэх мэт тусгай мэдлэгийн салбарт хэрэглэгддэг нэр томьёо. Жишээ нь: депозит, узуфрукт, импийчмент

3. Хуулийн тусгай нэр томьёо буюу эрх зүйн аливаа ойлголтыг илэрхийлсэн хууль зүйн онцгой утга бүхий нэр томьёо. Жишээ нь: барьцаа, эзэмшил, анз, дэнчин

Техникийн болон хууль зүйн тусгай хэл нь мэргэжлийн хүмүүс хоорондоо харьцах хэл юм. Үүнээс гадна хуулийн нэр томьёог дан ганц ярвигтай үг хэллэгээр хязгаарлаж болохгүй юм. Хуульнд хэрэглэгдсэн үг хэллэг нь өнгөц харахад нийтийн хэрэглээний ердийн үг мэт боловч цаанаа хууль зүйн тусгай утгыг илэрхийлсэн заримдаа нийтээр ойлгодог утгаасаа өндөө агуулгатай байх ч тохиолдол байдаг. Жишээ нь: Өмч гэдэг нь өдөр тутмын хэлний энгийн утгаасаа илүү хууль зүйн хэлэнд харилцаа гэсэн өөр тусгай утгаар хэрэглэгддэг.

[5] С.С.Алексеев, 'Төр ба эрх зүй', Улаанбаатар., 2004.х.108
[6] Anna Trosborg 'Rhetorical Strategies in Legal Language',1996,p.14
[7] Heikki Mattila, 'Comparative Legal Linguistic', London., 2006,p.108
[8] Д.Баярсайхан, 'Хууль бүтээх үйл ажиллагаа', Шихихутуг эрх зүйн шинжлэх ухааны онол, арга зүйн сэтгүүл, Улаанбаатар., 2001.х.14

Хуулийн Англи хэлэнд Латин, Франц хэлний нөлөө их байдаг. 1066 онд Нормандуудын булаан эзлэлтийн дараа Англо-Норман, Франц хэл нь Английн албан ёсны хэл болсон ба 300 гаруй жилийн турш хэрэглэгдсэн байдаг. Орчин үеийн хууль зүйн Англи хэлэнд Англо –Норманаас үүсэн маш олон үг хэрэглэгддэг. Жишээ нь: property, estate, lease, tenant

Түүнчлэн Латин хэлний *ad hoc*, *de facto* гэх мэт олон үг хэллэг өнөөг хүртэл хуулийн бичгийн хэлэнд хэрэглэгдсээр байна.

Орчин үед хэл шинжээчид хууль зүйн хэлнийг түүн дундаа форенсик[9] (forensic linguistic) хэл болон хуулийн дискурсийг сонирхон судалж байна. Форенсик хэл нь хэрэглээний хэл шинжлэлд багтах бөгөөд хэл, хууль болон гэмт хэргийн хоорондын харилцааг энд хамааруулан авч үздэг. Хуулийн дискурс нь ярианы болон бичгийн харилцааг илэрхийлдэг нэр томъёо юм. Энэ хүрээнд шүүхийн дискурс, хууль тогтоомжийн дискурс ... гэх мэтийн дагнасан судалгаанууд хийгдсээр байна.

Дүгнэлт

Эндээс товч дүгнэхэд хуулийн хэлний онцлог нь нэр томъёоны бүхий л шинжүүдийг агуулж байдаг ба мэргэжлийн нэр томъёо их хэрэглэгддэг, хураангуй, товч тодорхой, оновчтой байх шинжүүдтэй. Хуулийн хэл нь норматив болон зааварласан шинж чанартай байна. Хуулийн хэлнийг судлах нь онолын төдийгүй практик ач холбогдолтой болох нь илэрхий билээ. Хууль зүйн хэл нь манай орны хэл шинжлэлийн шинжлэх ухаанд төдийлөн судлагдаагүй бөгөөд энэ удаад өнгөц авч үзсэн болно.

[9] Black's law Dictionary. Editor in chief Bryan A. Garner. Ninth edition (2009) p.721 Бичгийн буюу аман харилцааны хэлний онцлогуудыг үнэлж, дүгнэдэг шинжлэх ухаан буюу техник



# ОЛОН НИЙТИЙН ӨМЧЛӨЛИЙН КОМПАНИ /GSOC/-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АНУ-ЫН АЛЯСКА МУЖЫН ТУРШЛАГА

М.Түвшинжаргал
*/Бүгд Найрамдах Турк улсын* Эржиес Их
Сургуулийн докторант/

**Удиртгал**

Дэлхий дахинд сүүлийн үед шинээр бий болж байгаа өмчлөлийн өөр нэг хэлбэрийн хандлага бол бүх нийтийн буюу ард түмний өмч гэсэн ойлголт юм. Өнөөдөр зарим орнуудад олон нийтийн өмчлөлийн компаниуд[1] хэдийн бий болжээ. Эдгээр компаниуд хүний оролцоогүй бүй болсон баялаг буюу уул ус, ой мод, бэлчээр, ашигт малтмал зэрэг баялгийг ашиглах, эдийн засгийн эргэлтэнд оруулахтай холбогдон бий болдог байна. Харин хүний оюун ухааны үйл ажиллагааны үр дүнд бий болсон бусад баялаг, түүнийг эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагаа голдуу хувийн өмчид тулгуурлаж байна. Монгол Улсын хувьд ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт 2002 оны байдлаар нийт экспортын 50 орчим хувийг эзэлж байсан бол өнөөдөр 90 орчим хувийг эзэлж байна.

***2012 оны төсөвт уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас 1,669.5 тэрбум төгрөгийн орлогыг төсөвлөсөн нь нийт тэнцвэржүүлсэн орлогын[2] 42 хувийг эзэлж байна.*** Энэхүү уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын нийт орлогын 925.1 тэрбум төгрөг буюу 55 хувь нь нүүрснээс орох орлого байна.[3] Эндээс үзэхэд 2012 оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд зэсийн орлого бус нүүрсний орлого тэргүүлж байна. Энэ нь манай улсын гол тулгуур салбар бол уул уурхай болсон нь харагдаж байна. Ашигт малтмалаас орж ирж байгаа мөнгөн хөрөнгийн урсгалыг зөв зохистой ашиглаж чадаагүйгээс “баялгийн хараал”[4] тусаж эдийн засгийн хямралд орох, байгалийн баялгийг тэгш шударга хуваарилаагүйгээс байгалийн баялгийн ашиг нийт хүн амын цөөнх хэсэгт төвлөрч баялгийн шударга бус хуваарилалт бий болдог байна.

---

[1] Транс Аляскийн нефтийн Trans-Alaska Pipeline System /TAPS/ сувag дээр үйл ажиллагаа явуулдаг Аляскийн нийтийн өмчлөлийн компани /Alaska General Stock Ownership Corporation/ AGSOC, Канад улсад үйл ажиллагаа явуулдаг 2.1 сая хувьцаа эзэмшигчтэй British Columbia Resource Investment Corporation /BCRIC/ тус тус нэртэй болно.

[2] Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого гэдэгт зэс болон нүүрснээс төвлөрөх орлого хамаарч байна.

[3] www.nso.mn 2012 оны Улсын төсвийн эдийн засгийн үзүүлэлт, тайлан судалгаа

[4] “Баялгийн хараал” гэсэн нэр томьёо дэлхий нийтэд саяхнаас ашиглагдаж эхэлсэн болсон бөгөөд газрын доорх асар их баялагтай мөртлөө удирдлагын муугаас дэлхийн хөгжлийн сүүл барьдаг Заир, Зимбабве, Гвиней зэрэг олон орнуудыг хамааруулан хэрэглэж байна. /Катрин Берессман нь баялгийн хараалд өртсөн орны судалгааг дагнан хийсэн судлаач/

Ашигт малтлын орд газраас орж ирж байгаа мөнгөн хөрөнгийг зөв зохистой ашиглаж эдийн засгийн эргэлтэнд оруулах, баялагийн тэгш хуваарилалтыг зүй зохистой хангах нь хамгийн чухал юм. Иймд ашигт малтмалын орд газар дээр тулгуурласан үндэсний хэмжээний компани байгуулах, эрх зүйн орчинг судлах нь зайлшгүй шаардлагатай асуудлуудын нэг юм.

## I. Олон нийтийн өмчлөлийн компанийн нэр томъёоны асуудал.

Олон нийтийн өмчлөлийн компанийн нэр томъёог тайлбарлаж үзвэл /General Stock Ownership Corporation -GSOC анг.хэл/, /Общие корпораци акционерной собственности ор.хэл/ хөрвүүлэгдэж байна. General - гэдэг үгийг бүх нийтийн, ерөнхий гэж хөрвүүлж болно.[5] Зарим үгийн орчуулгын хувьд General гэдэг үгийг ерөнхий суурь бүхэллэг гэж хөрвүүлэх тал байдаг. Иймд Public гэх нэр томъёо тохиромжтой гэж үздэг.

### 1.1 Нийтийн өмчлөлийн компани /GSOC[6]/ бүрэлдэн бий болсон шалтгаан:

GSOC байгуулах болсон гол шалтгаан бол нийгмийн баялагийг бүх ард түмэн, олон нийтэд тараах үзэл дээр тулгуурласан. Өөрөөр хэлбэл нийтийн өмчлөлд хувийн өмчийн эзлэх байр суурийг бий болгох энэ нь цаашлаад GSOC-ийг бий болгох шалтгаан болсон юм.[7] GSOC нь төрийн активыг[8] ард түмэндээ хүртээх нэг арга гэж үздэг бөгөөд GSOC нь баялагт хандах төрийн, хувийн хэвшлийн болон иргэдийн ашиг сонирхлыг хангаж байдаг[9].

1976 оны 1 сарын 1-ний байдлаар АНУ-ын үндэсний баялагийн хэмжээ 5,7 треллион ам.доллар байсан. Энэ баялагийг АНУ-ын иргэнд хуваж үзвэл нэг иргэнд 26.511 ам.доллар ноогдож байсан. Гэтэл үүнийг АНУ-ын иргэд эзэмших эрх зүйн хийгээд бодит боломж нөхцөл тухайн үед байгаагүй байна. Улмаар энэ нь АНУ-д баялагийн тэгш бус байдлыг бий болгоход нөлөөлсөн юм.[10] Ингээд нийт хүн амын баян чинээлэг хэсэгт үндэсний баялагийн эзлэх хувь ихсэж, байгалийн баялагийн ашиг нийт хүн амын ердөө нэгхэн хувьд төвлөрч байсан. АНУ тухайн үед баялагийн тэгш хуваарилалтыг бий болгож чадаагүй юм. **Тухайлбал:** АНУ-ын бүх гэр бүлийн талаас илүү хувьд нь улс орны бүх баялагийн хүртэх хувь нь 1 доллараас зөвхөн 3 цент хүртэж байсан байна. Ингээд АНУлс GSOC-ийг бий болгох зүй ёсны шаардлага урган гарсан байна.

Улмаар Холбооны засгийн газраас GSOC-ын эрх зүйн орчин бий болгох шат дараатай арга хэмжээ авснаар корпорацийн гаргадаг үнэт цаасны ихэнх хэсгийг АНУ-ын гэр бүлийн санхүүгийн гол хөрөнгө болж хувирсан юм. Ингээд 1971 оны байдлаар АНУ-ын гэр бүлийн байгалийн баялагаас хүртэх

[5] Bryan A.Garner "Black`s law Dictionary" Ninth Edition
[6] General Stock Ownership Corporation цаашид /GSOC/ гэж товчилж бичив.
[7] R. Goldsmith "The national wealth of the united states in the postwar period" 62 (1962); Bus., Nov. 1974, at 16.
[8] Актив гэдэг нь хэрэглэгдэх салбараас хамаараад өөр өөр байдлаар тайлбарлагдах боловч энэ тохиолдолд хөрөнгө гэж үзэв.
[9] Jerry N.Gauche "General stock ownership Corporations: Another step in Broadening capital Ownership" Nov. 2009, at 16.
[10] 1860 оны байдлаар хүн амын баян чинээлэг хэсэг нь нийт хүн амын 26 хувийг эзэлж байсан. 1969 он гэхэд энэ хувь 24 хувь болж буурсан байна. 1925 оноос АНУ үндэсний баялагийн баян хүмүүст эзлэх хувийг багасгах бодлого барьж эхэлсэн.

хувь нь бүх байгалийн баялагийн ашгийн 48 хувийг ногдол ашиг хэлбэрээр хүртдэг болсон байна[11].

Ингээд корпорацийн гаргадаг үнэт цаас нь АНУ-ын иргэдэд хөрөнгө хуваарилах гол арга болж хувирсан. **1976 онд АНУ-ын Конгрессын Эдийн засгийн хорооноос гаргасан тайланд:** Хувийн хөрөнгийг нэмэгдүүлэх бодлогыг үндэсний хүрээнд зорилго болгон дэвшүүлэн тавьсан байна. Ингээд GSOC нь иргэдийн хөрөнгийг нэмэгдүүлэх, томоохон хөтөлбөр болсон байна. GSOC-ийг байгуулахын тулд төрийн зүгээс заавал бодитой шаардлага байгаа эсэхийг мэдэх зүй ёсны шаардлага урган гарч ирсэн. Өөрөөр хэлбэл ард нийтийн санал асуулга авах нь төрийн байгууллагын шийдвэр гаргах хувилбар болсон.[12]

Мөн нийгэм дэх баялагийн тэгш бус хуваарилалт нь улс орны хөгжил, ардчилалд сөрөг нөлөө үзүүлдэг.[13] Иргэдийн бодит орлого доогуур дундаж байгаа нь хөрөнгийг дахин хуваарилах, хөрөнгийг нийтэд хүртээмжтэй хуваарилаагүйтэй шууд хамааралтай. Байгалийн баялаг, түүний үр шим бодит хөрөнгө нь төрийн мэдэлд байх нь тийм ч үр ашигтай биш. Энэ нь баялагийн тодорхой хувийг иргэдэд шууд эзэмшүүлэх боломжийг хязгаарладаг. Ингэснээр мөнгөн хөрөнгийн хэмжээ нэг хэсэгт төвлөрч эдийн засагт мөнгөн хөрөнгө үхмэл хэлбэрт орох юм.[14] Тодруулбал:

АНУ-аас төрийн томоохон компанийн хөрөнгийг хувьд шилжүүлэх, ялангуяа нефьтийн салбарын хөрөнгийг хувьд шилжүүлэх асуудал АНУ-д XIX зууны дунд үеэс эрчимтэй өрнөсөн. Иргэдэд баялагийг шууд эзэмших боломж олгох нь зайлшгүй зүйл бөгөөд тухайн үед Холбооны засгийн газрын зүгээс Synfuels International INC[15] корпорацийн хөрөнгийг хуваарилахад иргэдийн оролцоог альтернитев буюу сонгох хувилбартайгаар хувь хэмжээ хүртэх боломжийг бүрдүүлсэн. Энэ нь Synfuels International INC компанийн ажилчид болон ард түмэн баялагийн шударга хуваарилалтыг бий болгох шаардлага тависантай шууд холбоотой юм. Энэ нь шууд ардчиллыг бий болгосон хамгийн чухал үйлдэл байсан гэж үздэг. [16]

## 1.2 Нийтийн өмчлөлийн компанийн /GSOC/ үүсэл ба Employee Stock Ownership Plans: [17]

Employee Stock Ownership Plans[18] нь корпорациас ажилчдад санхүүжүүлэлт хийх нэг хувилбар гэж үздэг.[19] Энэхүү онол бол бүх ажилчдад компанийн хувьцааг адил тэгш эзэмших боломжийг бий болгож өгдөг. Энэ нь тухайн зах зээлд компанийн өрсөлдөх чадварт эерэгээр нөлөөлдөг байна. Учир нь

[11] 1976 Joint Economic Report, s. rep. no. 690,94th cong., 2d sess. 100 (1976) /www.lexis-nexis.com/
[12] Тухайн үед Аляскийн баялагийн сан байгуулах талаар ард нийтээс санал асуулга авч байсан.
[13] Luis.O. Kelso & M. Adler, "The Capitalist Manifesto" 226-27 (1958)
[14] Мөн тэнд
[15] Synfuels International INC нь байгалийн хийг боловсруулах, нефьтийн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байна.
[16] Luis.O. Kelso & M. Adler, "The Capitalist Manifesto" 226-27 (1958)
[17] Цаашид ESOP гэж товчилж бичиг.
[18] ESOP гэдэг нь корпораци ажилчдадаа хувьцаа гаргах хэлбэр гэж үздэг. Энэ нь хэтэд түгээмэл тогтсон арга бөгөөд гол санаа нь корпораци ажилчиддаа таниж мэдэх, тэдэнд итгэл төрүүлэх боломжийг бий болгож өгдөг. Ажилтан тэтгэвэрт гарсан тохиолдолд ч хувьцааг эзэмших боломжтой байдаг нь давуу тал бөгөөд хувьцааг шилжүүлэх тохиолдолд татвараас чөлөөлөх, шимтгэл төлөхгүй байх боломж олгодог байна.
[19] Эдийн засагч Luis O.Kelso нь ESOP-ийн онолыг анх гаргаж практикт хэрэгжүүлж ирсэн судлаач юм.

компанийн хувьцаа, хөрөнгө илүү найдвартай бас үнэ цэнэтэй байдаг байна. Энэ боломжийг ажилчны хувийн эрх буюу өмчлөх эрх болон компанийн нийгмийн хариуцлага, зорилготой холбож үздэг.[20]

Компанийн хувьцааг ажилчдад тарааж байгаа нь бодит хөдөлмөр гэж үздэггүй харин компанийн хөрөнгө баялгийг эзэмшиж буй санаа юм. Өөрөөр хэлбэл энэ орлого нь капиталыг ашигласнаас бий болсон орлого юм гэдгийг ажилчдад ойлгуулдаг байна.[21]

Улмаар 1950 оноос эхлэн ESOP нь компаниудын дунд түгээмэл арга болж ирсэн байна. Каллифорнын мужийн "Азотын Хөндий"[22] гэх нэртэй компани анх удаа ESOP-ийг практикт хэрэгжүүлж ирсэн юм. Ингээд 1973 онд АНУ-ын Конгресс зүгээс ESOP –ийг хүлээн зөвшөөрч тухайн үед Regional Rail Reorganization Act буюу "Төмөр замыг өөрчлөн байгуулах бүс нутгийн тухай"[23] хуулийг гаргасан. Мөн 1973 оноос эхлэж ESOP-ийн татварын эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

GSOC нь ESOP-н арга дээр тулгуурлаж бий болсон хэлбэр гэж үздэг байна. Тодруулбал: ESOP бол компанийн активын тодорхой хувийг ажилчдад буюу хувьд өгдөг бол GSOC нь төр өөрийн иргэддээ баялгаа хуваарилах, цаашид ашиглах үр дүнг бий болгодогоороо гол ялгаатай байна.[24]

### 1.3 **GSOC** тавигдах шаардлага шалгуур:

GSOC-н хувьцааг тараасныас хойш 5 жилийн хугацаанд худалдах, арилжаалахыг хориглосон байдаг. Дээр тогтоосон хугацаанд GSOC-д тодорхойгүй хугацаагаар татвар ногдуулж байсан. Уг зохицуулалтын гол агуулга нь компанийг зохион байгуулалтын тодорхой шаардлагыг хангуулах зорилготой байсан.

Уг шаардлага шалгуур нь гол төлөв компанийн үйл ажиллагааны хүрээнд тавигдаг. **Тодруулбал:**




[20] Jerry N.Gauche "General stock ownership Corporations: Another step in Broadening capital Ownership" Nov. 2009, at 16.
[21] For a detailed discussion of Employee Stock Ownership Plans (ESOP's), see A Symposium on Employee Stock Ownership Plans, 26 AM. U.L. REV. 515 (1977).
[22] Valley Nitrogen буюу Азотын Хөндий компани.
[23] Regional Rail Reorganization Act хуулиар төмөр замын ажилчдад хувьцаа тараах буюу ESOP хэлбэрийг хэрэглэж болохыг зөвшөөрсөн байна.
[24] Luis.O. Kelso & M. Adler, "The Capitalist Manifesto" 226-27 (1958)

Одоо дээрх шалгуур хязгаарлалтуудыг тухайлан авч үзвэл:

### 1.4 GSOC-ийн дүрэмд тавигдах шаардлага:

GSOC-ийг албан ёсны дүрэмтэй байхыг төрөөс шаарддаг. Уг дүрэмтэй байх нь төрийн албан ёсны бодлого гэж үздэгтүй ч хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах зүй ёсны шаардлага гэж үздэг байна. GSOC –ийн дүрэм бол үүсгэн байгуулах гэрээний адил хууль зүйн хүчин чадалтай баримт бичиг юм. GSOC-ийн дүрэмд дараах зүйлийг тусгахыг шаарддаг.

***GSOC-ийн дүрэмд тавих шаардлага***

| | |
|---|---|
| | 1. Хувьцааг гаргах, шилжүүлэхтэй холбоотой зүйлийг дүрэмд заавал тусгасан байхыг шаарддаг байна. GSOC –ийн дүрэмд корпорацийн гаргах хувьцааг тусгай зориулалт бүхий багц хувьцааг гаргах боломжтойг тусгасан байдаг.[25] Энэ нь GSOC-с насанд хүрээгүй хүнд хувьцаа тараах асуудлыг хөндөхөд хүргэдэг.<br><br>АНУ-ын ихэнх муж улсын хуулинд насанд хүрээгүй хүмүүст хувьцаа тараадаггүй зохицуулалт байдаг. Учир нь насанд хүрээгүй хүн хувьцаатай холбоотой санал өгөх эрх зүйн чадваргүй гэж үздэг байна. GSOC-ийн дүрэмд насанд хүрээгүй хүмүүст хувьцаа эзэмших асуудлаар тусгайлсан хуулиар нарийвчлан зааж өгнө гэж заасан байхыг шаарддаг. Эрх зүйн зохицуулалтын гол агуулга нь насанд хүрээгүй хүнд хувьцаа худалдах, ашиг орлого олох асуудалд эцэг эхийн тусламжтайгаар шийддэг юм.[26] |
| | 2. GSOC нь анхны хувьцаагаа гаргахдаа хүн бүрт нэг удаа байх зарчим баримтлах ба хувьцаа гаргаснаас хойш 1 жилийн дотор хувьцаагаа аваагүй бол сангийн хөрөнгөөс хувь хүртэх эрхгүй гэж дүрэмд тусгахыг шаарддаг. |
| | 3. GSOC нь хувьцааг тэнцүү ижил тоогоор хувьцаа авах эрх бүхий хүмүүст тараадаг. Хувьцаа гаргаснаас хойш 5 жилийн хугацаанд хувьцааг худалдах арилжаалахыг дүрэмдээ хориглодог.<br><br>GSOC нь 5 жилийн хязгаарлалтын хугацаан дотор ногдол ашиг хуваарилаж болох ба энэ хугацаанд хувьцаа эзэмшигч нь өөрөө ногдол ашиг авах, хөрөнгийн зах зээлийн талаарх туршлага мэдлэгтэй болгох боломжит цаг хугацаа юм. Мөн дээрх хугацааны хязгаарлалтын ач холбогдол нь шинэ хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмших, шинэ төрлийн хөрөнгө оруулалтын хэлбэрийг судлах боломж олгодог. |

[25] Хоёр дахь багц хувьцаа нь зөвхөн насанд хүрээгүй иргэдэд зориулсан байдаг.
[26] Хоёр дахь багц хувьцааг эзэмших асуудлыг насанд хүрээгүй хүмүүсийн тухай хуулиар нарийн зохицуулсан байдаг.

| | |
|---|---|
| GSOC-ийн дүрэмд тавих шаардлага | 4. Тухайн орны иргэний харьяалалтай оршин суугч этгээд өөр гадаадын этгээдэд хувьцаа борлуулж болохгүй ба харьяалалгүй, түр оршин суугчид мөн зарахыг хориглодог байна.[27] |
| | 5. Хэрэв хувьцаа эзэмшигч харьяалал сольвол хувьцаа эзэмших эрхийг халгалж үлдэх боломж олгодог. Энэ нь харьяалал сольсон ч тухайн үндэсний хүн гэж үздэгтэй шууд холбоотой. Хувьцааг арилжаалах 5 жилийн хязгаарлалт дууссан тохиолдолд бусдад худалдах эрх нээгддэг.[28] |
| | 6. GSOC-ийн хувьцаа нэг этгээдэд хэт төвлөрхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хувьцааг бусдад шилжүүлэхдээ 10-аас илүү багц хувьцааг нэг иргэн шилжүүлэхийг хориглодог. Энэ зохицуулалтын ач холбогдол нь GSOC нь иргэдийн орлогыг нэмэгдүүлэх нөгөөтэйгүүр удаан хугацаанд нэг этгээдэд хөрөнгө удаан төвлөрхөөс сэргийлдэгтэй холбоотой. |

### 1.5 GSOC-ийн хувьцаа эзэмших этгээдэд тавигдах шалгуур:

GSOC-ийн хувьцааг авах эрхтэй этгээд нь тухайн улсын харьяалалтай мөн тухайн орон нутагт байнга оршин суугч байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл Холбооны улсын хууль тогтоомжоор хувьцааг тараах тухайн цаг үед оршин сууж байсан иргэний харьяалалтай иргэд хувьцаа эзэмших зөвшөөрөл олгодог гэсэн үг.

### 1.6 GSOC-ийн бусад хязгаарлалт:

GSOC нь бусад компанийн гишүүн болон компанийн нэгдэл хэлбэртэй байж болдоггүй. Мөн аливаа нэг компанийн охин болон хараат компани байхыг хориглодог. Учир нь GSOC нь өөр компанийн гишүүн болвол хувьцаа нь үнэ цэнэгүй болох эрсдэлтэй байдаг. GSOC нь өөр компанийн хувьцаа эзэмших нь түүний статусыг алдагдуулж татварын асар их сөрөг үр дагаврыг бий болгодог.

## 2. АНУ-ын Аляска мужийн туршлага, эрх зүйн зохицуулалт

### 2.1 АНУ-ын Аляска мужийн AGSOC туршлага:

Анх 1978 онд АНУ-ын Конгрессын баталсан "Улсын татварын тухай хууль"[29]-ийн U[30] хэсэг буюу дэд бүлэгт AGSOC-ийн эрх зүйн байдал статусыг тодорхойлсон байдаг. Энэ нь АНУ албан ёсоор AGSOC-ийг хуулийн этгээд тэр дундаа ашгийн төлөө корпораци гэж үзэн татвар авах ёстой албан ёсны субъект гэж тооцсон явдал юм.[31]

[27] Jerry N.Gauche "General stock ownership Corporations: Another step in Broadening capital Ownership" Nov. 2009, at 16.
[28] Мөн тэнд
[29] Internal Revenue Code цаашид /IRC/ гэж товчилж бичив.
[30] IRC нь товчилсон бүлэгтэй бөгөөд U хэсэг нь 1300-1450 дахь хэсгийг багтаадаг.
[31] Хуулийн этгээдийг ашгийн төлөө бизнес эрхлэгч гэж үзэх тавигдах шалгуур
-Тогтвортой байх шинж: Энэ нь ашиг олох үйл ажиллагаа нь тогтвортой байхыг ойлгоно. Өөрөөр хэлбэл бүртгэгдсэн байхыг хэлнэ.
- Ашгийн байх гэдэг нь хуримтлал үүсгэж байхыг хэлнэ. Ашиг аргацаасан шинжтэй бол ашгийн төлөө гэсэн ойлголтонд хамаарахгүй
-Албан татвар төлдөг байх.

IRC-ийн U бүлэгт корпораци нь ашиг олох, ашиг хүртээх, орлого хуваарилахад татвар ногдуулдах асуудлыг зохицуулж өгсөн ба корпорацийн ашиг хуваах үйл ажиллагаа нь тусгай дүрэм журамтай байхыг шаардсан байдаг.[32]

**Тодруулбал:**

Алъяска мужд GSOC байгуулах талаар санал хэлэлцэгдэж хууль санаачилж байжээ. Алъяска мужд "Аляскийн иргэдийн олон нийтийн өмчлөлт корпораци" */Alaska General Stock Ownership[33]/* байдаг ба тус корпораци нь Транс Аляскын Нефьтийн */Trans-Alaska Pipeline System[34]/* суваг дээр үйл ажиллагаа явуулдаг корпораци юм.[35]

Аляскын хуулинд төр тухайн компанийн хувьцааг тараахад баталгаа гаргаж өгдөг. Энэ нь корпорацийн хувьцааг эдийн засгийн баталгаат хамгаалалттай болгох цаашлаад корпорацийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр тогтвортой байлгах бодлого юм. Мөн AGSOC нь иргэдэд хөрөнгө оруулалт хийх боломж өгдөг нь давуу талтай юм.

Транс Аляскын Нефьтийн сувгийн дамжуулах хоолой нь ашигтай ажилладаг ба AGSOC нь өөрийн иргэддээ байгалийн баялагийн үр шимээс хүртээх боломжтой нөхцлөөр хангасан байдаг байна.[36] AGSOC-г байгуулах өөрийн иргэддээ байгалийн баялагийн үр шимээс хүртээх боломжтой нөхцлийг судлаж анхлан санаачилсан хүн бол эдийн засагч Луис О. Кельсо юм.

**2.2 Алъяска мужийн AGSOC-ын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа:**

AGSOC-ийг мужийн хууль тогтоох байгууллагаас зөвшөөрөл олгож байгуулдаг. Үүсгэн байгуулагчдыг мужийн эрх бүхий албан тушаалтнуудаас томилох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл гэж нэрлэнэ. Хууль тогтоох байгууллагаас тогтоосон өдөр Алъяскийн оршин суугч байсан эрэгтэй, эмэгтэй, хүүхэд хэн ч байсан тус компанийн нэг хувьцааны эзэн болно. Үүнд ямар нэгэн төлбөр байхгүй.

Компани үүсгэн байгуулагдмагцаа мужаас бие даан үйл ажиллагаа явуулна. Компани нь банк, даатгалын компани болон бусад томоохон хөрөнгө оруулагч байгууллагуудаас зээл авч болдог. Зээлдүүлэгч нь компанид оруулахаар санал болгосон хөрөнгө оруулалт болон компани өөрөө санхүүгийн байдалдаа баталгаа гаргасны үндсэн дээр зээл олгоно.

Компанид оруулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт бүтэлгүйтвэл зээл олгогч хувьцаа эзэмшигчээс зээлүүлсэн мөнгөө буцаан авах боломжгүй бөгөөд компанийн зүгээс өөрөө барагдуулахыг хүлээнэ. Компани авсан зээлээ Алъяскад үр ашигтай хөрөнгө оруулалт, нийгмийн сайн сайханд зарцуулна.

[32] Дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тусгав
[33] Цаашид AGSOC гэж товчилж бичнэ.
[34] Цаашид TAPS гэж товчилж бичнэ.
[35] Транс Аляскийн Нефьтийн суваг нь анх 1974-1977 онд байгуулагдсан бөгөөд байгалийн баялагийн нөөцөөрөө эхний арват ордог томоохон орд юм.
[36] AGSOC нь Алъяскад үйл ажиллагаа явуулдаг Нефьтийн 8 томоохон компанийн хэлтгүүсэн байдаг бөгөөд корпорацийн хувьцааг аляскын ууугууд иргэд эзэмшдэг байна.

### 2.3 Алъяска мужийн AGSOC-ын хувьцаа, түүний ногдол ашиг

Компанийн олсон орлогод орлогын татвар оногдуулдаггүй. Зээл олгогчид буцаан олгоход шаардагдах хэмжээнээс илүү гарсан орлого нь компанийн үндсэн ашиг болдог. Уг ашгийг Алъяскийн хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцааны үндсэн дээр хуваарилах бөгөөд хувьцаа эзэмшигч бүрт ногдол ашгийг гэрчилсэн чекээр төлнө. Хуулийн дагуу компанийн бараг бүх ашиг (доод тал нь 90%) хувьцаа эзэмшигчдэд шилжинэ. Компанийг өрөө төлж барагдуулах үед хөрөнгө оруулалтаас олсон бүх орлого ногдол ашгийн хувиар хувьцаа эзэмшигчид шилжинэ.

Алъяскийн нөхцөлд улс төрийн харъяалал бүхий бүх иргэн компанийн хувьцаа эзэмшигч байна гэж үздэг. Эндээс юуны түрүүнд хоёр асуудал үүсдэг.

**Үүнд:** 1. Нийтээр хувьцаа өмчлөх компани байгуулагдсаны дараа төрсөн буюу иргэний харъяалал олж авсан муж улсын иргэдийн өмчлөлийн оролцоог хэрхэн хангах; 2. Мужаас гадагш шилжин суурьшсаны улмаас иргэн байхаа больсон хувьцаа эзэмшигчдийн тухайд юу хийх. AGSOC нь анхны саналаар шилжиж байгаа хувьцаа эзэмшигчийг хувьцаагаа өөртөө хадгалах эсвэл бусад боломжтой хувьцаа эзэмшигчдэд худалдахыг зөвшөөрдөг байна.

AGSOC-н татвар төлөхөөс өмнөх ашгийн 90%-ийг хувьцаа эзэмшигчид хуваарилахыг шаарддаг. Нэгдсэн улсын хууль нь 5 жилийн дотор хувьцааны шилжүүлгийг хориглох боловч уг хугацаанд хувьцаа эзэмшигч нас барсан, мужаас өөр газар шилжих бол уг хувьцааг худалдах шаардлага үүсгэ.

Ийм шаардлага үүссэн бол худалдагч тал нь эрх бүхий худалдан авагчийг хайх хүргэл батлан **даалтын санд шилжүүлнэ**. Уг таван жилийн хооронд компани нь худалдахаар хүсэлт гаргасан хувьцааг худалдан авах давуу эрх эдэлнэ. Нэгдсэн улсын хуулиар уг таван жилийн дотор AGSOC хувьцааг барьцаалах, дэнчин болгох, түүнээс бусад үүргийн баталгаа болгохыг хориглоно.

5 жилийн шилжүүлгийг хязгаарласан хугацаа өнгөрч, насанд хүрээгүй хувьцаа эзэмшигч нь насанд хүрсэн бол AGSOC-ын хувьцааны цэвэр хөрөнгө оруулагчийн зах зээл нээгдэнэ.

AGSOC нь цэвэр ашгийн багадаа гэхэд 90%-ийг ногдол ашиг болгон жил бүр хуваарилахыг шаардах болохоор Нэгдсэн улсын хууль нь энэхүү компанийн хувьцаа эзэмшигчид хамгийн дээд зэ хөрөнгийн эрхийг олгосон. Хэрвээ ашиг хуваарилах бол ногдол ашгийг тогтоосон хугацаанд олгох, орлогын эх үүсвэрийг заах ёстой. AGSOC нь хагас жил тутамд хуралдаж, түүний тухай яаралтай хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

### 2.4 AGSOC-ийн эрх зүйн орчин ба холбогдох хууль тогтоомж

Алъяска мужийн Сенатч Майк Гравел 1979 онд Алъяск мужийн Засгийн газартай уг асуудлаар яриа хэлэлцээр өрнүүлж эхэлсэн ба эрх олгож байгаа

хуулийг Аляска мужийн Сенат болон Танхимд танилцуулсан боловч батлагдахад шаардлагатай дэмжлэгийг авч чадаагүй. 1980 онд Аляскийн олон нийтээр өмчлөлийн компанийн тухай хууль батлах дараагийн санаачлага мөн үр дүнд хүрээгүй. Гэвч энэ нь ерөнхий хувьцаа эзэмших тогтолцоо нь үнэндээ хэрэгжиж байсан тохиолдол болохоор AGSOC-н өргөн барьсан саналыг энэхүү тогтолцооны үндсэн эх сурвалжийн нэг гэж үздэг.

Иймд АНУ-д олон нийтийн өмчлөлийн компаний харилцааг тусгайлан зохицуулсан төрөлжсөн хууль байдаггүй байна. Харин салбарын хуулиудаар зохицуулдаг байна. **Жишээ нь:**

1933 оны Холбооны улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулиар GSOC нь үнэт цаас худалдах, борлуулах,худалдаж авах харилцааг зохицуулсан. GSOC-д тавих шаардлага, хязгаарлалтыг тусгаж өгсөн

1934 оны "Үнэт цаасны болон биржийн худалдааны тухай" хууль тогтоомжоор хөрөнгө оруулагчдын талаарх тусгайлсан журам мөрдүүлж ажиллах, Мөн GSOC-ийг хянах "Үнэт цаас биржийн комисс"-ийн эрх зүйн байдлыг тогтоожээ.

1940 оны "Хөрөнгө оруулалтын компанийн тухай" /The Investment Company Act/ хууль, тогтоомжоор хөрөнгө оруулалтын компаниуд өөр бусад компанид ямар төрлийн үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийж болох талаарх мэдээллээ заавал бүртгүүлж болох талаар хуульчилжээ. GSOC нь хувьцаа гаргахдаа Үнэт цаас биржийн комисст бүртгүүлэхийг заавал шаарддаг байна.




**GSOC** ба 1933 оны Холбооны улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль:/**Federal Securities Laws**/

1933 оны хуулийн хоёрдугаар бүлэгт үнэт цаас арилжаалах гол агуулгыг тодорхойлж өгсөн байдаг. Тус хуулийн агуулгаар: Үнэт цаас арилжаалахад оролцдог бүх этгээд тодорхой үнэ, эрсдэл, захиран зарцуулах гэх мэт олон агуулгыг арилжаалах гэсэн агуулгад багтааж үзэх ёстой.

Энэ нь үнэт цаас бүрийг Үнэт цаас биржийн комисст бүртгүүлэх үүрэгтэй. Тодруулбал: Иргэн үнэт цаас арилжаалах тохиолдолд түүний хөрөнгө оруулалтыг хамгаалах зайлшгүй шаардлага гардаг. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зохицуулалт шаарддаг байна.[37]

GSOC-ийн төслийг санаачлагч сенатор Майк Грави /Mike Grave/ дурьдахдаа GSOC бол өөрийн хувьцааг худалдах боломжийг бүрдүүлдэг. GSOC нь зөвхөн хувьцааг өөрийн болгох сонирхолтой иргэнд боломж олгох санхүүжүүлэх нэг арга байх ёстой юм. Мөн GSOC-ын хувьцааны тогтолцоо нь ард түмнийг өөрийн орон нутгийг хөгжүүлэх оролцоог нэмэгдүүлж өгөх үндсэн арга болдог гэж үзжээ.

GSOC-ийн хувьцааг үнэлэх, арилжаалах нөхцөл бүрдсэн тохиолдолд Компанийн тухай хуулиар зохицуулах. Мөн Үнэт цаас биржийн комисст бүртгүүлэх, мөн бүртгүүлэхээс чөлөөлөгдөх журмууд давхар хэрэглэгддэг байна.

**1934 оны Үнэт цаасны болон Биржийн тухай хууль:**

GSOC байгуулагдсаны дараа түүний актив буюу нийт хөрөнгө 1 сая болж нэмэгдсэн байна. 1933 оны хууль тогтоомжоор тодорхойлж өгсөн бүртгэлийн талаарх чөлөөлөлтийг 1934 оны хууль тогтоомжоор нарийвчилж өгсөн нь GSOC-ийн хөрөнгийг нэмэгдүүлэх гол шалтгаан болсон гэж үздэг.

1934 оны Үнэт цаас болон Биржийн тухай хууль бол GSOC-д тавьсан тодорхой шалгуурыг бүрэн болон хэсэгчлэн Үнэт цаас Биржийн комисст бүртгүүлэх боломж олгож байсан. 1934 оны хуулийн зорилго бол хувьцаа эзэмшигчийг тодорхой мэдээллээр хангах, хөрөнгө оруулалт хийсэн шийдвэртэй холбоотой компанийн зүгээс ямар нэгэн дарамт үзүүлэхийг хориглосон байна. Энэ санаа бол GSOC-ийн төслийг санаачлагч Майк Гравийн үзэлтэй[38] нийцдэг байна. GSOC-д хөрөнгө оруулалт хийсэн этгээд GSOC-н удирдлагын талаар үнэн бодитой мэдээллээр хангагдах ёстой гэж үздэг.

**1940 оны Хөрөнгө оруулалтын компанийн тухай хууль:**

Энэ хуулийн зорилго GSOC нь бусад компанид хөрөнгө оруулалт хийх боломжтой эсэхийг зохицуулсан хууль юм.

IRC хуулийн U хэсгийн заалт нь GSOC өөрөө оор компанид хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлаагүй. Ийм учраас GSOC-г үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийж болдог хөрөнгө оруулалтын компани гэж үзэж болдог. 1940 оны хуулийн ихэнх заалтууд нь хөрөнгө оруулагчыг шударга бус өрсөлдөөны үйл ажиллагаанаас хамгаалахад чиглэгдсэн байдаг. GCOS нь төрийн байгууллага, нийтийн гэсэн статустай байдаг. 1940 оны хуулийн гол зорилгуудын нэг нь : GSOC болон түүний хөрөнгө оруулагч нар, зөвлөгч,

---

[37] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн гол санаа, зорилгыг АНУ-ын ерөнхийлөгч Франклин Д.Рузвельт тодорхойлсон байна.

[38] GSOC-ийн хувьд 5 жилийн хугацаанд хувьцаагаа бусдад зарахыг хориглосон байдаг. Энэ 5 жилийн баталгаа нь хувьцаа эзэмшигч өөрөө бодитой хөрөнгө оруулалт хийх нөхцлийг бүрдүүлж өгөөд чухал ач холбогдолтой юм.

андрайтерийн үйл ажиллагаа эрхлэгч, хоорондын харилцаа мөн компанийн удирдлагын талаарх, түүнд ногдуулах хариуцлагын тогтолцоог тусгажээ.

**GSOC** ба Үндсэн хуулийн үзэл баримтлал:

GSOC-д татварын тодорхой нөхцөл хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчин GSOC-д удирдлагын талаар хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагааны чиглэл нь Үндсэн хуулийн зарим зарчмыг хөндлөг байна.

Аляскын иргэд болон Үнэт цаас Биржийн комисс хоёрын дунд 1980 оны 6 сарын 22 өдөр GSOC-той холбоотой Memorandum буюу санамж бичгийг байгуулжээ. Уг санамж бичиг[39] нь Холбооны улсын Үндсэн хуулийн үзэл санаа дээр тулгуурлагджээ.

Санамж бичгийн зохицуулсан гол харилцаа нь GSOC-ийн төсөв, аудит, төсвийг тогтоохтой холбоотой харилцаа тусгасан. Уг санамж бичгийн гол агуулга нь AGSOC-г нийтийн өмчлөлтэй болгох Үндсэн хуулийн асуудлыг дэвшүүлсэн юм.

GSOC-той холбоотой олон хуулийн зүйл заалт Үндсэн хуулийн үзэл санаатай холбогддог. Тодруулбал: IRC хуулийн U заалт нь Үндсэн хуулийн холбогдох олон зүйлийг өөртөө агуулсан байдаг байна. Өөрөөр хэлбэл GSOC-ийн хувьцааг тараах үйл явц тухайн мужийн хууль тогтоох байгууллагын шийдвэрт үндэслэх, мөн хувьцаа тараах үед иргэн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах, холбооны улсын нутаг дэвсгэрийн асуудлыг давхар хөндлөг байна.

Үндсэн хуулийн өөр асуудал бол GSOC нь хувьцааг дамжуулах хүрээнд хязгаарлалт тогтоож өгсөн нь иргэн хувийн өмчөө дураараа зарцуулах эрхэд халдаж байгаа гэж үздэг. Мөн төр оршин суугч бус этгээдэд буюу гадаадын иргэнд хувьцаа эзэмшүүлэх нь үндсэн хуулийн асуудлыг хөндлөг байна. GSOC-ийн хувьцааг анхлан тараасны дараа төрсөн хүүхэд яах вэ, оршин суугаа газраа сольсон иргэн яах вэ гэх Үндсэн хуулийн олон үзэл санаанд GSOC холбогддог байна.

GSOC-ийн хувьцаа нь төр болон хувьцаа эзэмшиж байгаа иргэн хоёрын ашиг сонирхлыг хэрхэн хангаж байгаа нь маргаантай асуудал бөгөөд иргэн төр хоёрын харилцааг тэнцвэртэй байлгах нь хамгийн зөв хувилбар юм.[40]

GSOC-ийн хувьцаа эзэмшигч 5 жилийн хугацааны хязгааралалт тогтоож өгсөн нь Үндсэн хуулийн өмчлөх эрхэд сөрөг нөлөө үзүүлдэг.

**2.5 GSOC-ийн татварын дэглэм:**

GSOC татварын дэглэмийг IRC хуулийн U хэсэгт нарийвчлан заасан байдаг. GSOC-д ногдуулах татварын асуудлыг, Татварын нарийн бичгийн дарга нарын зөвлөл эцэслэн шийддэг байна. Уг дэглэм нь татварын жилийн хугацаанд GSOC-д ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэгддэг

[39] Memorandum төслийн үзэл санааг Wilmer & Pickering нар хийжээ.
[40] Jerry N.Gauche "General stock ownership Corporations: Another step in Broadening capital Ownership"

байна. Жишээ нь: Холбооны улсын ашгийн татвараас чөлөөлөгддөг байна.

GSOC нь зөвхөн өөрийн хувьцаа эзэмшигчдэд татвар ногдуулдаг ба IRC хуулийн S хэсэгт заасан байдаг. IRC хуулийн S хэсэгт "Бүх татвар төлөгч тодорхой тохиолдолд татвар төлөхөөс татгалзуулах эрхийг нарийвчлан заасан. GSOC нь ашгийн татвар төлөхөөс болон бусад шимтгэл хураамжаас чөлөөлөгддөг байна. Энэ нь GSOC-ийн гаргасан нэг хувьцаанд нэг л төрлийн татвар ногдуулж болно гэсэн санаа юм.

GSOC нь тухайн татварын жилд үйл ажиллагаа явуулаад алдагдалд орж болдог уг татварын алдагдлыг шилжүүлэх буюу дараагийн татварын жилд суутгаж тооцож болдог. GSOC –ийн үйл ажиллагааны улмаас учирсан цэвэр алдагдлыг хувьцаа эзэмшигчдэд халдаахгүй байх зарчмыг хатуу баримталдаг. Энэ нь бүх хувьцаа эзэмшигч татвараа төлөхгүй байх явдлаас хамгаалах зориулалттай юм. Тийм учраас GSOC нь тухайн оны 12 сарын 31-ээс өмнө өөрт татвар ноогдох байсан орлогоо хувьцаа эзэмшигчдэд адил тэнцүү хуваарилаж, тэднийг дахин татвар төлөхгүй байхаас хамгаалдаг байна.

Хэрэв хуулиар тогтоосон хугацаанд GSOC хувьцааны ногдол ашгаа хуваарилаагүй бол эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. GSOC-ийн татварын статусыг Сангийн сайд тодорхойлдог.

Компанийн дүрэмд татварын асуудлыг зохицуулж өгдөггүй заавал хуульчилсан байхыг шаарддаг байна. Хэрэв GSOC-д татварын хүндрэлтэй нөхцөл бий болсон тохиолдолд GSOC-ийн статусыг хүчингүй болгох асуудлыг компани шийдэж болдог. Гэхдээ Конгрессийн зүгээс GSOC-г сайн дураар татан буулгах эсвэл татварт ноогдох орлогыг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах эсэх асуудлыг шийдэж болдог байна.[41]

### 3. Байгалийн баялгийн сан /National Resource Foundation/ ба GSOC

Ашигт малтмалын нөөцтэй улс гүрэн газар доорх баялагаа хэрхэн зөв ашиглаж эдийн засгаа хөгжүүлэн баялгийн хараал хүрэхгүй байх арга нөгөө талаар газрын хэвлий доорх баялаг зөвхөн ард түмний өмч бөгөөд энэ эрхээ хэрхэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх асуудал чухалд тавигддаг.

Дээрх асуудлыг дэлхийн улс гүрнүүд хоёр аргаар шийдэж байна.

1. Ашигт малтмалын ордын ашиглалтын орлого, төрд оногдох хэсгийг тодорхой санд төвлөрүүлж эдийн засгийн хүндрэлтэй үед баялгийн сангаараа дамжуулан эрсдлийг даван туулах. Мөн зарим тохиолдолд баялгийн сангаар дамжуулан ард иргэдэд хувь хүргэх /Дэлхийн ихэнхи улс нэг удаагийн шинжтэйгээр бэлэн тараадаг. Тухайлбал АНУ-н Аляска муж улс 1997 онд нэг иргэнд 1200 ам.доллар тарааж байсан.
2. Хоёр дахь хэлбэр ашигт малтмалын ордын нөөцийн лицензийн тусгай

[41] Мөн тэнд

зөвшөөрлийг хариуцлаг олон нийтийн өмчлөлийн компани байгуулж түүгээр дамжуулан бүх ард түмэн нь тухайн компанийн хувьцааг эзэмших замаар ногдол ашиг хүртэн шууд бус замаар газрын хэвлий доорх баялгаас ашиг хүртэх, баялагийн тэгш хуваарилалтын нэг арга юм. Олон нийтийн өмчлөлийн компани гэх ойлголт зөвхөн байгалийн баялаг дээр тулгуурлаж бий болдог гэвэл өрөөсгөл ойлголт юм. Олон нийтийн өмчлөлийн компани нь зөвхөн байгалийн баялаг дээр бус олон хэлбэрүүд бий болдог байна */Схем-1 товч үзүүлэл/*




**3.1 Байгалийн баялагийн сангуудын** нийтлэг гол зорилго нь: эдийн засгийг гадна, дотны сайн, муу аливаа гэнэтийн өөрчлөлтөөс хамгаалж, санхүү мөнгөний систем, түүгээр дамжуулан нийгмийн амьдрал, өсөлт хөгжлийг тэнцвэр, тогтвортой байлгахад үндсэндээ чиглэж байна. Нефьт, хий, алт, зэс мэтийн байгалийн баялаг борлуулснаас олсон их хэмжээтэй мөнгөний түр зуурын урсгал нь зэрэг болович далайн шуурга, ган, зуд, газар хөдлөлтийн адил таагүй нөлөө үзүүлж эдийн засаг, нийгмийн амьдралын ерөнхий тэнцвэр, хөгжлийн тогтвортой хэмнэлийг алдагдуулдаг байна.

Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сангийн тайлан, мэдээнээс нефьт болон эрдсийн бусад баялагтай хөгжиж байгаа олон улс оронд ядуурал нэмэгдэж, эдийн засаг нь уруудаж байгаа жишээ, түүх олныг харж болно. Энэ нь эдгээр орнууд, тэдгээрийн төр засаг дээр дурдсан байгалийн болон гадаад зах зээлийн нөлөөнөөс гарах арга хэрэгслээ нэгдүгээрт олоогүй, хоёрдугаарт газрын доорх баялагаа ашиглахын хирээр эдийн засгийн өрсөлдөх чадвар нь алдагдаж ард түмнийх нь аж байдал доройтдог өнөөдөр дэлхийд **"Голландын өвчин"**[43] гэх нэр авсан эдийн засгийн хүчин зүйлийг

[43] Өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас Голланд эрэг орчмын далайн гүнээс асар их хэмжээний нефтийн сан газар илэрч ёстой л бурханы хишгийг хүртсэн болов нефтийн хязгааргүй мөнгө нэрийн сан хөөрөгт урсан орохын хирээр үйлдвэрлэл багасч эдийн засгийн тэнцвэр нь алдагдаж хөгжил биш хөөрөлдөөтэй учирч эхэлсэн байна. Энэ нь гаднаас их хэмжээний нефть-доллар эдийн засагт урсан орсноос үндэсний мөнгөний ханш эрс өсөж гэр нь эдийн засгийн бүх салбар гэр дундаа экспортын салбарын өртгийг өсгөсөнтэй шууд холбоотой байжээ. Ийм эдийн засагтай, дэлхийн эдийн засгийн интеграцид гүнзгий нэгтэрч гадаад зах зээлд бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг аль ч орны хувьд экспорт нь үнэтэй болж өрсөлдөх чадвараа алдах нь жинхэнэ сүйрэл гэдэг нь ойлгомжтой. Энэ шалтгаанаар Нидерландын нефтээс бусад салбарууд уналтад орж, ажилгүйдэл дагаж, эдийн засгийн үндсэн балансууд алдагдаж газрын доорх хямд баялаг нь хөгжлийг хурдасгагч биш саарууллан бүр сүйрүүлэх хүчин зүйл болж хувирчээ. Түүнээс хойш нефть, баялагтай холбоотой энэ "хямрал"-г дэлхий нийтээрээ түүнийг анх амссан Нидерландын нэрээр нэрлэх болсон бөгөөд өнөө нь тогтоогдож, өөрөөр нь ойлгомжтой болсон өнөө үед ч энэ өвчнөөр өвчлөгсдийн тоо буурахгүй харин ч шаш дамжирч нефть болон газрын доорх бусад баялагтай холбоотой шинэ үзэгдэл, нэр томьёог төрүүлсээр байна.

ойлгож зөв удирдан зохион байгуулж чадаагүйтэй холбоотой байна.

Голландын өвчин нь өнөөгийн хоцрогдсон голдуу орнуудын төрд нүүрлэсэн авилгал болон төрийг нэг буюу хэсэг бүлгээрээ өмчлөх нийгмийн үзэгдэлтэй хоршсон тохиолдолд **"баялагийн хараал"**[43] болж дээрхээсээ илүү гай гамшигтай хүчин зүйл болж улс гүрнийг хоцрогдол, ядуурлын туйлд хүргэх болсныг олон орны жишээ харуулж байна.[44]

Олон улсын туршлагаас харахад Байгалийн баялагийн сан /NRF/ бол төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг "буяны" сан биш юм. Өнгөн талаас нь харахад тэтгэвэр, ажилгүйдэл нийгмийн халамжийн чиглэлтэй байгаа мэт байвч үнэн хэрэгтээ хожим нь улсын нэгдсэн төсөвт үүсч магадгүй хүндрэл бэрхшээлийг даван туулах зориулалттай байдаг аж. Тодруулбал, АНУ-ын "Аляскийн байнгын сан "-г эс тооцвол аль ч сан нийгмийн халамж хэлбэрээр иргэддээ бэлэн мөнгө тараадаггүй гэсэн үг юм.

Гэхдээ "Аляскийн байнгын сан"-ын хувьд энэхүү тарааж буй бэлэн мөнгө нь хатуу ширүүн уур амьсгал бүхий тодорхой нэг бүс нутагт иргэдийг амьдарч оршин суухад нь зориулагдсан урамшууллын арга хэмжээ болохоос нийт ард иргэдэд зориулагдсан нийгмийн халамж биш юм. Уул уурхайгаас олсон илүүдэл орлогоо төрийн мэдлийн санд төвлөрүүлж хуримтлал бий болгох, энэ хөрөнгөөр олон улсын мөнгөний зах зээлд эргэлтэд оруулан дахин нэмэлт орлого олж буй нь тухайн улсуудад мөнгө илүүдэж, эсхүл бүтээн байгуулалт хөгжлийн дээд зэрэгт хүрсэн явдал огт биш юм. Эдийн засгийн шингээх чадвараас хэтрүүлж гүйлгээнд гаргавал инфляци хөөрөгдөх, ямар ч хамаагүй үнэ хаялцаж импортын үнийг хөөрөгдөх, үнийн өсөлтийн өрсөлдөөн үүсэх зэргээр эдийн засгийн тогтвортой түвшинг хангах, тэнцвэрийг хадгалах зорилгоор уг мөнгөн хуримтлалыг зугуухан гүйлгээнд гаргадаг байна.

- Ихэнх улс дотоод зах зээлд уг мөнгөн хөрөнгийг байршуулахаас татгалзаж /улс төрийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалж/ гадаад зах зээл дээр Төв банкууд нь эрсдлийн удирдлагаар хангаж ажилладаг. Үүний үр дүнд энэхүү орлого тогтвортой хадгалагдан өсч хожим учирч болох гэнэтийн хямрал, бэрхшээлээс тухайн улс орноо хамгаалах найдвартай эх үүсвэр болдог байна.
- Сангийн хөрөнгө нь ард түмний өмч учир баялагаас орох орлого хэрхэн зарцуулагдаж байгааг баялагийн эзэн болсон ард түмэн мэдэх боломжийг бүрдүүлж, ил тод байдлыг хангах, сангийн ирээдүйн орлогын тооцоолсон өнөөгийн үнэ цэнэ зэрэг мэдээллийг хуулиар заавал ил тод тайлагнадаг

[43] **"Баялагийн хараал"** гэсэн нэр томъёо дэлхий нийтэд саяхнаас ашиглагдаж эхлэх болсон бөгөөд газрын доорх асар их баялагтай мөртлөө удирдлагын муугаас дэлхийн хөгжлийн сүүл барьдаг Заир, Зимбабве, Гвиней зэрэг олон орнуудад хамааруулан хэрэглэж байна. Ухаад ухаад алт, эс бөгөөс эзэл үндсэн ус ч гарах нь ховор Сингапур, Япон дэлхийд тэргүүлэгч хөгжиж, хүний хөгжлийн дээд түвшин, стандартыг тогтоож байхад нефть, газрын хий, алт, зэс зэрэг баян дээр нэрлэсэн бөгөөд нэрлээгүй дэлхийн зарим орнууд хөгжлийн хоцрогдолд умбаж, иргэний дайн, гудамжны хөдөлгөөнд дарлуулан, өөрөө хоорондоо урууцан муудаж байна. Эдгээр орнуудад нийгмийн харилцааг зохицуулах хуулиа ёс журам байхгүй, байсан ч үйлчилгээгүй болж, хийн засаг, үндэсний баялаг цөөн хүний авилгачдын мэдэлд орж түүний эрх ашигт үйлчлэх болсон нь хөгжлийн нийн гажуудлын үндэс болж байгаа гэж дэлхийн олон нийт үзэж байна.
[44] Нээлттэй нийгэм форум "Монголд Эрдэсийн сан байгуулах шаардлага арга зам" 2006 он

байхаар зохицуулдаг байна.

- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд хяналт тавих боломжийг төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдэд олгож, төсвийн гадуур хяналтгүй зарцуулахаас сэргийлэх буюу хяналт тавих эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зайлшгүй байдаг ажээ.

## Дүгнэлт хэсэг

**Монгол улсын хувьд:**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн зорилго нь ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил санг байгуулав гэж тусгасан байна.

Хүний хөгжил сангийн тухай хуульд уг сангийн эх үүсвэр нь **стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг,** хувьцаа борлуулсаны орлогоос, ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, борлоборуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг, үнэт цаас өрийн бичиг эсвэл хадгаламжид оруулсан хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээл зэргээс бүрдэхээр хуульчилж өгчээ.

**Дээрх байдалд дүгнэлт хийхэд:**

1. ***Өнгөн талаас нь харахад Байгалийн баялагийн сан нь тэтгэвэр, ажилгүйдэл нийгмийн халамжийн чиглэлтэй байгаа мэт боловч цаад зорилго нь хожим нь улсын нэгдсэн төсөвт үүсч магадгүй хүндрэл бэрхшээлийг даван туулах зориулалтаар хуримтлал үүсгэдэг зорилготой байдаг.***

Харин хүний хөгжил сангийн хөрөнгийн эх үүсвэр нь уул уурхай, ашигт малтмалын ордоос бүрдэж байгаа хэдий ч үйл ажиллагааны чиглэл зорилго нь зөвхөн иргэдэд хишиг хувь хүртээх зорилготой байна. Сангаас хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харъяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээнэ. Монгол улсын иргэн тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр; орон сууц худалдаж авсны төлбөр; бэлэн мөнгө; эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөр; хүүхдийн мөнгө хэлбэрээр сангаас хишиг, хувь хүртээнэ гэж заасан байна. Энэ нь хүний хөгжил сан нь уул уурхайгаас орсон мөнгөн хөрөнгийг тусгай санд хуримтлуулан эрсдлийг даван туулахаас зорилгоос илүүтэйгээр сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэх нийгмийн халамжийн сан төдий үйл ажиллагаа явуулж байгаа нь Байгалийн баялагийн сан буюу /National Resuorce Foun-

dation/-ны үндсэн цаад санаа зориулалттай нийцэхгүй байна.

2. Баянмонгол (Эрдэнэс Монгол) компанийн хуулийн төслийн хүрээнд.

Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллага тухайн зах зээлд тогтвортой бөгөөд ашигтай ажиллахад бизнестэй холбоотой шийдвэрийг шуурхай бөгөөд уян хатан байдлаар гаргаж байж амжилтанд хүрдэг гэж үздэг нь зарчим билээ. Харин Баянмонгол ХК-ийн хуулийн төсөлд удирдлагын бүтцийг маш нүсэр бүтэцтэйгээр тусгасан байна. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгчдийн хурал нь маш их эрх мэдэлтэй хэрнээ түүнийг хэрэгжүүлэх субъектүүд хангалтгүй, шийдвэр гаргах үйл явц удаашралтай зэрэг асуудал үүсвэл ашгийн төлөө ажиллах ёстой компани зах зээлд оршин тогтнох чадваргүй болох эрсдэл өндөртэй.

Тус хуулийн төслийн 8.5-д "Энэ хуулийн 8.1-д заасан хувьцааг худалдах, арилжих, өв залгамжлуулахыг хориглоно" гэж тусгасан нь зөвхөн ногдол ашиг авах эрхтэйгээр заасан байна. Гэтэл Компанийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ" гэж заасан. Гэтэл Баянмонгол ХК-ийн хуулийн төсөлд хувьцаа эзэмшигчийн энэхүү бүх эрхийг хязгаарласан байна.

Процессийн заалтын тодорхойгүй байдал. Төслийн 14 дүгээр зүйлд хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгчдийн хурлын тухай заасан бөгөөд аймаг бүрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас сонгогдохоор заасан байна. Гэтэл аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ямар журмаар, яаж сонгох зэрэг тухай огт заагаагүй байна.



# ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ НӨХӨРЛӨЛ: ГАДААД ОРНЫ ХАРЬЦУУЛТ

Ч.Жадамба
/Шихихутуг ХЗДС-ийн багш, магистр/

Удиртгал

Аливаа хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад үйл ажиллагааны зорилго, чиглэлийг харгалзах ёстой. Хуулийн этгээдийн хэлбэрийг оновчтой сонгоход удирдлагын уян хатан шинж (management flexibility), хувь хүн хариуцлага хүлээх эсэх (personal liability), татварын зохицуулалт (taxation), үйл ажиллагааны үр нөлөөтэй байдал (effectiveness) зэрэг хүчин зүйлс чухал нөлөөтэй.

Төрийн зүгээс хуулийн этгээдээс явуулах тодорхой үйл ажиллагааг зөвшөөрөх, эсхүл хориглохоос эхлээд хуулийн этгээдийн шинэ төрөл, хэлбэрийг хуулиар тогтоож хүлээн зөвшөөрөх зэрэг хэлбэрээр төр хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оролцдог.[1] Нөгөө талаас төр нь өөрөө хуулиар бий болгосон этгээд болох хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг сонгох сонголтыг зарим тохиолдолд хязгаарлах нь бий. Жишээлбэл, хүний эрүүл мэндийг хариуцаж байдаг хувийн эмнэлгийг байгуулахдаа хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахыг зөвшөөрөхгүй байх нь бий. Энэ нь компанийн хязгаарлагдмал хариуцлага гэсэн "бамбай"-ны ард орж, мэргэжлийн алдаа, хариуцлагаас бултах боломжийг эрх зүйн, шударга ёсны хувьд, төр бодлогын хувьд хориглож байгаатай холбоотой.[2]

Түлхүүр үг: аж ахуйн нэгж, хоршоо, компани, нөхөрлөл, гишүүдийн хүлээх хариуцлага (хязгаарлагдмал хариуцлага, хэсэгчилсэн хариуцлага)

Олон улсын туршлагаас үзвэл өмгөөллийн үйл ажиллагааг хамтран эрхлэх хуулийн этгээдийн хэлбэрт мэргэжлийн корпораци[3], мэргэжлийн хязгаарлагдмал хариуцлагатай компани[4], хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл[5], мэргэжлийн компани зэрэг хэлбэрийг сонгох нь түгээмэл байна. Нөхөрлөлийн хэлбэрийн хувьд хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

[1]Hickson& Turner, "Corporation or Limited Liability Company", available at www.qub.ac.uk/mgt/efeg/Corporation.pdf
[2] Амарсанаа Б. "Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал". УБ., 2012 он. 11 дэх тал
[3]Англ. Professional corporation
[4]Англ. Professional limited liability company
[5]Англ. Professional limited liability partnership

(Англ. Limited Liability Partnership, ор. Товарищество с ограниченной ответственностью)-ийг байгуулж хууль зүй, санхүү, татварын зөвлөх, эмнэлгийн үйлчилгээ зэрэг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх жишиг, хандлага хэдийн тогтжээ.

Компани болон нөхөрлөлийн зохицуулалтын онцлог, давуу шинжийг хослуулсан хуулийн этгээдийн энэ хэлбэр өдгөө дэлхийн олон улсад бизнес хамтран эрхлэгчид болон өмгөөлөгч, нягтлан бодох, архитектурч, татварын мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэх нийтлэг хэлбэр болохын зэрэгцээгээр манай улсад ч адил хөгжөөд байна.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь гишүүний нөхөрлөлийн нэрийн өмнөөс явуулсан үйл ажиллагааны явцад гаргасан алдаанаас үүдэх хариуцлагыг бусад гишүүд нь зөвхөн нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг хуулийн этгээд юм.

Манай улсад өнөөг хүртэл өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хэлбэр тодорхой бус байсаар иржээ. Тухайлбал 2002 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулийн хүрээнд иргэний хуульд заасан бүх хуулийн этгээдийн хэлбэрээр өмгөөллийн үйл ажиллагааг эрхлэхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Харин шүүх эрх мэдэл, шинэтгэлийн багц хуулийн хүрээнд 2012 онд батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар өмгөөллийн үйлчилгээг ганцаарчлан, гэрээгээр хамтарч, хуулийн этгээд байгуулах замаар үндсэн гурван хэлбэрээр эрхэлж болох бөгөөд хуулийн этгээд байгуулж өмгөөллийн үйлчилгээ хамтран эрхлэх хэлбэр нь нөхөрлөл байна гэж заасан.[6] Өмгөөллийн хуулийн этгээдийн хэлбэрийг ийнхүү нөхөрлөл байхаар хязгаарласан нь нэг талаас өмгөөлөгч хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн ач холбогдолтой баримт бичиг боловсруулах, шүүхэд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж оролцох зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг өмгөөлөгч нь шууд биечлэн гүйцэтгэх шаардлага, нөгөө талаас мэргэжлийн үйл ажиллагааны алдаа, зөрчлөөс үүдэн гарах гэм хорыг бүрэн нөхөн төлүүлэх замаар үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн гэж үзэж болно.

Эндээс үзэхэд өмгөөлөгч дангаараа хуулийн этгээд байгуулан өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг хориглоогүй бөгөөд дангаар хуулийн этгээд байгуулан өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн хэлбэр нь манай улсын хувьд компанийн хэлбэр байж болно.

Өмгөөллийн нөхөрлөл нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглох[7] бөгөөд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй этгээд нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй юм. Мөн өмгөөлөгч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх

[6] Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 36.3 "Өмгөөллийн үйлчилгээ хамтран үзүүлэх хуулийн этгээдийн хэлбэр нь нөхөрлөл байна"

[7] Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 36.7 "Өмгөөллийн хуулийн этгээд нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно."

зөвшөөролгүй этгээдтэй хамтарч ашиг хуваарилах байдлаар өмгөөллийн үйлчилгээ явуулахыг хуулиар хориглосон. Энэ нь өмгөөллийн үйлчилгээг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр (өмнө нь) явуулж байсан хувьцаа эзэмшигчийн хувьцааг үнэгүйдүүлэх нөхцөл байдал үүсэж байна. Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээдтэй үйл ажиллагаа явуулсан бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно гэжээ.[8]

Нөхөрлөлийн тухай хуулийн 2013 оны 07 дугаар 09-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрийг хуульчилж өгсөн, 29.1-д "Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна" гэж заасан. Энэ нь нөхөрлөлийн гишүүн нь зөвхөн бусад гишүүн, эсхүл нөхөрлөлийг төлөөлөх эрхтэй этгээдийн буруутай үйлдэл, мэргэжлийн алдаанаас учирсан хохирлыг хувийн өмчийн эд хөрөнгөөр хариуцахгүй буюу "хэсэгчилсэн хязгаарлагдмал хариуцлага" хүлээх явдал юм. Мөн нөхөрлөлийн гишүүд буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүний хариуцлагаас чөлөөлөгдөхөөс гадна нөхөрлөлийн өөрийн хүлээсэн болон бусад үүргээс үүдэлтэй хариуцлагаас давхар чөлөөлөгдөх онцлогтой юм.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн удирдлага, хяналт: Хязгаарлагдмал хариуцлага нөхөрлөлийн эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал юм. Бүх гишүүдийн хурал нь нөхөрлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцогдох бөгөөд хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Нөхөрлөлийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, татан буулгах
- Нөхөрлөлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах
- Их хэмжээний үнийн дүнтэй болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрөх эсэх
- Нөхөрлөл удирдлагатай байх эсэх, хэрэв гүйцэтгэх удирдлагын бүтэцтэй бол түүний эрх, үүрэг хариуцлагын журам, цалин, урамшууллын хэмжээг тогтоох

Нөхөрлөлд шинэ гишүүн орох, нөхөрлөлөөс гарах, чөлөөлөх болон удирдлага болоод гишүүдийн санал болгосон бусад асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй.

---
[8] Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.9, 36.10 дахь заалт

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүдийн хариуцлага: Нөхөрлөлийн гишүүн нь эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ нөхөрлөлийн ашиг сонирхолд нийцүүлэн шударгаар гүйцэтгэнэ. Нөхөрлөлийн гишүүн нь мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэхээр хөрөнгө, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа нэгтгэн нөхөрлөлд оруулах бөгөөд нөхөрлөлийн гишүүний эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаагаа биечлэн гүйцэтгэнэ.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ өөрийн хөрөнгөөр хариуцна. Нөхөрлөлийн гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгөөрөө хязгаарлагдмал хариуцлага хүлээнэ. Дараах тохиолдолд дангаараа болон хэсгээр хамтран хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

Буруутай үйл ажиллагаа явуулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол нөхөрлөлийн гишүүн,

Буруутай үйл ажиллагаа явуулсан нөхөрлөлийн гишүүний болон бусад этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй гишүүн, эсхүл буруутай үйл ажиллагаа явуулсныг мэдсэн, мэдэх ёстой байсан боловч шаардлагатай арга хэмжээ аваагүй гишүүн,

Нөхөрлөлийн гишүүний буслад учруулсан хохирлыг нөхөрлөлийн хөрөнгөөр тэргүүн ээлжинд барагдуулна. Хохирлыг барагдуулахад нөхөрлөлийн хөрөнгө хүрэлцэхгүй бол буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөх хариуцлага хүлээнэ.

Манай улсад аудитын үйл ажиллагаа,[9] татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ,[10] татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд, мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа зэрэг тусгай мэргэжил, зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэхийг хуульчлах боломжтой юм.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг бусад хуулийн этгээдийн хэлбэрээс ялгах нь: Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, компаниас удирдлагад оролцох боломж, хариуцлагын хувьд ялгаатай. Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хувьд гишүүд нь бүгдээрээ нөхөрлөлд оруулсан хөрөнгөөр болон хувийн өмчийн эд хөрөнгөөр нөхөрлөлийн хүлээсэн үүргийг хүлээдэг. Өөрөөр хэлбэл нөхөрлөлийн үйл ажиллагаанд холбогдуулан гаргасан шаардлагад нөхөрлөлийн аль ч гишүүн буруутай эсэхээс үл хамааран хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцлага хүлээдэг харьцангуй "эрсдэлтэй" хэлбэр юм. Бүрэн хариуцлага хүлээдэг тул гишүүн бүр нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй. Харьцуулбал,

[9] Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "аудитын үйл ажиллагаа" гэж аудитын байгууллагаас гэрээний дагуу хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний нягтлан бодох бүртгэлийн хөтөлт, үйл ажиллагааны тайлан хянаж дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх харилцааг бүс үйл ажиллагаа"-г ойлгоно. 1997 он

[10] Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 "татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ" гэж үйлчлүүлэгчийн татвар төлөх үүргээ биелүүлэх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн мэргэшсэн зөвлөх үйл ажиллагаа"-г ойлгоно. 2002 он

хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрийг сонговол мэргэжлийн алдаа гаргаагүй нөхөрлөлийн гишүүн нь бусад гишүүний нөхөрлөлийг төлөөлөн явуулсан үйл ажиллагааны улмаас үүсэх хариуцлагыг зөвхөн нөхөрлөлд оруулсан хөрөнгөөр хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг онцлогтой.

Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хувьд дор хаяж нэг гишүүн нөхөрлөлийн хүлээсэн үүргийг хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцаг, нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй нэг гишүүн, зөвхөн оруулсан хөрөнгөөр нөхөрлөлийн хүлээсэн үүргийг хариуцаг хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг, нөхөрлөлийг удирдах төлөөлөх эрхгүй нэг гишүүн байх шаардлага тавьдаг. Эсрэгээр хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлд бүрэн хариуцлага хүлээдэг гишүүн байхгүй, компанитай адил байдлаар нөхөрлөлийн үйлажиллагаанаас гарах хариуцлага буруутай этгээдэд илүүтэй оногддог онцлог бүхий хуулийн этгээдийн хэлбэр юм. Компанийн хувьд компанийн хувьцаа эзэмшигчидтэй харьцуулахад нөхөрлөлийн гишүүд өдөр тутмын үйл ажиллагаанд шууд оролцох боломжтой. Нөгөө талаас компанийн хувьцаа эзэмшигчид нь бүх гишүүдийн хурлаас төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулна. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрх бүхий албан тушаалтнууд (Гүйцэтгэх захирал болон бусад)-ыг томилж, тэдгээр нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах зарчмаар ажилладаг. (Хүснэгтээр хавсралт 1-ээс харна уу)

Хуульчийн мэргэжил нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулах болсноор нөхөрлөлийн шинэ хэлбэрээр бүртгүүлэх тоо эрс өссөн байна. Манай улсын хэмжээнд нийт 3286[11] нөхөрлөл албан ёсоор бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээ, тайлангаас харвал нөхөрлөл 2013 он хүртэл өсөлттэй харагдаж байна. Энэхүү өсөлт нь 2013 оны 07 сарын 09 ний өдрийн Нөхөрлөлийн тухай хууль, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой[12] холбон тайлбарлаж болно.

АНУ-ын нөхөрлөлийн эрх зүйн зохицуулалт. АНУ-д ерөнхий нөхөрлөл (General partnerships), хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (LLPs-limited Liability partnerships), зарим мужуудад хязгаарлагдмал хариуцлагатай хязгаарлагдмал нөхөрлөл (LLLPs-Limited liability limited partnerships) байдаг.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрийг анхлан хууль тогтоомжид тусгасан нь АНУ-ын Техас муж юм. 1980-аад оны сүүл үед үл хөдлөх хөрөнгө болон эрчим хүчний үнийн уналтаас үүдэлтэй АНУ-ын хадгаламж, зээлийн хямрал нь хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрийг үүсгэх түлхэц болсон юм. Хямралаас үүдэлтэй Техас мужид байрлах Холбооны даатгалын хадгаламжийн корпораци (Federal Deposit Insurance Corporation), Холбооны хадгаламж зээлийн даатгалын корпораци

11https://burtgel.gov.mn/index.php?option=com_content&view=category&id=53&Itemid=253 2015.01.05/хандалт/

12 Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөлийн хэлбэрээр үйл явуулна" гэсэн.

(Federal Savings and Loan Insurance Corporation)-ийн дампуурал нь тэдгээрт зөвлөгөө үзүүлж байсан хуулийн болон нягтлан бодох бүртгэлийн пүүсүүдийн мэргэжлийн буруутай үйл ажиллагаанаас ямар нэг байдлаар хамааралтай байв. Нөхөрлөлийн хариуцлагын ерөнхий зарчмын дагуу бүх гишүүд буруутай эсэхээс үл хамаарч сангууд болон банкнуудын гаргасан өндөр үнийн дүнтэй нэхэмжлэлд бүрэн хариуцлага хамтран хүлээхэд хүргэж, энэ мэргэжлийн алдаа гаргаагүй этгээд бусдын гаргасан алдаанд бүрэн хариуцлага хүлээлгэх нь эрсдэлтэй болохыг харуулжээ.[13] Ингээд нөхөрлөлийн алдаа гаргаагүй, буруугүй гишүүний хариуцлагыг хязгаарлах эрэл хайлтын дүнд 1991 онд Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хуулийг баталжээ.[14] Тус хуулиар нөхөрлөлийн гишүүн нь зөвхөн бусад гишүүн, эсхүл нөхөрлөлийг төлөөлөх эрхтэй этгээдийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хувийн өмчийн эд хөрөнгөөр хариуцахгүй буюу "хэсэгчилсэн хязгаарлагдмал хариуцлага"[15]-ыг хуульчилсан бол 1997 онд тус хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж "бүрэн хязгаарлагдмал хариуцлага"-ыг бусад мужийн адилаар хуульчилсан байна. Ингэснээр нөхөрлөлийн гишүүд буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүний хариуцлагаас чөлөөлөгдөхөөс гадна нөхөрлөлийн өөрийн хүлээсэн бусад үүрэг (тухайлбал, гэрээний үүрэг)-ээс үүдэлтэй хариуцлагаас давхар чөлөөлөгддөг болжээ.

Өдгөө тус улсын 40 гаруй мужид хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрийг хуулиар зөвшөөрсөн байна. Зарим мужид хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг иргэд чөлөөтэй сонгож байгуулах боломжтой байхад тодорхой мужуудад зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүд хамтран байгуулж болохоор зохицуулжээ.

АНУ-д нөхөрлөлийг мужийн хуулиар ихэвчлэн зохицуулдаг. АНУ-ын ихэнх мужуудад мужийн хууль тогтоомжийг нэгтгэх үндэсний конференцээс (NCCUSL)[16] гаргасан үндсэн хоёр актын модель (загвар) байдаг. Шинэчлэгдэн батлагдсан 1994 оны нөхөрлөлийн тухай хууль (RUPA[17] - нэмэлтүүдийн хамт)[18], 1916 (ULPA[19] - өөрчлөлтүүдийн хамт)[20] оны нөхөрлөлийн хуультай ойролцоо юм. Ерөнхий хуульд нөхөрлөлийг хувь иргэн түншүүдийн нэгж гэж үздэг.[21] RUPA-ийн дагуу нөхөрлөл нь бизнес явуулах, эд хөрөнгө олох,

[13] Alberta Law Reform Institute 'Limited Liability Partnerships' Final Report No. 77, p.40, 199

[14] Техас мужийн Нөхөрлөлийн Нэгдсэн Актад (англ. Texas Uniform Partnership Act) "нөхөрлөлийн аль нэг гишүүн, эсхүл нөхөрлөлийг төлөөлөх эрхтэй этгээдийн нөхөрлөлийн үйл ажиллагааны явцад гаргасан буруутай үйлдэл, эс үйлдэхүй, хайхрамжгүй байдлаас үүдэн гарах алдаа эр, үүргээс тухайн нөхөрлөлийн гишүүн хяналт тавих үүрэгтэй байсан, эсхүл буруутай үйлдэл, эс үйлдэхүй, хайхрамжгүй байдал гаргахад шууд ямар нэг хэлбэрээр оролцоогүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй байхаар заасан.

[15] Англ. Partial limited liability

[16] National Conference of Commissioners on Uniform State Laws

[17] Revised Uniform Partnership Act of 1994

[18] http://www.nccusl.org/Update/uniformact_factsheets/uniformacts-fs-upa9497.asp
http://www.law.cornell.edu/uniform/vol7.html#partn зэрэг линкээс мужуудын хуулийн жагсаалтыг үзнэ үү.

[19] Uniform limited Partnership Act of 1916

[20] List of state laws at http://www.nccusl.org/Update/uniformact_factsheets/uniformacts-fs-ulpa.asp зэрэг линкээс мужуудын хууль тогтоомжийн жагсаалтыг үзнэ үү.

[21] J William Callison, 'Federalism, Regulatory Competition, and the Limited Liability Movement: The Coyote Howled and the Herd Stampeded' 26 Journal of Corporation Law 951, 974 (2001)-ийг үзнэ үү.

эзэмших, захиран зарцуулах, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар өөрийн нэрийн өмнөөс оролцдогоороо онцлогтой.[22] Үүгээр нөхөрлөл нь компанитай төстэй байх хэдий ч татвар төлөх асуудлын хувьд өөр юм. Компани нь аж ахуйн нэгж болон хувьцаа эзэмшигчдийн түвшинд татвар төлдөг бол нөхөрлөл нь "урсгал" буюу нөхөрлөлийн гишүүдийн хувьд нэгдсэн ижилхэн хэмжээгээр татвар төлдөг.[23]

Нөхөрлөлийн гишүүдийн хоорондын харилцаа нь нөхөрлөлийг үүсгэн байгуулсан гэрээгээр зохицуулагддаг бөгөөд нөхөрлөлийн акт нь дуугүй байх зарчмыг тэргүүн ээлжинд зохицуулдаг. Нөхөрлөлийн олон хэлбэрүүдийн гол ялгаа нь гишүүдийн хариуцлагад оршдог. Бүрэн хариуцлагатай нөхөрлөлийг аливаа зорилгод хүрэх үүднээс ямар нэгэн нэмэлт шаардлагагүйгээр байгуулж болдог. Нөхөрлөл үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүргээ биелүүлж чадаагүй бол нөхөрлөлийн гишүүн нь нөхөрлөлийн үүрэг, төлбөрийн хэмжээгээр нэмэлт хариуцлага хүлээдэг.[24]

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг үүсгэн байгуулахын тулд төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байхыг шаарддаг.[25] Энэхүү нөхөрлөл нь ядаж нэг үндсэн хариуцлагатай, нэг хязгаарлагдмал хариуцлагатай гишүүнтэй байх шаардлагатай. Үндсэн гишүүн нь нөхөрлөлийн бүх үүргийг бүрэн хариуцдаг бол хаязгаарлагдмал хариуцлагатай гишүүн нь энэхүү үүргээс ангид байдаг. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хязгаарлагдмал хариуцлагатай гишүүний нөхөрлөлийн активыг захиран зарцуулах, удирдахад оролцох байдлыг хязгаарлах зорилгоор нөхөрлөлийн тухай хуулийг баталдаг. Гэвч хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн нь аажмаар өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг ихэсгэж болно.[26] Ялангуяа Делавэрт хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүд нөхөрлөлийг тараах, активийг захиран зарцуулах, ерөнхий захирлыг томилох, ажлаас халахад саналаа өгөх, мөн ерөнхий захиралтай зөвлөлдөх болон түүний үйл ажиллагааг хянах эргийг зөвшөөрсөн байдаг.[27]

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (ХХН) нь сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжих болсон. Анх Техаст хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн 1991 онд байгуулсан[28] бөгөөд үндсэн нөхөрлөлтэй харьцуулахад гишүүний хариуцлагыг дэд хэмжээнд хамгаалсан хувийн хариуцлагын тухай бизнесийн маргаанууд гарсантай холбоотой юм.[29] 1996 онд RUPA-д хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн тухай зохицуулалтууд нэмэгдэж орсон бол 2001 он гэхэд бүх мужид LLP-ийн зарим хэлбэрүүд батлагдсан.[30]

---

[22] RUPA s 201(a).

[23] Internal Revenue Code § 7704 (exception for publicly traded limited partnerships)

[24] RUPA ss 306, 307.

[25] ULPA s 201.

[26] Larry E Ribstein, 'The Evolving Partnership' 26 Journal of Corporation Law 819, 843 (2001).

[27] Delaware Revised Uniform Partnership Act § 17-303.

[28] Mathias M Siems. "Regulation Competition in Partnership Law" 58 International and Comparative Law Quarterly 767 (2009) http://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1223735

[29] Болсон үйл явдлын талаар Robert W Hamilton, 'Professional Partnerships in the United States' 26 Journal of Corporation Law 1045,1056-1058 (2001)-аас үзнэ үү.

[30] Carter G Bishop, 'The Limited Liability Partnership Amendments to the Uniform Partnership Act (1994)' 53 Business Lawyer

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг үүсгэн байгуулахад өгөх байдлыг шаардлаг[31]. Үүнээс гадна хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь жилийн тайлан болон жил бүрийн төлбөрийг төлөх үүрэгтэй[32].

Зарим тохиолдолд хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь мужуудад янз бүр байх тохиолдол гарна. Зарим мужуудад хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг үүсгэн байгуулж бизнес явуулахын тулд зөвхөн мэргэжлийн хүмүүс тусгай зөвшөөрөл авах шаардлагатай.[33] Хураамж янз бүр байх бөгөөд зарим мужуудад нөхөрлөлийн гишүүдийн тооноос хамаардаг.[34] Зарим мужуудад үүрэг гүйцэтгүүлэгчийн эрхийг хамгаалах талаар нэмэлт баталгаа байдаг. Жишээ нь, хувийн баталгаа гаргаж болох бөгөөд хадгаламжийн данс нээх, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн зориулалтын даатгалын гэрээг байгуулж болно.[35] Хариуцлагыг хамгаалах хүрээнд ялгаа гардаг. Мужуудын гуравны нэгд зөвхөн нөхөрлөлийн гишүүдийн хууль бус үйлдлээс үүдэн бусад гишүүдийн шаардах эрх нь хамгаалагдсан байна (жишээ нь, нөхөрлөлийн гишүүдийн хайхрамжгүй байдал, эсхүл мэргэжлийн хайхрамжгүй байдлаас гарсан хууль бус үйлдэл). Бусад мужуудад нөхөрлөлийн гишүүдийн бүсдад гомдол гаргах эрхийг хамгаалсан.[36]

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн үйл ажиллагааг явуулах явцад гэрээ, иргэний эрх зүйн зөрчил, эсхүл бусад нөхцөл байдлаас хамааран үүссэн үүрэг нь зөвхөн нөхөрлөлийн үүрэг гэж тооцогдоно. Нөхөрлөлийн гишүүн нь зөвхөн гишүүний хувьд үйл ажиллагаагаа эрхлэхээс бусад тохиолдолд шууд, эсхүл шууд бус байдлаар татвар төлөх зэргээр хувийн хариуцлага хүлээхгүй.[37]

Гэсэн хэдий ч эдгээр мужуудад хариуцлагыг хамгаалах нь хязгаарлагдмал юм. Нөхөрлөлийн гишүүн нь өөрийн хяналтан доор байдаг этгээдэд өөрийн буруутай, хайхрамжгүй үйлдлээрээ учруулсан үр дагаврыг хариуцаж, хариуцлага хүлээнэ.[38] Ихэнх мужуудад мэргэжлээс хамаарсан нэмэлт ялгаатай байдал гардаг. Тухайлбал, нөхөрлөлийн гишүүн нь хөдөлмөрийн хөлс болон татварын хариуцлага хүлээдэг, харин зарим мужуудад тодорхой мэргэжилтэй гишүүд (жишээ нь, хуульчид) хязгаарлагдмал хариуцлага хүлээхийн тулд нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан байх ёстой.[39]

---

101 (1997)-ийг үзнэ үү.
[31] RUPA s 201(b).
[32] RUPA s 1003(c).
[33] Thomas E Rutledge, 'To Boldly Go Where You Have Not Been Told You May Go: LLCs, LLPs, and LLLPs in Interstate Transactions' 58 Baylor Law Review 205, 227 (2006) (New York, California, Nevada and Oregon).
[34] Carol R Goforth, 'An Overview of Organizational and Ownership Options Available to Agricultural Enterprises, Part I' (National Agricultural law Center Publications 2002), available at http://www.nationalaglawcenter.org/assets/articles/goforth_ownership1.pdf' at 38
[35] Gofort ibid; Matthias Hallweger 'Limited Liability Partnership - Eine Gesellschaftsform fur USAmerikanische Anwaltszusammenschlusse und ihre Haftungsfragen Protection' Neue Zeitschrift fur Gesellschaftsrecht (NZG) 1998, 531, 534.
[36] Ribstein (n 14) 838; Thomas E Rutledge, 'Limited Liability (or Not): Reflections on the Holy Grail' 51 South Dakota Law Review 417, 423-424 (2006)-ийг үзнэ үү.
[37] RUPA 1996 s 306(c).
[38] Rutledge (n 23) 435-436, 447; Hallweger (n 22) 536-ийг үзнэ үү.
[39] Robert R Keatinge, 'Are Professional Partnerships Really Partnerships? LLPs, LLCs and PCs – Vicarious Liability Protections and Limitations' 60 Consumer Finance Law Quarterly Report 518; Rutledge (n 23) 447-ийг үзнэ үү.

Үүнээс гадна, америкийн арван таван мужид хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг хязгаарлагдмал хариуцлагатай хязгаарлагдмал нөхөрлөл (LLLP) болгон хэлбэрийг өөрчлөх боломжийг олгосон байдаг. Нөхөрлөлийн энэхүү шинэ хэлбэр бий болсон ULPA-д хамааралгүй, ач холбогдолгүй хэдий ч нөхөрлөлийн LLLP хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг мужуудад нөхөрлөлийн ерөнхий захирлын хариуцлагыг LLP (хязгаарлагмал харицлагатай нөхөрлөл) шиг хязгаарлахыг зөвлөдөг. Иймд LLLP нь үндсэн хязгаарлагдмал хариуцлагатай гишүүдийн ялгааг харуулдаг. Гэвч үндсэн хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүд нь нөхөрлөлийн үүргийг хариуцахгүй юм.

Төрийн зүгээс хуулийн этгээдээс явуулах тодорхой үйл ажиллагааг зөвшөөрөх, эсхүл хориглохоос эхлээд хуулийн этгээдийн шинэ төрөл, хэлбэрийг хуулиар тогтоож хүлээн зөвшөөрөх зэрэг хэлбэрээр төр хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оролцдог. Нөгөө талаас төр нь өөрөө хуулиар бий болгосон этгээд болох хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг сонгох сонголтыг зарим тохиолдолд хязгаарладаг. Тухайлбал, хуульч, аудитор, физикч, эмч, шүдний эмч, болон сэтгэл зүйч зэрэг мэргэжилтнүүдийг тусгай зөвшөөрөл олгох шаардлагыг биелүүлж чадахгүй гэж үзэн бизнес корпораци (Business corporation) болон хязгаарлагдмал хариуцлагатай компани (LLC) байгуулж, бизнес эрхлэхийг ихэнхдээ хүлээн зөвшөөрөхгүй байх нь бий.[40] Энэ нь хязгаарлагдмал хариуцлага гэсэн "бамбай"-ны ард орж, мэргэжлийн алдаа, хариуцлагаас бултах боломжийг эрх зүйн шударга ёсны хувьд, төр бодлогын хувьд хориглож байгаатай холбоотой юм.[41] Өөрөөр хэлбэл, мэргэжлийн дүрэм, ёс зүйн алдаа гаргаж хүний эрүүл мэнд, амь нас зэрэг амин чухал ашиг сонирхолд гэм хор учруулсан эмч хүн хуулийн этгээдэд оруулсан хөрөнгийн хэмжээгээр храиуцлага хүлээж, гэм хорын нөхөн төлөгдөөгүй үлдсэн хэсгийг бизнесийн эрсдэлд оруулан тооцож болохгүй юм. Иймд, зарим мужуудад мэргэжлийн холбоо байгуулах боломжийг бий болгосон байдаг.[42] Үүнээс гадна 1960 оны сүүлээс ихэнх мужуудад эдгээр мэргэжилтнүүдэд мэргэжлийн корпораци (professional corporation) үүсгэн байгуулахыг зөвшөөрсөн байна. Зарим мужуудад зарим мэргэжилтнүүд (жишээ нь, өмгөөлөгчид) тодорхой хэмжээгээр хувийн хариуцлага хүлээдэг хэвээр байна.[43] Саяхан АНУ-ын ихэнх мужуудад хязгаарлагдмал хариуцлагатай мэргэжлийн компани (PLLC – Professional Limited Liability Company)-ийн төрлийг бий болгосон. Үүний гол ялгаа нь мэргэжлийн корпораци нь тусгай аж ахуйн нэгж шиг, харин хязгаарлагдмал хариуцлагатай мэргэжлийн компани (PLLC) нь нөхөрлөл шиг татвар төлдөгт оршдог.

**Техас мужид** хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хязгаарлагдмал хариуцлагыг дан ганц буруутай гишүүнээр хязгаарлалгүйгээр тодорхой

[40] Mathias M Siems. "Regulation Competition in Partnership Law" 58 International and Comparative Law Quarterly 774 (2009)
[41] Амарсанаа Б. Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал. УБ., 2012 он. 11 дэх тал
[42] Hamilton (n 16) 1048-1049-ийг үзнэ үү.
[43] Robert W. Hillman. 'Organizational Choices of Professional Service Firms: An Empirical Study' 58 Business Lawyer 1387, 1392-1393 (2003)-ийг үзнэ үү.

этгээд хариуцлага хүлээдэг онцлогтой. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүнд бусад гишүүний алдаа, дутагдал, хайхрамжгүй байдал, буруутай үйл ажиллагаанаас учирсан хариуцлагыг халдааж хүлээлгэдэггүй хязгаарлагдмал хариуцлагатай. Гэхдээ дараах тохиолдолд буруугүй нөхөрлөлийн гишүүн доор дурдсан тохиолдолд хариуцлага хүлээнэ:

- Тухайн алдаа, дутагдал, хайхрамжгүй байдал, буруутай үйл ажиллагаа гарах үед тухайн гишүүний үйлдэлд хяналт тавих, удирдах үүрэгтэй байсан гишүүн эсхүл нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй этгээд,[44]
- Алдаа, дутагдал, хайхрамжгүй байдал, буруутай үйлдэл гарахад шууд тодорхой байдлаар оролцсон хариуцлагатай этгээд.
- Алдаа, дутагдал, хайхарамжгүй байдлын талаар мэдсэн боловч үр дагаврыг арилгах талаар шаардлагатай арга хэмжээ аваагүй гишүүн, хариуцлагатай этгээд.

Нөхөрлөлийн гишүүдийн хязгаарлагдмал хариуцлага нь нөхөрлөлийн хүлээсэн үүргийг өөрийн хөрөнгөөр хариуцах, нөхөрлөлийн гишүүний хувнар хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүрэг, шүүхийн болон иргэний журмаар нөхөрлөлийн хүлээх аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

**Калифорни мужид** бүртгэлтэй хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн гэрээний болон гэм хороос үүдэлтэй нөхөрлөл, эсхүл нөхөрлөлийн бусад гишүүн хариуцах хариуцлагыг шууд болон шууд бус аливаа хэлбэрээр хүлээхгүй.[45]

Компани болон хуулийн нөхөрлөлийн зохицуулалтын онцлог, давуу шинжийг хослуулсан хуулийн хэлбэр болох LLP нь өдгөө дэлхийн олон улсад бизнес хамтран эрхлэгчид болон өмгөөлөгч, нягтлан бодох, архитектурч, татварын мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэх нийтлэг хэлбэр болон хөгжиж байна.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн давуу тал нь худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд хуулийн этгээдийн нарийн бүтэц, зохион байгуулалттай хэлбэрт шилжилгүйгээр хялбар аргаар хамтын үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгодогт оршино.

**Канад улс:** Канад улсад хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн эрх зүйн зохицуулалт харьцангуй сүүлд үүссэн, шинэ хуулийн этгээдийн хэлбэрт тооцогддог. Ихэнхи мужид хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг зөвхөн эмч, нягтлан бодогч, хуульчид зэрэг мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүмүүс хамтран үүсгэн байгуулж болохоор хуулиудад нь заажээ.[46] Ингэхдээ нөхөрлөлийн хуулинд хязгаарлагдмал хариуцлагатай

[44] Нөхөрлөлийн мэргэжилтэн, ажилтан /employee, servant, agent/
[45] 16306. (c)
[46] Канадын Кьюбек (Quebec), Онтарио (Ontario), Манитоба (Manitoba), Альберта (Alberta), Шинэ Шотланд (Nova Scotia),

нөхөрлөлийн үйл ажиллагааны хүрээ хязгаар (англ. Limitation on limited liability partnership's business activity)-ыг зөвхөн мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулж буй хуулиар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд байгуулж болохоор тусгасан байна.

**Онтарио муж:** Канадын Онтарио мужид хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрийг гагцхүү хуулиар тогтоосон мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хязгаарладаг. Нөхөрлөлийн хууль[47]-ийн 10 дугаар зүйлд гишүүдийн хүлээх хариуцлагыг тухайлан заасан байна. Нөхөрлөлийн гишүүд нь фирмийн гишүүний хувиар хариуцлага хүлээх боловч 10.2-т зааснаар хязгаарлагдмал нөхөрлөлийн бусад гишүүн, хариуцлагатай албан тушаалтны нөхөрлөлийн үйл ажиллагааны явцад гаргасан хайхрамжгүй байдал, буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс учирсан өр, үүрэг, хариуцлагыг хүлээхгүй. Дараахь тохиолдолд энэхүү хязгаарлагдмал хариуцлага хязгаарлагдана:

- Тухайн хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн өөрөө буруутай үйлдэл, эс үйлдэл, хайхрамжгүй байдал гаргасан,
- Буруутай үйлдэл, эс үйлдэхүй, эсхүл хайхрамжгүй үйлдэл гаргасан этгээд шууд удирдлага-хяналтанд байсан нөхөрлөлийн гишүүн,
- Буруутай үйлдэл, эс үйлдэхүй, эсхүл хайхрамжгүй байдал гаргасан этгээд нь нөхөрлөлийн гишүүний шууд удирдлага дор үүрэг гүйцэтгэж байгаагүй боловч үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй, эсхүл тухайн үйлдэл эс үйлдэхүйг мэдсэн боловч боломжит арга хэмжээг шуурхай авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.[48]

Нөхөрлөлийн гишүүдийн нөхөрлөлд оруулсан эд хөрөнгөөр хүлээх хариуцлага нь нөхөрлөлийн хүлээсэн үүргээр хязгаарлагдана.

**Алберта муж:** Тус мужийн нөхөрлөлийн хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гишүүн нөхөрлөлийн бусад гишүүн, ажилтан, төлөөлөх эрхтэй этгээдийн нөхөрлөлийн үйл ажиллагааны явцад гарсан аливаа буруутай үйл ажиллагаа, хайхрамжгүй аливаа үйлдэлд хариуцлага хүлээхгүй.

---

Шинэ Брансвик (New Brunswick), Саскечван (Saskatchewan), Ньюфаундлэнд ба Лабрадор (Newfoundland and Labrador) болон хойд хэсгийн нутаг мужуудад хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн үйл ажиллагааг зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаагаар хязгаарлахаар заасан.

[47] http://www.e-laws.gov.on.ca/html/statutes/english/elaws_statutes_90p05_e.htm#BK11

[48] Partnerships Act R.S.O. 1990, CHAPTER P.5 10. (3) Subsection (2) does not relieve a partner in a limited liability partnership from liability for,
(a) the partner's own negligent or wrongful act or omission;
(b) the negligent or wrongful act or omission of a person under the partner's direct supervision; or
(c) the negligent or wrongful act or omission of another partner or an employee of the partnership not under the partner's direct supervision, if,
(i) the act or omission was criminal or constituted fraud, even if there was no criminal act or omission, or
(ii) the partner knew or ought to have known of the act or omission and did not take the actions that a reasonable person would have taken to prevent it. 2006, c. 34, s. 19.

Харин тус хуулийн 12 (2)-т зааснаар тухайн буруутай үйлдэл, эс үйлдэхүй, хайхрамжгүй байдал гарсан тухайд мэдсэн бөгөөд тэр даруй шаардлагатай арга хэмжээ аваагүй, мөн тухайн гишүүний шууд удирдлага дор байсан гишүүн, ажилтан буруутай үйлдэл, эс үйлдэл, хайхрамжгүй байдал гаргасан бөгөөд шаардлагатай удирдлага, хяналтыг тавьж чадаагүй нь нотлогдвол хариуцлага хүлээнэ. Нөхөрлөлийн гишүүний хязгаарлагдмал хариуцлага нь нөхөрлөлийн хувьд хүлээх аливаа хариуцлагаас хамгаалсан өйлгөлт биш юм.

**Сингапур:** Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн эрх зүйн зохицуулалтын үндсийг 2005 оны Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн акт-аар тогтоосон. Энэ хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь гишүүдээс бие даасан хуулийн этгээд бөгөөд өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээн шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байна. Бүх гишүүд нь нөхөрлөлийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах, нөхөрлөлийг удирдахад оролцох эрхтэй байна.

Хариуцлагын хувьд нөхөрлөлийн хүлээсэн үүргийг нөхөрлөл өөрийн эд хөрөнгөөр хүлээх бөгөөд нөхөрлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад ажиллаж буй бусад этгээд нөхөрлөлийн хүлээсэн үүргийг хувийн эд хөрөнгөөр хариуцахгүй. Харин нөхөрлөлийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахдаа алдаа гаргасан нөхөрлөлийн гишүүн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцлага хүлээдэг байна. Татварын хувьд зөвхөн нөхөрлөлийн гишүүдийн орлогод хувь хүний орлогын татвар ногдуулдаг байна.

**Дүгнэвэл** мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөлийн гишүүн өөрийн мэдлэг ур чадвартаа тулгуурлан харьцангүй бие даасан байдлаар нөхөрлөлийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг. Ийм учраас нөхөрлөлийн гишүүн мэргэжлийн алдаа хийгээд бусад буруутай үйл ажиллагаа явуулснаас үүдэлтэй хариуцлагыг хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хариуцдаг. Сүүлийн жилүүдэд улс орнууд мэргэжлийн үйл ажиллагаанд суурилсан хуулийн этгээдийг нөхөрлөл тэр дундаа хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулалтанд шилжих байдал давамгай байна. Хуульчийн мэргэжил нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулах болсноор нөхөрлөлийн шинэ хэлбэрээр бүртгүүлэх тоо эрс өссөн байна. Манай улсын хэмжээнд нийт 3089[49] нөхөрлөл албан ёсоор бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээ, тайлангаас харвал иргэд нөхөрлөл байгуулах явдал 2013 онд эрс өссөн байна. Энэхүү өсөлт нь 2013 оны 07 сарын 09 ны өдрийн Нөхөрлөлийн тухай хууль, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой юм.

[49] https://burtgel.gov.mn/index.php?option=com_content&view=category&id=53&Itemid=253 2014.03.10/хандсан/

"Эврика" бага, оюутны эрдэм шинжилгээний бага хурал,
Шихихутуг ХЗДС-н эрдэм шинжилгээний бага хуралд
тэргүүн байр эзэлсэн илтгэл



# ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ХҮНИЙ СУБЪЕКТИВ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮҮРГИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

М.Хатанзориг
Шихихутуг хууль зүйн дээд
сургуулийн 3-р курсын оюутан

Төр үүсэн бий болсон үндсэн зорилго нь нийгэмлэг шинжийнхээ үүднээс хүмүүсийн нэгдэл эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахад чухамдаа чиглэсэн ажээ. Тэрхүү үзэл баримтлал, хүсэл эрмэлзлэлийн үр дүнд төрийн удирдлага, улс төрийн дэглэм ч хувьсан өөрчлөгдсөөр дэлхийн ихэнх улс орнууд[1] ардчилсан дэглэмтэй болох замыг туулжээ.Тийм учраас төрийн удирдлагын аль ч хэлбэрт хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, дээдлэх нь үйл ажиллагааны үндсэн зарчим болох зүй тогтол хүлээж байдаг. "Хэрэв философийн утгаар нь авч үзвэл төр байгаагийн эцсийн зорилго нь хүний эрхийг хамгаалахад оршино" гэж хэлэх бүрэн үндэслэл бий. Төрийн эрх мэдлийг хуваарилсан улс орнуудын хувьд хүний эрхийг /эрх чөлөөг/ хамгаалахад нэг талаас хууль тогтоогчид хүний эрхийг хангаж хамгаалсан шударга, "зөв" хуулийг батлах, нөгөө талаас мөн тийм шударга, хараат бус шүүх зайлшгүй ажиллах учиртай. Тэр тусмаа хүний эрх, эрх чөлөөг үндсэн хуулиар баталгаажуулдаг улс үндэстнүүдийн хувьд "Үндсэн хуулийн шүүх" нь онцгой үүрэг хүлээх нь ойлгомжтой. Үндсэн хуулийн шүүх нь төр өөрийн удирдлага, үйл ажиллагаанд хүний эрхийг зөрчихгүй байх, хангах, хамгаалах явдалд чухал ач холбогдолтой. Энэ нь ердийн шүүхтэй харьцуулахад аливаа маргааныг гагцхүү Үндсэн хуулийн үзэл баримтлалд шууд тулгуурлан шийдвэрлэдэг /Үндсэн хуулийг хэрэглэдэг/, ингэхдээ өөр ямар ч байгууллага, албан тушаалтнаас эрх зүйн хувьд давсан хүчин чадал бүхий акт гаргадагтай холбоотой. Энэ ч утгаараа төрийн удирдлагыг түүний үндсэн эх сурвалж болох хүний эрх, чөлөөг хангаж, хамгаалах зорилгод нийцүүлэхэд Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн баталгаа болж өгнө.

***Судалгааны зорилго:*** Үндсэн хуулийн Цэцийн үйл ажиллагаанд хүний субъектив эрхийг хамгаалах үүргийг онол, практикт тулгуурласан ажиглалт хийж улмаар боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхэд энэхүү

[1] 2010 оны Ардчилсан улсуудын хамтын нийгэмлэгийн хуралд нийт 142 улс оролцжээ.

судалгааны зорилго оршино.

***Судалгааны арга:*** Судалгааг шинжлэх ухааны судалгааны аргууд болох харьцуулалтын, статистикийн, түүхчлэх болон хууль зүйн шинжлэх ухаанд түлхүү хэрэглэгддэг анализ, синтез, дедукцийн аргуудад тулгуурлан хийж гүйцэтгэсэн болно.

***Судлагдсан байдал:*** Хүний эрх, төрийн удирдлага, эрх мэдэл, Үндсэн хууль, шүүх засаглал гэсэн ойлголтууд хууль зүйн төдийгүй бусад шинжлэх ухааны бусад салбаруудад ч үндсэн ба хавсарга хэлбэрээр судалгааны обьект болж байдаг бөгөөд эдгээр нь өргөн хүрээтэй, онол, практикийн хувьд олон талаасаа судлагдсан, харилцан уялдаа холбоотой асуудлууд. Хэдийгээр хүний эрх, түүнийг хамгаалах аргачлалуудын талаар, Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны чиглэлээр янз бүрийн бүтээл, судалгааны ажлууд цөөнгүй боловч хүний субъектив эрхийг Үндсэн хуулийн шүүхээр хамгаалах онол арга зүйн үндэслэл тийм ч тодорхой бус гэж хэлж болохоор байна.[2]

**Нэг. Хүний эрх, субъектив эрхийн талаарх ойлголтыг авч үзэх нь**

Хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт нь хүн төрөлхтний түүхийн бүх л цаг үед ээдрээтэй асуудлын нэг байсаар ирсэн юм. Түүнийг байгалийн шинжлэх ухааны томъёолбор мэтээр шууд тогтоох боломжгүй, нөгөө талаас улс үндэстэн бүрийн төр, эрх зүйн түүх, төлөвшил, соёл ухамсар, үзэл баримтлал өөр өөр учраас дэлхий нийтийн нэгдсэн нэг ойлголтод хүрэхэд бэрхшээлтэй байсан аж. Харин ардчилсан дэглэм бий болсоноос хойш улс орнууд нь хүний эрхийн түгээмэл ойлголтуудыг нэгдсэн байдлаар томъёолох боломж нээгдсэн төдийгүй, хүний эрх нь зөвхөн тухайн улсын эрх зүйн үнэлэмжээс үл шалтгаалах зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч эхэлсэн. Энэ ч утгаараа ардчилсан улс орнууд нь дотоодын хууль тогтоомж болон төрийн удирдлага, бодлогодоо хүний эрхийг дээдлэх, хамгаалах зарчмыг зайлшгүй баримтлах үүрэг хүлээдэг болов. Онолын түвшинд хүний эрхийг үндсэн эрх, субъектив эрх, жам ёсны эрх, баталгаат эрх гэх мэтээр ангилан авч үздэг боловч ийнхүү ангилахын ач холбогдол нь гагцхүү тэдгээр эрхийг тусгайлан судлах, боловсронгуй болгох, нэгдсэн онолын ойлголтод хүрэх зэрэгтэй л холбоотой болохоос янз бүрийн эрэмбэлэл зэрэг зиндаа тогтоох зорилго агуулдаггүй.

*Үндсэн эрх:* 19 дүгээр зууны дунд үеэс эхлэн дэлхий нийтийн хууль зүйн утга зохиолд, Үндсэн хуульд заасан эрхүүдийг иргэн бүрт олгож буй *үндсэн эрхүүд* гэсэн утгаар нэг мөр ойлгож эхэлсэн юм.[3] Нэг талаас энэ үзэл нь позитив шинжтэй гэж хэлж болохоор байгаа бөгөөд хэрэв тийм бол үндсэн эрхэд хүний болон иргэний эрхүүд аль аль нь багтана. Гэвч хүний зарим эрхүүд, тэр тусмаа заягдмал эрхүүд нь позитив шинжээс ангид бөгөөд эдгээрийг үндсэн эрхэд хамааруулан ойлгосон нь гагцхүү эрх зүйн

[2] Энэ чиглэлээр Ж.Амарсанаа "Үндсэн хуулийн шүүх хүний эрхийг хамгаалах баталгаа мөн".УБ.,2001 он, Ц.Сарантуяа "Үндсэн эрх-шүүх-Үндсэн хуулийн шүүх".УБ.,2001 гэсэн эрдэм шинжилгээний нийтлэлд энэ талаар тодорхой бий.
[3] Й.Изензее, П.Кирхгоф. Государственное право Германии.Т2.М.,1994.стр.167 /дам иш татав/

хамгаалалтын шинжгэй, гэхдээ шууд тодорхойлон хэрэгжүүлэх боломжгүй хэмээгддэг. Зарим ном зохиолд[4] "хүний эрхийг шууд хэрэгжүүлэхэд түүнд тодорхой байх шинж дутдаг, энэ дутагдлаас ангижруулахын тулд *тодорхой байх* шинжийг *олгож* амьдралд хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг төрийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулахыг эрмэлзэж улс орнуудын үндсэн хуулиудаар бэхжүүлдэг байна" гэж тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр үндсэн эрхийг жам ёсны болон позитив эрх, хүний болон иргэний эрхийг багтаасан өргөн хүрээний ойлголт гэж үзэх үндэслэл бий.

*Жам ёсны эрх:* Хүнийг төрөхөд л хамт заядаг, салгаж болшгүй эрхүүд гэж байдаг ба энэ нь хүний оршин байх эсэхтэй нь хамаардаг юм гэж жам ёсны онолчид үздэг. Английн философич Жонн Локк нь жам ёсны эрхэд амьд явах, чөлөөтэй байх, өмчлөх эрхүүд орох бөгөөд эдгээр эрхүүд нь хүний бусад бүх эрхийн үндэс суурь болно гэжээ. Жам ёсны эрхийг тодорхойлох явдал нь янз бүр байдаг ч үндсэн санаа нь эдгээр эрхүүд нь хүнд заягдмал байдлаар хадгалагддаг, төрийн болон эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээнээс үл хамааран орших шинжийг ямагт агуулдаг аж. Зарим онолчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний заягдмал, суурь эрх гэж үздэг нь ч бий.

*Баталгаат эрх:* Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлэгт хүний эрх, эрх чөлөөний бүрэн каталогийг хуульчилсаны дотор мөн бүлгийн 16-р зүйлд Монгол улсын иргэний эдлэх баталгаатай эрх, эрх чөлөөг тодорхойлсон юм.[5] Үндсэн хуулийн 16-р зүйлд: "Монгол улсын иргэн нь дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ" гэж заасан байна. Иргэний баталгаат эрх нь тухайн улсын онцлогоос хамаарч хүний эрхээс гадна иргэний эрхийг багтаасан, эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан байдаг онцлогтой. Нөгөө талаас хүний баталгаат эрхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан, хэн байхаас үл шалтгаалан хүн байхынхаа хувьд эдэлдэг эрхүүдийг /жам ёсны/ ойлгож болох юм.

*Субъектив эрх:* Субъектив эрх буюу хүний хувийн эрх, эрх чөлөө гэдэг нь хүний эрх зүйн этгээд байхынхаа хувьд зайлшгүй эдлэх шаардлагатай / хамгаалагдах шаардлагатай/ эрхүүд юм. Зарим ном, зохиолд[6] хүний хувийн эрхэд Хүний эрхийн түгээмэл тунхаглалд үндэслэн амьд явах эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, эрхээ шүүхээр хамгаалуулах эрх, шашин шүтэх, эс шүтэх эрх /итгэл үнэмшилтэй байх/, чөлөөтэй зорчих эрх, ажил мэргэжлээ сонгох эрхүүдийг хамруулан ойлгожээ.

Энэ жагсаалтад өмчлөх эрхийг нэмж ойлгох бөгөөд ядаж л өөрийн биеэ өмчилж чадахгүй бол чөлөөтэй байх эрх хэрэгжих боломжгүйд хүрнэ.[7] Субъектив эрхийн агуулга нь иргэний болон хүний эрхийг /позитив болон жам ёсны эрхүүд аль аль нь/ багтааж болох бөгөөд тухайн этгээдийн

[4] Й.Ипензее, П.Кирхгоф. Государственное право Германии.Т2.М.,1994.стр.167 /дам ишлэл/

[5] Г.Совд. Монгол улсын Үндсэн хууль, хүний эрх. УБ.,1999 он 41-р тал.

[6] Г.Совд. Монгол улсын Үндсэн хууль, хүний эрх. УБ., 1999 он

[7] Боолын нийгэмд тухайн хүний бие нь өөрийнх нь бус эзнийх нь өмч гэж үздэг байсан бөгөөд энэ утгаараа биеэ өмчлөх гэсэн ойлголтыг ялгасан болно.

нийгмийн болон байгалийн хамаарлын эрхүүдтэй[8] аль алинтай нь холбоотой. Байгалийн хамаарлын эрхүүд нь нэг талаас жам ёсны эрхтэй ижил утгатай бөгөөд хэзээд "төрөөс өмнөх" шинжтэй. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд нийгэм байхгүй байсан ч оршин тогтноход шаардлагатай эрхүүд орно. Ийм эрхүүдийг төрөөс зөвхөн хүлээн зөвшөөрөх замаар хамгаалдаг. Нийгмийн хамаарлын эрхүүдийг дотор нь туйлын ба харьцангуй гэж ангилж болох бөгөөд энэ нь нийгмийн харилцааны субьект байхад зайлшгүй шаардлагатай, хавсарга шинжтэй гэсэн шалгуураар шүүгдэнэ.Хамгаалагдах байдлаар нь субьектив эрх гэдэгт тухайн этгээдийн өөрийнх нь буюу хувийн эрхийг ойлгож бас болно. Манай Үндсэн хуулийн Цэцэд хүний субьектив буюу тухайн этгээдэд халдагдах хувийн эрхийг шууд хамгаалахад нэлээд эргэлзээ бий.

## Хоёр. Хүний субьектив эрхийг Үндсэн хуулийн шүүхэд хангах, хамгаалах асуудал

Хүний эрх нь хамгаалалтын хувьд үргэлж пассив буюу идэвхгүй төлөвт оршдог бөгөөд ямагт хөндлөнгийн этгээдийн оролцоо[9] шаардлагатай байдаг. Ардчилсан дэглэмт улс орон бүр ард түмнийхээ өмнө хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүргийг хүлээдэг бөгөөд энэ үүргээ гүйцэтгэх аргачлал нь салбарын чиглэлтэй бус цогц механизмийн шинжээр илэрдэг. Хүний эрхийг хамгаалах механизм нь эрх зүйн зохицуулалт, нийгмийн сэтгэл зүйн бодлого, төрийн бүтэц зохион байгуулалт, олон улсын харилцаа гэх мэт олон элементээс бүрдэх бөгөөд үүнд эрх зүйн зохицуулалт, хууль зүйн шинжлэх ухааны үр нөлөө голлох ач холбогдолтой. Үндсэн хуульт улс орнуудад Үндсэн хуулийн шүүхийн оролцоо нь хүний эрхийг хамгаалах явдалд онцгой байр суурийг эзэлнэ.

Академич Ж.Амарсанаа "Үндсэн хуулийн шүүх, хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахад хууль тогтоох болон шүүхийн практикийн нэгдлийг хангаж байх ёстой билээ. Энэхүү хоёрдмол чиг үүрэг нь Үндсэн хуулийг хамгаалах болон хүний эрхийг хамгаалах явдал нь салшгүй гэдгийг нотолж байгаа болно"[10] гэсэн байна. *Үндсэн хуульд агуулагдсан бүх л санаа нь[11] үндсэндээ хүний эрхийг л хамгаалахад чиглэсэн ойлголтууд юм. Учир нь дээр дурьдсанчлан төр байгаагийн үндсэн хэрэгцээ нь хүний эрх, эрх чөлөөг батлан хамгаалах явдал мөн бөгөөд төрийн эрх мэдэл хуваарилалт,улс төрийн дэглэм, зарчим зэрэг нь эцэстээ хүний эрхийг хангах механизмыг хүн төрөлхтөн өөрсдийн эрмэлзэл, зөн совингоороо боловсронгуй болгосоор*

[8] Хүний эрхийг нийгмийн хамаарлын болон байгалийн хамаарлын гэж ангилж болох бөгөөд энэ нь хүний нийгмийн, байгалийн харилцаанд оролцохтой холбоотой. Байгалийн хамаарлын гэдэгт жам ёсны буюу тухайн хүнийг материал оршин байхад зайлшгүй шаардлагатай эрхүүдийг ойлгох бол нийгмийн хамаарлын гэдэгт нийгэмлэг шинжтэй буюу нийгмийн харилцаанд субьект байх чадвартай зайлшгүй холбоотой эрхүүд орно. Эрх зүйн философийн үүднээс бол хүний эрх нь зөвхөн нийгэм оршин байгаа нөхцөлд хэрэгжих буюу эрх зүйгээр хамгаалагдах боломжтой бөгөөд нийгмийн харилцаанд оролцох чадвар нь тухайн хүний биологийн чадвартай ч бас холбоотой. Өөрөөр хэлбэл хэрэв хүн амьд явах эрхгүй бол бусад эрхийг эдлэх боломжгүйтэй адилаар томьёо нь: "байгалийн хамаарлын эрх + нийгмийн хамаарлын эрх = хүний эрх" гэсэн байдлаар тодорхойлогдох юм.

[9] Хөндлөнгийн этгээд гэдэгт тухайн эрхийг хэрэгжүүлж, эдлэж буй хүн өөрөө ч хамаарна. Учир нь агуулгын хувьд хүний эрхийг бие даасан байдлаар авч үзэж болно. Хүний эрхийг хангаж хамгаалахад хүн өөрөө чухал үүрэгтэй бөгөөд нэг эрхээ хэрэгжүүлэх замаар нөгөө эрхээ хамгаалж болдог.

[10] Ж.Амарсанаа. Үндсэн хуулийн шүүх хүний эрхийг хамгаалах баталгаа мөн.УБ.,2001 он

[11] Төрийн эрх мэдэл хуваарилалт, хүний үндсэн болон журамт үүрэг гэх мэт.

*ирсэний үр дүн юм.* Манай улсад Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийнЦэц /цаашид Цэц гэнэ/ хэрэгжүүлдэг бөгөөд одоогийн эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалт нь хүний эрх, эрх чөлөөг шууд хамгаалахад бэрхшээл, хүндрэлтэй. *Үндсэн хуулийн шүүхийн үндсэн чиг үүрэг нь нэгдүгээрт: Үндсэн хуулийг хамгаалах, хоёрдугаарт: хүний эрхийг хамгаалах, гэхдээ мөн чанар, үг гарвалыг нь тунгааж үзвэл: нэгдүгээрт: хүний эрхийг хамгаалах, хоёрдугаарт: Үндсэн хуулийг хамгаалах хэмээж болно. Учир нь, Үндсэн хууль байгаагийн гол шалтгаан нь хувь хүний эрхийг бусдаас нь, хоёрдугаарт төрийн эрх мэдэл, дур зоргоос хамгаалах бөгөөд энэ ч утгаараа Үндсэн хууль нь хүний эрхийн хууль зүйн баталгаа болдог гэж хэлж болно. ТовчдооҮндсэн хуулийг хамгаалах нь хүний эрхийн эрх зүйн баталгааг хамгаалж байна гэсэн үг.* Логикийн үүднээс аваад үзвэлҮндсэн хууль хүний эрхийг хамгаалдаг, Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийг хамгаалдаг. Харин төр нь энэ харилцааны босоо нуруу болох бөгөөд төрийн эрх мэдэл нь хэдийгээр хүний эрхийг хамгаалдаг боловч үргэлж өөрийн ашиг сонирхолын үүднээс хүний эрхийг зөрчихийг эрмэлзэж байдаг гэж үзнэ. Хэрэв эдгээр үндэслэлүүдээс дүгнэвэл Үндсэн хуулийн шүүх нь хүний үндсэн эрх, тэр дундаа субъектив эрх, эрх чөлөөг хамгаалахад хамгийн чухал үүрэг бүхий субъект мөн гэж үзэх үндэслэл байна.

*Дээр дурьдсанчилан манай улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийнЦэц явуулдаг бөгөөд одоогийн бүтэц, үйл ажиллагааны хэлбэр нь хүний субъектив эрхийг шууд хамгаалах боломж тун хязгаарлагддаг нь манай эрх зүйн зохицуулалттай холбоотой.* Үндсэн хуулинд заасанаар Цэцийн хянан хэлэлцэх хэргийн харъяалал нь обьектээр болон субъектээр тодорхойлогддог. Үндсэн хуулинд заасанаар:

1. *Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж буй эсэх*

2. *Ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх*

3. *Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх*

4. *Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх*

Эл зохицуулалтаас үзэхэд Монгол улсын Үндсэн хуулийн Цэц нь хүний эрхийг хамгаалах чиг үүргээ дам байдлаар хэрэгжүүлэх л боломжтой. Үүний учир нь Цэц Үндсэн хуулийн хэм хэмжээг хэдийгээр шууд хэрэглэдэг боловч дээрх харьяаллын хязгаарлалтаас болоод үндсэн эрхийн заалтыг тухайн эрх нь зөрчигдөгч иргэн буюу субъектэд хамааралтайгаар хэрэглэх боломжгүйд

байгаа юм. Шууд хэрэгжүүлэх хэлбэр нь хүний үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн талаарх маргааныг /өргөдөл, мэдээлэл[12]/ Цэцийн хуралдаанаар хянан хэлэлцэх явдал юм.Үндсэн хуулийн Цэцийн гишүүн асан профессор Ц.Сарантуяа "Үндсэн хууль, түүнд заасан үндсэн эрхийн талаарх заалтууд нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн шийдвэрийг хязгаарлах хүчин чадалтай байж гэмээж нь, дээрх гурван эрх мэдлийн шийдвэр үндсэн эрхийг зөрчөөгүй байж гэмээж нь, зөрчсөн тохиолдолд Үндсэн хуулийн шүүх түүнийг нь сэргээж чаддаг байж гэмээж нь Үндсэн хууль бүхэлдээ шууд хэрэгждэг, шууд үйлчилдэг эрх зүй болох юм" гэж онцолжээ. *Өнөө цагт иргэд зөвхөн Үндсэн хуульд заасан харъяаллын дагуу, шуудхан хэлбэл өөрт хамаагүй асуудлаар л Цэцэд хандах эрхтэй байгаа нь хүний эрхийг хамгаалах Цэцийн үүргийн хэрэгжилтэнд сурхий хаалт болдог.*[13] Субъектив эрх нь зөрчигдсөн иргэн Цэцэд хандах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь нэг талаас хуулийн хийдэл, нөгөөтэйгүүр манайд Үндсэн хуулийн хяналтыг "хийсвэр /абстракт/ хэлбэрээр явуулж" байгаа гэж нэрлэгдэх нэг үндэс болж байна. Энэ нь хэдий иргэдийн субъектив эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдол байлаа ч Үндсэн хуулийн Цэцийн хянан хэлэлцэх маргааны харъяалалд хамаарахгүй учир түүний гомдлыг гарцаагүй буцаана гэсэн үг. Гэтэл энэ үүднээс нь аваад үзвэл хүний эрхийн хамгаалалтын механизмийн гол хөдөлгүүр нь үүргээ бүрэн гүйцэтгэх боломжгүй байдалд хүрээд байна гэх үндэслэл бүрнээ байна.

## Гурав. Хүний субъектив эрх зөрчигдөх тухай асуудал Монгол улсын эрх зүйн тогтолцоонд

Аливаа асуудлыг шийдвэрлэх арга зам нь түүний уг үндэс, шалтгаан нөхцлийг тодорхойлохоос эхлэнэ. Хүний эрх зөрчигдөх магадлал буюу боломж нь амьдралын аливаа бодит тохиолдол, эрх зүйн фактаас буюу тодорхой төрлийн нийгмийн харилцаанаас үүдэлтэй. Өөрөөр хэлбэл хүний эрхийг зөрчих асуудал нь нийгмийн харилцаа болон эрх зүйн зохицуулалтын огтлолцсон цэг дээрх ойлголт юм. Монгол улсын эрх зүйн тогтолцооноос харахад:

1. Хүний эрх, эрх чөлөө нь Үндсэн хуулинд тусгаагдан баталгаажна

2. Бусад /ердийн/ хуулиудыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн батална

3. Нийгмийн харилцааны /амьдрал дээрх бодит факт/ тодорхой зөрчил үүсэхэд шүүхэд хандана

4. Шүүх ердийн хуулиудыг тайлбарлан хэрэглэнэ

[12] Өргөдөл мэдээлэл гэсний учир нь тухайн иргэн өөрийн эрх ашиг сонирхолтой шууд холбоогүй зүйлийг Цэцэд мэдээлэх замаар буюу иж ёсны сайн үйл хийх байдлаар Үндсэн хуулийн зөрчлийг "мэдээлдэг"-т байгаа бөгөөд хэрэв иргэн өөрийн эрх зөрчигдсөн талаар Цэцэд хандвал "гомдол" гаргах нь зүйтэй болно.

[13] Ц.Сарантуяа.Үндсэн хуулийн шүүх ба захиргааны хэргийн шүүх: Ухаалаг холбоо, харьцуулалт.УБ.,2004 он

5. Хэрэг эцсийн байдлаар шийдвэрлэгдэнэ /дээд шүүхээр/ гэсэн дамжлагатай байна.

Дээрх дамжлагад анализ хийвэл, хүний үндсэн эрх зөрчигдөх боломжтой үе шат нь "нэгдүгээрт: Ердийн хуулиуд батлагдахдаа хүний эрхийг зөрчсөн хэм хэмжээ агуулах, хоёрдугаарт: шүүх ердийнхуулийг буруу тайлбарлан хэрэглэх, эсхүл хүний эрхийг зөрчсөн хуулийг хэрэглэх" болж байна. Эхний тохиолдолд буюу ердийн хуулиуд нь Үндсэн хуульд заасан Үндсэн эрхийг зөрчсөн тохиолдолд Цэц түүнийг харъяалан шийдвэрлэх боломжтой. Харин хоёрдахь тохиолдолд: шүүх хуулийг тайлбарлахдаа хүний Үндсэн эрхийг зөрчсөн шинжтэй буруу тайлбар хийсэн бол түүнийг хянан шийдвэрлэх боломжгүй. Ердийн хуулиуд Үндсэн хууль зөрчсөн тухай хэргийг Цэцээс хянан шийдвэрлэх нь дээр дурдсанаар шууд бус хяналт. Харин шууд хяналтыг хэрэгжүүлэхийн тулд шүүхийн шатанд зөрчигдсөн хүний эрхийн гомдлыг ч мөн хүлээн авч шийдвэрлэдэг байх нь зүйтэй.Үндсэн хуульд заагдсан үндсэн эрх нь зөрчигдсөн тохиолдолд иргэд холбогдох ердийн шүүхэд шийдвэрлүүлсэний дараа шаардлагатай бол Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байх ньҮндсэн хуулийн шүүх нэг талаас үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг шууд хянан шийдвэрлэх, нөгөө талаас шүүх засаглал үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянах боломж нээлттэй болж байна. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын сонгодог хэлбэр нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хамардаг бол манай улсад шүүх эрх мэдлийн шийдвэрийг хянадаггүй.

Хүний субъектив эрх бодит амьдрал дээр зөрчигдөх асуудал бол хэвийн буюу байж болох үзэгдэл бөгөөд гагцхүү үүнээс хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхийн тулд эрх зүйн хамгаалалт, шүүх засаглал оршин тогтнодог гэж үзэж болно. Харин тэрхүү эрх зүйн зохицуулалт, шүүх засаглал нь[14] Үндсэн хуулийн хэм хэмжээ, үзэл баримтлалыг зөрчиж буй эсэхийг зайлшгүй хянах шаардлагатай. Өнөө цагт манай улсын хувьд Үндсэн хуулийн Цэц нь эрх зүйн зохицуулалтыг хянадаг боловч шүүх засаглалыг хянадаггүй ба ердийн шүүхүүд /захиргааны дагнасан шүүх ч мөн хамаарна/ өөрөө өөрийгөө хянах тогтолцоотой байна.

**Дөрөв. Гадаад улсын Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн зохицуулалт**

**<u>Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн шүүх:</u>**

Үндсэн хуулийн шүүхийг Герман улсад 1949 онд буюу Гитлерийн дэглэмийн дараа байгуулсан түүхтэй. ХБНГУ /цаашид Герман гэх/ -н Үндсэн хуулийн шүүх нь 2 сенаттай, сенат бүр 8 гишүүнтэй, мөн 3 танхимтай. Танхим бүр 3 шүүгчтэй. Сенатад 6-аас доошгүй шүүгч бүрдсэн тохиолдолд асуудлыг шийдвэрлэх боломжтой болдог.

Германы Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, эрх хэмжээ, харъяалан шийдвэрлэх асуудлууд:

[14] Үндсэн хуулийн Цэцийг оролцуулалгүйгээр бусад шүүхүүдийг ойлгоно.

- Парламентаас гаргасан хууль, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх
- Холбооны ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх /Холбооны Үндсэн хуульд заасны дагуу Бундестаг эсвэл Бундесрат нь Холбооны Үндсэн хууль эсвэл холбооны өөр нэг хуулийг санаатай зөрчсөн гэж үзвэл Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байна. Парламентын аль нэг аль танхимаас Үндсэн хуулийн шүүхэд хандаж гаргасан дээр хүсэлтийн агуулгад ерөнхийлөгчийг буруутгах үндэслэл хангалттай байгаа тохиолдолд түүнийг холбооны Үндсэн хуулийн шүүх албан тушаалаас нь огцруулах боломжтой хэмээн тооцдог/
- Улс төрийн намуудыг хориглох /тухайн нам, улс төрийн хүчний баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь ХБНГУ-н бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахаар байвал тэдгээр нам, эвслийн үйл ажиллагаанд хориг тавих эрхтэй. Гэхдээ дээрх шийдвэрийг гаргахаас өмнө Үндсэн хуулийн шүүх тухайн нам, эвслээс явуулж буй улс төрийн үйл ажиллагаа болон түүний гишүүдэд ямар нэг байдлаар саад хийх эрхгүй/
- Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарласан буюу зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэх. /Энэ талаарх гомдлыг эхлээд холбогдох ердийн шүүхэд хандаж шийдвэрлүүлсэний дараагаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх нь иргэдэд нээлттэй болдог/
- Холбооны улсын дээд байгууллагаас гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх /үүнд Холбооны ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага болох Бундестаг, Бундесрат, Холбооны засгийн газар зэрэг нь орно/
- Газрын харилцаан дахь Үндсэн хуулийн маргаантай асуудлыг
- Муж улсын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх
- Үндсэн хуулийг тайлбарлах
- Сонгуулийн ажиллагаа Үндсэн хууль нийцсэн эсэх
- Шүүхийн шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх
- Олон улсын гэрээ, конвенц Үндсэн хуульд нийцсэн эсэх
- Төрийн байгууллагын хооронд, эсвэл төрийн байгууллага улс төрийн хүчнүүдийн хооронд үүссэн Үндсэн хуулийн маргаан

Үндсэн хуулийн шүүх тогтоосон хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл хууль тогтоох байгууллага эрх зүйн хэм хэмжээг батлан гаргахдаа Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлсэн эсэх, тэдгээр хууль нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан болон зөрчсөн эсэхэд хяналт тавьдаг.

Аливаа хууль тогтоомж материаллаг талаасаа ч, өөрийн агуулгаараа ч Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагын үүднээс энэхүү хяналтыг хэрэгжүүлдэг. Мөн хэм хэмжээний абстракт хяналтыг ч хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд эрх зүйн тодорхой маргаанаас үл хамаарч Холбооны болон Зөвлөлийн эрх хэмжээ нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, түүнчлэн муж улсын эрх зүй нь Холбооны өөр бусад муж улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

*Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим онцлог:*

Холбооны Үндсэн хуулийн шүүхийн хувьд маргааныг хянан хэлэлцэхдээ юуны түрүүнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг аль сенатаар хэлэлцэх вэ гэдгийг эхлэн шийдвэрлэх нь чухал. Тиймээс энэ асуудлыг сенат бүрээс 3 шүүгч оролцсон тусгай хороогоор хэлэлцээд дүгнэлт гаргаж шийдвэрлэдэг журамтай. Холбооны Үндсэн хуулийн шүүхээр жилд дунджаар 4500 орчим гомдлыг хэлэлцэж шийдвэрлэдэг бөгөөд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан 2500 орчим өргөдөл байдаг гэсэн статистик тоо баримт ч бий. Энэхүү ачааллын учир шалтгааны улмаас танхим байгуулсан ч гэж үздэг. *УХШүүхэд ирж буй нийт өргөдлийн 95 орчим хувь нь иргэдийн үндсэн эрхтэй холбоотой маргаан байдаг, үүнийг танхимаар шийдвэрлэдэг.* Хоёр сенат хамтран маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах нь тун ховор бөгөөд нэгдүгээр сенатын гаргасан шийдвэрийг хоёрдугаар сенат зөвшөөрөөгүй, мөн тухайн сенатын шүүгч хүлээн зөвшөөрөөгүйгээ албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд хоёр сенат хамтран хэлэлцэж тухайн хэргийг шийдвэрлэнэ. Холбооний Үндсэн хуулийн шүүх шийдвэрээ Үндсэн хуулийн нэрийн өмнөөс бус ард түмний нэрийн өмнөөс гаргадаг.[15]

## Дүгнэлт

Орчин үед Үндсэн хуулийн шүүхийн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүргийн шууд хэрэгжилтийг буюу субъектив эрхийг хамгаалахын ач холбогдол нь олон оронд хүлээн зөвшөөрөгдсөн хэвийн үзэгдэл болжээ. Үүнд Австри, Герман, ОХУ, Гүрж зэрэг орнуудыг дурьдаж болно. Судалгааны үр дүнд дараах ерөнхий болон, тусгай дүгнэлтийг хийж байна:

*Ерөнхий дүгнэлт:*

1. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хамгаалах нь төрийн удирдлага, үйл ажиллагааны үндсэн зорилго буюу зарчим байх бөгөөд энэ нь төрийн оршин байгаа учир шалтгаантай холбогдоно. Тиймээс төрийн аль ч үйл ажиллагаанд буюу тухайлбал, хууль тогтоох, хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх бүхий л процесст хүний эрхийг дээдлэх зарчмыг баримтлах шаардлагатай.
2. Хүний эрхийг хамгаалах механизмд Үндсэн хуулийн Цэцийн үүрэг нь

[15] Э.Лхагвасүрэн.Гадаад орнуудын Үндсэн хуулийн шүүх: бүрэлдэхүүн, эрх хэмжээ, онцлог."Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2003-2006 оны дугаарт цуврадаар гарсан нийтлэлийн эмхтгэл хэвлэгдсэн

онцгой ач холбогдолтой бөгөөд энэхүү үүрэг нь шууд болон шууд бусаар хэрэгжих боломжтой. Монгол улсын эрх зүйн зохицуулалтын хувьд шууд хэрэгжүүлэх боломжгүй байгаа нэг нь манай орны эрх зүйн төлөвшил, хүний эрхийн үнэлэмж боловсронгуй бус байгаатай холбоотой.

3. Үндсэн хуулийн Цэцэд хүний субъектив эрхийг шууд хамгаалах арга замыг нээлттэй, боловсронгуй болгох шаардлагатай ба ингэхдээ Үндсэн хуулийн хэм хэмжээг Цэц шууд хэрэглэдэг байхаар хуульчлах нь зүйтэй.

4. Хүний баталгаат эрх, эрх чөлөөг хийсвэр аргаар биш амьдралын бодит тохиолдолд үндэслэн хамгаалдаг болох ба ингэхдээ бусад шүүхүүдийн шийдвэрийг Үндсэн эрхийн хүрээнд хянадаг болох нь зохистой байна.

*Тусгай дүгнэлт:*

Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн үйл ажиллагаанд хүний субъектив эрхийг хамгаалах үүргийг боловсронгуй болгохын тулд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна:

1. Захиргааны дагнасан болон ердийн шүүхүүдэд хүний субъектив эрхийг зөрчсөн эсэх талаар гомдлыг хүлээн авдаг болохын тулд Үндсэн хуулийн 66-р зүйлийн 1, 2-р хэсэгт нэмэлт оруулах. /...өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу../ /...шүүх нь хууль хэрэглэх, тайлбарлах явцдаа Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн бол.../

2. Үндсэн хуулийн Цэцэд хүний субъектив эрхийг зөрчсөн талаарх гомдлыг хүлээн авч, харъяалан шийдвэрлэдэг байх. Ингэхдээ салбар хуулиудын зүйл заалтаар зохицуулагддаг ч гэсэн Үндсэн хуулийн баталгаат эрхүүдийн мөн чанарыг Цэцийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтуудад хамааруулан тодорхой томъёолж өгөх./Мөн Үндсэн хуулийн 66-р зүйлд нэмэлт оруулах/

3. Үндсэн хуулиар баталгаажсан хувь хүний субъектив эрхийн тухай онол, арга зүйн судалгаа, томъёоллыг илүү үйлчлэл, үр нөлөөтэй болгох.

4. Үндсэн хууль болоод салбар хуулиудын хүрээнд хүний субъектив эрхийн хамгаалалтын уялдаа холбоог гаргаж тавих чиглэлээр судалгааны ажлыг эрчимжүүлэх. Ялангуяа харьцуулсан судлалын хүрээнд ихээхэн зүйл хийх шаардлагатай байна.

5. Үндсэн хуулийн Цэцэд хүний субъектив эрхийг хамгаалах эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлэхийн тулд Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтаас гадна, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай багц хуулиудын болон шаардлагатай бусад хуулиудын холбогдох зүйл, заалтуудад зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулж өгөх нь зүйтэй.

# МЭДЭЭ
# УЛСЫН ИХ ХУРЛЫН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ХҮРТЭВ



Нэрт хуульч Б.Чимидийн нэрэмжит шагнал бий болгох журмыг Улсын Их Хурлын даргын 2014 оны арванхоёрдугаар сарын 18-ны өдрийн 176 тоот Захирамжаар баталжээ. Энэ журам батлагдсанаар Монгол төрийн нэрт зүтгэлтэн, Ардчилсан шинэ Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч Бяраагийн Чимидийн Монгол төрд зүтгэсэн гавьяа зүтгэлийг мөнхжүүлэх, судалгаа шинжилгээнд суурилсан хууль тогтоох ажиллагааг хөгжүүлэх, парламент судлал, үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр гарсан үнэ цэнэтэй томоохон бүтээлийг хөхиүлэн дэмжих, энэ чиглэлийн эрдэм судлалын ажилд оюун ухаанаа зориулах эрдэмтэн, судлаачдын тоог нэмэгдүүлэх зорилготой.

Монгол Улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 23 жилийн ойн өдрийг тохиолдуулан нэрт хуульч Б.Чимид агсны нэрэмжит анхны шагналыг хэний ямар бүтээлд олгох сонгон шалгаруулалтыг эрдэмтдийн баг, Улсын Их Хурлын даргын зөвлөлийн гишүүд шагналд нэр дэвшсэн 6 бүтээлээс тунгаан шүүж, Улсын Их хурлын гишүүн, Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Шихихутуг ХЗДС-ийн зөвлөх багш Д.Лүндээжанцангийн "Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт" бүтээлд олгохоор шийдвэрлэжээ. Ийнхүү Улсын Их Хурлын нэр хүндтэй анхны шагналыг Д.Лүндээжанцан профессор хүртэв. Тэрээр "Би их азтай хүн. 1975 онд Б.Чимид багш анх Шүүх прокурорын зохион байгуулалт гэдэг хичээл орсноос хойш дөрвөн жил хичээл заалгаж гарынх нь шавь болсон. Миний 40 жилийн хөдөлмөр 20 гаруй ном байна. Тэр дотроос "Төрийн эрх мэдлийн хуваарилалт" ном маань шагнал хүртсэнд баяртай байна. Б.Чимид багшаар хичээлийг нь заалгаад, хамтарч ажиллаад, эрдмийнхээ ажлыг удирдуулж байлаа. Нэг үгээр хэлбэл, багшийнхаа заавраар, багшийнхаа өвд тулгуурлаж бичсэн номоороо өөрийнх нь нэрэмжит шагналыг авлаа. Багшийнхаа нэрэмжит анхны шагналын эзэн болсон би их азтай хүн юм" хэмээн өгүүлсэн байна.

# ШИНЭ НОМЫН МЭДЭЭ




Данзангийн Лүндээжанцан профессор "Монгол Улс дах төрийн эрх мэдлийн хуваарилалт" номоо шинэчлэн баяжуулж 10 гаруй жилийн дараа дахин хэвлүүлж байна.

Д.Лүндээжанцан профессор: "Би бээр 2001 онд бичиж хэвлүүлсэн "Монгол Улс дах төрийн эрх мэдлийн хуваарилалтын онол, практикийн асуудал" бүтээл дээрээ тухайн онол үзэл баримтлал монголын хөрс шороонд хэрхэн соёолж буй, учирч буй хүндрэл бэрхшээл, саад тотгор тэдгээрийн учир шалтгааны тухайд сүүлийн 10 гаруй жилд хийсэн ажиглалт судалгааныхаа үр дүнд хүрсэн санаа бодлоо шингээсэн нэгэн шинэ бүлгийг нэмж байгаа юм. Би шинэ онол, сургаал тавих гээгүй. Төрийн эрх мэдэл хуваарилах онол АНУ, Франц, Их Британи зэрэг ардчиллын өлгий орнуудад хэрэгжиж эхлэнээр хэдэн зууныг өнгөрөөсөн боловч хүний эрх, эрх чөлөөний баталгаа болох мөн чанар нь өөрчлөгдсөнгүй. Харин улс төр, эрх зүйн сэтгэлгээний энэхүү маргашгүй үнэт зүйл дэлхийн ардчилсан их, бага улс гүрэн бүрийн өнцлог, түүхэн цагийн хэлхээнд өөр өөр нөхцөлд хэрэгжих агуулга нь баяжиж дэлгэрсээр авай" гэжээ.

Номын агуулгын эдүгээчлэл үүгээр хязгаарлагдахгүй бөгөөд номын бүлэг бүлгэнд шинэчлэл, ялангуяа эрх мэдлийн салбар (мөчир) хоорондын харилцааны хөгжлийн чиг хандлага, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн төлөвшлийн асуудлаар шинэ санаа, үзэл бодол шингээстэйг уншигч абугай болгоох бөлгөө. Шинэчлэгдсэн бүтээл анхны эх бүтээл шигээ эрдэмтэн судлаачид, улс төрчид, их, дээд сургуулийн багш, суралцагсад, эрдэм номын хүмүүсийн оюуны эрэлт хэрэгцээ, таашаалд нийцсэн бүтээл болсонд эргэлзэхгүй байна.




Бид 1998 онд хэвлүүлсэн "Эрх зүйн философи" номоо дахин хэвлүүлж байна. Үүний учрыг нэгд, ном маань эдэлгээнд нухлагдаж ихэд хуучирч ховордсон, хоёрт, номоо эрх зүйн онолын үндсэн асуудлын нэгэн болох эрх зүйн онотолги буюу эрх зүйн ахуй, хүний ахуйн мөн чанар, тэдгээрийн уялдаа холбоо, эрх зүйн ухамсар, эрх зүйн соёлын онол, арга зүйн асуудлаар сэлбэн баяжуулах шаардлага байсантай холбон тайлбарлах байна. Мөн монголчуудын эрх зүйн сэтгэлгээний үнэт зүйлсийг өрнө, дорнын эрх зүйн гүн ухааны гол онол, арга зүйн харьцуулалтын хүрээнд авч үзэж шинэ бүлгээр баяжуулав.

Энэхүү сурах бичигт нийгэм, гүн ухааны сэтгэлгээний бие даасан салбар болох эрх зүйн философийн тулгуур ухагдахуун, ойлголтууд, үүсэл, төлөвшил, хөгжлийн үндсэн үе шат, урсгал чиглэлүүд, үндэсний эрх зүйн философи сэтгэлгээний уламжлал, шинэчлэлийн гол асуудлыг тусгахыг оролдов.

Сурах бичгийг их, дээд сургуулиудын гүн ухаан, эрх зүй, хуулийн мэргэжлээр суралцаж буй оюутан болон мэргэжлийн багш, эрдэм шинжилгээний ажилтан нарт гарын авлага болгох зорилгоор бүтээсэн болно. Бид сурах бичгээ уншигч, хэрэглэгч олон хүнээс ирүүлсэн санал, зөвлөмжид тулгуурлан шинэчлэхийг зорьсон билээ. Эрх зүйн философи гэдэг хичээл монгол улсын их, дээд сургуулиудын нийгмийн ухааны сургалт судалгааны өнөр бүлд байр суурина төвөхнүүлсээр, танин мэдэхүйн үйл явц лавширсаар авай. Учир иймд суралцах бичигт бүтэц, агуулга, арга зүйн хувьд учир дутагдалтай, профессор багш, оюутан абугай нарын хэрэгцээ шаардлагыг хангахгүй зүйл буйг үгүйсгэх аргагүй.

Сурах бичгийн талаарх санал зөвлөмжийг бид ихэд анхааран үзэж, цаашид сайжруулахад хүчин зүтгэхээ илэрхийлж байна. Зохиогчид

# ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН МЭДЭЭ:



"Зах зээлийн эдийн засгийн эрх зүйн зохицуулалт дахь ашиг сонирхлуудын солбицол, түүний үр дагавар" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын мэдээ

Шихихутуг ХЗДС-ийн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг олон улсын эрдэм шинжилгээний ээлжит бага хурал 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Олон улсын бага хурал нь сургалт-судалгааны төв болох сургуулийн стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд тодорхой бодит алхам болохын зэрэгцээгээр хурлын илтгэлүүдээр эмхтгэл эрхлэн гаргаг нь сургалт, судалгааны ажил эрхэлдэг байгууллага, багш, судлаач нарт ихээхэн түшиц болдог юм.

"Зах зээлийн эдийн засгийн эрх зүйн зохицуулалт дахь ашиг сонирхлуудын солбицол, түүний үр дагавар" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлаар дараах илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Үүнд:

1. МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАНГИЛАА АСУУДЛУУД: ЭРХ ЗҮЙН АСПЕКТ

Р.Амаржаргал - Монгол Улсын Их хурлын гишүүн

2. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ч.Нямсүрэн - Улсын дээд шүүхийн тамгын газрын Шүүхийн практик судлах хэлтсийн дарга, Хууль зүйн ухааны доктор

Б.Ганпүрэв - Шихихутуг ХЗДС-ийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхмийн багш, докторант

3. МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД: ЭРСДЭЛИЙН АСПЕКТ

Ч.Норовдондог - УИХ-ын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, доктор

4. ОРОС ОРОН ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГ: ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГУУД

Койсин, А.А - Эрхүүгийн УИС-ийн Хуулийн сургуулийн эрүүгийн эрх зүйн тэнхмийн ахлах багш, өмгөөлөгч

5. ЭДИЙН ЗАСАГТ ХАМААРАХ, ЭС ХАМААРАХ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Г.Амаржаргалан - Шихихутуг ХЗДС-ийн салбар эрх зүйн тэнхмийн эрхлэгч, ахлах багш

6. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААРХИ КЕЙС СУДАЛГАА /ЭСТОНИ/

Давид коллер - Бүгд найрамдах Солонгос Улсын Хандуны Олон Улсын Хууль зүйн сургуулийн профессор

7. ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮЗЭЛ ХАНДЛАГА

Д.Батжаргал - СЭЗДС-ийн дэд захирал, доктор /Ph.D/

С.Батбуян - СЭЗДС-ийн багш, докторант

8. ГЕОПОЛИТИКИЙН ОГТЛОЛЦОЛД ОРШИХ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Д.Даваасамбуу - Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд

9. ОЛИГАРХИ АШИГ СОНИРХЛЫН ЭРХ ЗҮЙН ХЯЗГААРЛАЛТ

Н.Дашзэвэг - Эдийн засагч

10. ШУДАРГА, ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

Ш.Цогтоо - Үндсэн хуулийн цэцийн гишүүн, МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор

11. СҮҮДРИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ХУМИХ АСУУДАЛД

Б.Баттөмөр - «Ойн бирж» ХХК-ийн захирал, доктор /Sc.D/

12. ЭРДЭС БАЯЛГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТВОРТОЙ ОРЧИН БОЛ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭС БОЛОХ НЬ

Н.Алгаа - Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал

13. ӨМЧЛӨХ ЭРХ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНДСЭН АСУУДАЛ МӨН

П.Түвшинтөгс - Шихихутуг ХЗДС-ийн Салбар эрх зүйн тэнхмийн багш, докторант

14. МОНГОЛ УЛС НУТАГ БЭЛЧЭЭРИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

М.Сувд - Отгонтэнгэр их сургуулийн багш, докторант

15. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ШУДАРГА ШҮҮХЭЭР ХАМГААЛАХ НЬ

Ж.Бямбаа - Шихихутуг ХЗДС-ийн төр, эрх зүйн онол, түүхийн тэнхмийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/, профессор

16. ЁС ЗҮЙ -СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Шакли Ф. Рафетто - АНУ-ын Усан Цэргийн Бэлтгэл Капитан, Шүүгч асан

17. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫГ ИЛ ТОД БОЛГОЖ, УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Д.Батзориг - Тахарын Ерөнхий газрын дэд дарга, доктор /Ph.D/

# ХУУЛЬЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮН

Хуульчийн мэргэжлийн шалгалт 2014 оны 11 дүгээр сарын 11, 12, 13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөсөн бөгөөд хуульчийн шалгалтанд оролцсон эрх зүйчдээс шалгалтанд тэнцсэн эрх зүйчдийн үзүүлэлтээр 38.7 хувиар Шихихутуг ХЗДС-ийн төгсөгчид хоёрдугаар байрт шалгарсан байна.



# ЭЛСЭГЧДЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Хууль зүйн их, дээд сургуулиудаас анхлан "эрх зүйч" мэргэжлийн БАКАЛАВРЫН хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн, монгол төрийн их заргач Шихихутугаар овоглосон эрдмийн их өргөөнд та бүхнийг элсэн суралцахыг урьж байна.

ХБНГУ-ын Соёлын сайд нарын бага хурал (ССНБХ)-ын дэргэдэх Гадаад орнуудын боловсролын асуудал эрхэлсэн төв зөвлөлийн 2008 оны 04-р сарын 07-ны өдрийн шийдвэрээр Шихихутуг ХЗДС-ийн төгсөгчид болон оюутнууд Герман Улсын их, дээд сургуульд элсэн суралцах эрх нь нээгдсэн.

2015-2016 оны хичээлийн жилд Шихихутуг ХЗДС-д оюутан элсүүлэх хөтөлбөр

| индекс | Элсэлт авах хөтөлбөр | Нарийвчилсан чиглэл | Суралцах хэлбэр | Суралцах хугацаа | Өгөх шалгалт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улаанбаатар хотоос элсэгчид | Аймаг, орон нутгаас элсэгчид |
| **042101** | Эрх зүйч | Төр, захиргааны эрх зүй | өдөр | **4** | Нийгмийн тухай мэдлэг **/100%/** | Нийгмийн тухай мэдлэг **/70%/, математик /30%/** |
| | | Иргэн, бизнесийн эрх зүй | өдөр | **4** | | |
| | | Эрүүгийн эрх зүй | өдөр | **4** | | |

**Бакалаврын зэрэг олгох өдрийн хөтөлбөрт элсэгчдэд тавигдах шаардлага**

- Бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн байна.
- Бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөрт шаардлагатай хичээлээр 2014 эсвэл 2015 онд ерөнхий шалгалт өгсөн байна.
- Ерөнхий шалгалтын нийт онооны 50-иас дээш хувийг авсан тохиолдолд бүртгүүлэх эрх нээгдэнэ.

Тус сургуульд босго оноог хангасан бүртгүүлэгчдээс шалгаруулалт хийхдээ нийгмийн тухай мэдлэгийн хичээлийн ерөнхий шалгалтын оноон дээр боловсролын гэрчилгээний дундаж оноог нэмж, онооны жагсаалт хийнэ.

Бүртгэлийг 7-р сарын 01-нээс 7-р сарын 9-нийг дуустал явуулж, онооны жагсаалтыг 7-р сарын 10-ны өдөр гаргана.

Тэнцсэн элсэгчдийн нэрсийн жагсаалтыг Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн хичээлийн байранд болон веб сайтад /www.shihihutug.edu.mn/ тавьж нийтэд мэдээлнэ.

Тухайн жилийн нийгмийн тухай мэдлэгийн болон математикийн улс, аймаг, хот, дүүргийн олимпиадад эхний 10 байрт шалгарсан сурагчийг нотлох баримтыг үндэслэн онооны дараалал харгалзахгүй шууд элсүүлнэ.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

1. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах бичиг баримт /нотариатаар батлуулсан хуулбар/
2. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, хуулбарын хамт
3. Ерөнхий шалгалтын батламж, хуулбарын хамт
4. Чээж зураг 2 хувь /сүүлийн 3 сард авахуулсан/
5. Бүртгэлийн хураамж

Аймаг, орон нутгаас элсэлт авахдаа "Аймаг, орон нутгаас монголын их, дээд сургуулиудын консорциум/МИДСК/-ын гишүүн их, дээд сургууль, коллежид оюутан элсүүлэх журам"-ыг баримтлан МИДСК-ын элсэлтийн комисс зохион байгуулна.

ХАЯГ: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,6-р хороо, Их сургуулийн гудамж-1, Монгол-Япон төвийн ард,шуудангийн хайрцаг-1033,

И-мэйл хаяг: info@shihihutug.edu.mn, shihihutughzds@gmail.com

Вэб сайт: http://www.shihihutug.edu.mn

Утас:323392, 320176, 320812, 99182624, 99027676, 99892524

Факс: +976-11-323392, +976-11-318712